

**ТАТВАРЫН СУУРИЙГ БАГАСГАХ, АШИГ ШИЛЖҮҮЛЭХ ЯВДЛААС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ ЗОРИЛГООР ТАТВАРЫН ГЭРЭЭТЭЙ ХОЛБООТОЙ АРГА
ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТУХАЙ ОЛОН ТАЛТ КОНВЕНЦ**

Энэ конвенцод Оролцогч талууд нь,

Татваргүй, эсхүл татварын хувь, хэмжээ багатай газруудад ашгийг зохиомлоор шилжүүлэх олон улсын татварын түрэмгий төлөвлөлтийн улмаас Засгийн газрууд үлэмж хэмжээний аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого алдаж байгааг хүлээн зөвшөөрч;

Татварын суурийг багасгах, ашиг шилжүүлэх явдал (цаашид "BEPS" гэх) нь зөвхөн аж үйлдвэржсэн улсуудын хувьд төдийгүй, хурдацтай өсөж буй эдийн засаг, хөгжиж буй улсуудын хувьд ч хойшлуулшгүй асуудал гэдгийг анхааран үзэж;

Нэмүү өртөг бий болгож буй болон ашиг олох зорилгоор бодит эдийн засгийн үйл ажиллагаа явагдаж буй газарт татвар ногдуулахын чухлыг хүлээн зөвшөөрч;

ЭЗХАХБ/Их20-ын BEPS төсөл (цаашид "BEPS-ийн багц" гэх)-ийн хүрээнд боловсруулсан багц арга хэмжээг сайшааж;

BEPS-ийн багцад татварын зохицуулалтын зөрүүг урвуулан ашиглах асуудлыг шийдвэрлэх, гэрээг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх, төлөөний газар үүсгэхээс хиймлээр зайлсхийхийн эсрэг болон маргаан шийдвэрлэх үйл ажиллагааг сайжруулах зэрэг татварын гэрээтэй холбоотой арга хэмжээг багтаасан байгааг тэмдэглэж;

Олон талт хамтын ажиллагааны хүрээнд татварын гэрээтэй холбоотой BEPS-ийн арга хэмжээнүүдийг түргэн шуурхай, уялдаатай, нэгдсэн байдлаар хэрэгжүүлэх шаардлага байгааг ухамсарлаж;

Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй давхар татварын гэрээнд хамаарах татварыг давхардуулан ногдуулахгүй байх нөхцөлийг хангахаас гадна татвараас зугтах, зайлсхийх замаар татвар ногдуулахгүй байх, эсхүл татварын ногдлыг бууруулах (Гуравдагч талын оршин суугч этгээдэд шууд бус ашиг бий болгох зорилгоор гэрээг урвуулан ашиглах явдлыг оролцуулан) боломжийг үүсгэхгүй байх шаардлага байгааг тэмдэглэж;

Харилцан тохиролцсон өөрчлөлтүүдийг одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй орлогын татварыг давхардуулан ногдуулахаас зайлсхийх гэрээнүүдийн сүлжээнд бүхэлд нь харилцан уялдаатай, үр ашигтай хэрэгжүүлэхэд эдгээр гэрээ тус бүрийг дахин зөвшилцөх, хоёр талт хэлэлцээ хийх шаардлага үүсгэхгүйгээр үр дүнтэй механизм бий болгох хэрэгцээ байгааг хүлээн зөвшөөрч;

Дараах зүйлийг хэлэлцэн тохиролцов:

Монгол Улсын Гадаад харилцааны яам
АЛБАН ЕСНЫ ОРЧУУЛГА МЭН

Гарын үсэг /Signature/  1

2023 оны 10 сарын 16 өдөр
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs of Mongolia
OFFICIAL TRANSLATION

1 ДҮГЭЭР БҮЛЭГ

ХАМРАХ ХҮРЭЭ БА НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

1 дүгээр зүйл

Конвенцын хамрах хүрээ

Энэхүү конвенц нь 2 дугаар зүйл (Нэр томьёоны тодорхойлолт)-ийн 1 дүгээр хэсгийн а) заалтад тодорхойлсны дагуу бүх Хамаарах татварын гэрээг өөрчилнө.

2 дугаар зүйл

Нэр томьёоны тодорхойлолт

1. Энэхүү конвенцын зорилгоор дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

а) "Хамаарах татварын гэрээ" гэж орлогын албан татварын давхардлыг арилгах зорилготой гэрээг (бусад төрлийн татваруудыг хамааруулсан эсэхээс үл хамааран):

i) Гэрээ нь хоёр, эсхүл түүнээс дээш этгээдүүдийн хооронд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа:

A) Энэхүү конвенцын Оролцогч талууд; ба/эсхүл

B) Дээр дурдсан гэрээний талууд бөгөөд тэдгээрийн олон улсын харилцааг нь энэхүү конвенцын аль нэг Оролцогч тал хариуцдаг улс, эсхүл нутаг дэвсгэр; мөн

ii) Энэхүү конвенцын Оролцогч тал тус бүрийн хадгалагчид хүргүүлсэн мэдэгдэлд дурдсан энэ конвенцод хамааруулахыг хүссэн татварын гэрээнүүд, мөн холбогдох аливаа нэмэлт, өөрчлөлт болон дагалдах баримт бичгүүдийг (Үүнд: гэрээний нэр, гэрээний талуудын нэр, гарын үсэг зурсан огноо болон шаардлагатай тохиолдолд уг мэдэгдлийг гаргах үед хүчин төгөлдөр болсон огноо);

b) "Оролцогч тал" гэж:

i) Энэхүү конвенцын 34 дүгээр зүйл (Хүчин төгөлдөр болох)-ийн дагуу энэ конвенц хүчин төгөлдөр үйлчилж байгаа Улсыг, эсхүл



ii) Энэхүү конвенцын 27 дугаар зүйл (Гарын үсэг зурах, соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, эсхүл батлах)-ийн 1 дэх хэсгийн b), эсхүл c) -д заасны дагуу гарын үсэг зурсан болон 34 дүгээр зүйл (Хүчин төгөлдөр болох)-ийн дагуу энэхүү конвенц хүчин төгөлдөр үйлчилж буй нутаг дэвсгэрийг хэлнэ.

c) "Хэлэлцэн тохирогч улс" гэж энэхүү конвенцод хамаарах аль нэг татварын гэрээний аль нэг талыг хэлнэ.

d) "Гарын үсэг зурсан тал" гэж энэ конвенцод гарын үсэг зурсан боловч конвенц хараахан хүчин төгөлдөр болоогүй байгаа улс, эсхүл нутаг дэвсгэрийг хэлнэ.

2. Оролцогч тал энэхүү конвенцыг хэрэглэх бүрдээ энэ конвенцод тодорхойлоогүй аливаа нэр томъёог тухайн хугацаанд энэхүү конвенцод хамаарах холбогдох татварын гэрээнд заасны дагуу ойлгоно.

2 ДУГААР БҮЛЭГ

ТАТВАРЫН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗӨРҮҮ

3 дугаар зүйл


Ил тод этгээдүүд

1. Хамаарах татварын гэрээний хувьд аль нэг Хэлэлцэн тохирогч улсын татварын хуулийн дагуу санхүүгийн хувьд бүхэлдээ, эсхүл хэсэгчлэн ил тод гэж тооцогдох этгээд, эсхүл зохион байгуулалтын олсон, эсхүл түүгээр дамжуулан бий болсон орлогыг зөвхөн уг орлогын хүрээнд тухайн Хэлэлцэн тохирогч улс татвар ногдуулах зорилгоор өөрийн оршин суугчийн орлого гэж үзнэ.

2. Аль нэг Хэлэлцэн тохирогч улсын оршин суугчийн олсон орлогод нөгөө Хэлэлцэн тохирогч улсад татвар ногдуулах боломжтой бөгөөд үүнтэй холбогдуулан эхний улс нь уг орлогыг албан татвараас чөлөөлөх, хөнгөлөх, эсхүл төлсөн татвартай тэнцэх хэмжээгээр бууруулахтай холбоотой Хамаарах татварын гэрээний зохицуулалт нь зөвхөн уг орлого нь нөгөө Хэлэлцэн тохирогч улсын оршин суугчийн олсон орлого гэж үзэж нөгөө Хэлэлцэн тохирогч улс татвар ногдуулах боломжийг бий болгож байгаа гэсэн үндэслэлээр хязгаарлагдан үйлчлэхгүй.

3. Энэхүү конвенцын 11 дүгээр зүйл (Өөрийн оршин суугчид татвар ногдуулах аль нэг Оролцогч талын эрхийг хязгаарласан татварын гэрээг хэрэглэх)-ийн 3 дахь хэсгийн а) -гийн дагуу нэг буюу түүнээс дээш Оролцогч тал тайлбар хийсэн Хамаарах татварын гэрээний хувьд 1 дэх хэсгийн төгсгөлд дараах өгүүлбэрийг нэмж оруулна:

"Энэхүү заалтыг ямар ч тохиолдолд аль нэг Хэлэлцэн тохирогч улсын өөрийн оршин суугчдад татвар ногдуулах эрхийг хөндөх байдлаар тайлбарлахгүй."



4. Энэ зүйлийн 1 дэх хэсгийг (3 дахь хэсэгт заасны дагуу өөрчлөлт оруулж болно) аль нэг Хэлэлцэн тохирогч улсын татварын хуулийн дагуу санхүүгийн хувьд ил тод гэж тооцогдох (ерөнхий дүрмийн дагуу, эсхүл тодорхой баримт нотолгоо, аж ахуйн нэгж, эсхүл бусад зохион байгуулалтын төрлийг нарийвчлан тодорхойлох замаар тогтоосон) аж ахуйн нэгж, эсхүл бусад хэлбэрийн зохион байгуулалтын орлого, эсхүл түүгээр дамжуулан олсон орлогыг Хэлэлцэн тохирогч улсын оршин суугчийн олсон орлого гэж тооцох эсэхийг авч үзэж буй Хамаарах татварын гэрээний зохицуулалтуудын оронд, эсхүл ийм зохицуулалт байхгүй тохиолдолд хэрэглэнэ.

5. Аль нэг Оролцогч тал дараах тайлбар хийх эрхтэй:

a) Энэ зүйлийг бүхэлд нь өөрийн Хамаарах татварын гэрээнд хэрэглэхгүй;

b) Энэ зүйлийн 1 дэх хэсгийг 4 дэх хэсэгт заасан зохицуулалтыг агуулсан өөрийн Хамаарах татварын гэрээнд хэрэглэхгүй;

c) Энэ зүйлийн 1 дэх хэсгийг гуравдагч улсад үүсгэн байгуулагдсан этгээд, эсхүл зохион байгуулалтын олсон, эсхүл түүгээр дамжсан орлогын хувьд гэрээний давуу талыг олгохгүй байх зохицуулалт бүхий энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасныг агуулсан өөрийн Хамаарах татварын гэрээнд хэрэглэхгүй;


d) Энэ зүйлийн 1 дэх хэсгийг этгээд, эсхүл зохион байгуулалтын төрлүүд зэрэг тодорхой нөхцөл байдлыг журамласан дэлгэрэнгүй зохицуулалт бүхий энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасныг агуулсан өөрийн Хамаарах татварын гэрээнд хэрэглэхгүй;

e) Энэ зүйлийн 1 дэх хэсгийг гуравдагч улсад үүсгэн байгуулагдсан этгээд, эсхүл зохион байгуулалтын олсон, эсхүл түүгээр дамжсан орлогын хувьд гэрээний давуу талыг олгохгүй байх бөгөөд этгээд, эсхүл зохион байгуулалтын төрлүүд зэрэг тодорхой нөхцөл байдлыг журамласан дэлгэрэнгүй зохицуулалт бүхий энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасныг агуулсан өөрийн Хамаарах татварын гэрээнд хэрэглэхгүй;

f) Энэ зүйлийн 2 дахь хэсгийг өөрийн Хамаарах татварын гэрээнд хэрэглэхгүй;

g) Энэ зүйлийн 1 дэх хэсгийг этгээд, эсхүл зохион байгуулалтын төрлүүд зэрэг тодорхой нөхцөл байдлыг журамласан дэлгэрэнгүй зохицуулалт бүхий энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасныг агуулсан өөрийн Хамаарах татварын гэрээнд зөвхөн хэрэглэх.

6. Энэ зүйлийн 5 дахь хэсгийн a) эсхүл b)-д заасны дагуу тайлбар хийгээгүй аливаа Оролцогч тал нь энэ зүйлийн 5 дахь хэсгийн c)-гээс d) хүртэлх тайлбарт өөрийн Хамаарах татварын гэрээ хамаарахгүй бөгөөд энэ зүйлийн 4 дэх хэсэгт



заасныг агуулсан эсэхийг хадгалагчид мэдэгдэх ба агуулсан тохиолдолд тухайн зохицуулалтын зүйл, заалтын дугаарыг мэдэгдэнэ.

Аль нэг Оролцогч тал нь энэ зүйлийн 5 дахь хэсгийн г)-д заасны дагуу тайлбар хийсэн бол өмнөх өгүүлбэрт дурдсан мэдэгдэл нь зөвхөн тухайн тайлбар үйлчлэх Хамаарах татварын гэрээгээр хязгаарлагдана.

Аль нэг Хамаарах татварын гэрээний бүх Хэлэлцэн тохирогч улс тухайн Хамаарах татварын гэрээний аливаа зохицуулалттай холбоотой ийнхүү мэдэгдэл гаргасан бол уг зохицуулалтыг энэ зүйлийн 4 дэх хэсэгт тодорхойлсон хүрээнд энэ зүйлийн 1 дэх хэсгийн (үүнийг 3 дахь хэсгээр өөрчилсөн байж болно) зохицуулалтаар солино.

Бусад тохиолдолд, Хамаарах гэрээний зохицуулалт энэ зүйлийн 1 дэх хэсэг (үүнийг 3 дахь хэсгээр өөрчилсөн байж болно)-тэй зөрчилдсөн тохиолдолд энэ зүйлийг 1 дэх хэсгийг хэрэглэнэ.

4 дүгээр зүйл

Байнга оршин суугчийн давхар харьяалалтай этгээдүүд

1. Аль нэг Хамаарах татварын гэрээний улмаас аливаа хувь хүнээс бусад этгээд нь нэгээс дээш Хэлэлцэн тохирогч улсын оршин суугч байх тохиолдолд Хэлэлцэн тохирогч улсуудын эрх бүхий байгууллагууд харилцан тохиролцох замаар Хэлэлцэн тохирогч аль улсын оршин суугч болохыг тодорхойлохыг эрмэлзэнэ. Ингэхдээ тухайн этгээдийн удирдлага байршиж буй газар, үүсгэн байгуулагдсан, эсхүл бусад аливаа хэлбэрээр байгуулагдсан газар, болон холбогдох бусад аливаа хүчин зүйлийг харгалзан үзнэ.

Хэлэлцэн тохирогч улсуудын эрх бүхий байгууллагууд харилцан тохиролцсноос бусад тохиолдолд тухайн этгээд нь тухайн Хамаарах татварын гэрээнд заасан аливаа татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэхгүй.

2. Нэгээс дээш Хэлэлцэн тохирогч улсын байнгын оршин суугч хувь хүн бус этгээдийг Хэлэлцэн тохирогч аль улсын оршин суугч болохыг тодорхойлох журмыг агуулсан Хамаарах татварын гэрээний зохицуулалтын оронд, эсхүл ийм зохицуулалт байхгүй тохиолдолд энэ зүйлийн 1 дэх хэсгийг хэрэглэнэ.

Харин энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан нь давхар бүртгэлтэй компанийн зохион байгуулалтын бүтцэд хамаарах аж ажуйн нэгжийн оршин суух харьяаллыг тусгайлан зохицуулсан Хамаарах татварын гэрээнд үйлчлэхгүй.

3. Аль нэг Оролцогч улс дараах тайлбар хийх эрхтэй:

а) Энэхүү зүйлийг бүхэлд нь өөрийн Хамаарах татварын гэрээнд хэрэглэхгүй;

б) Энэхүү зүйлийг бүхэлд нь аливаа хувь хүнээс бусад этгээд нэгээс дээш Хэлэлцэн тохирогч улсын оршин суугч байх тохиолдолд Хэлэлцэн тохирогч



улсуудын эрх бүхий байгууллагууд харилцан тохиролцох замаар аль нэг Хэлэлцэн тохирогч улсын оршин суугчаар тодорхойлохоор хүчин чармайлт гаргах үүрэг Хэлэлцэн тохирогч талуудад хүлээлгэсэн зохицуулалт бүхий өөрийн Хамаарах татварын гэрээнд хэрэглэхгүй;

с) Энэ зүйлийг бүхэлд нь аливаа хувь хүнээс бусад этгээд Хэлэлцэн тохирогч нэгээс дээш Хэлэлцэн тохирогч улсын оршин суугч байх тохиолдолд Хэлэлцэн тохирогч улсуудын эрх бүхий байгууллагууд харилцан тохиролцох замаар аль нэг Хэлэлцэн тохирогч улсын оршин суугчаар тодорхойлохоор хүчин чармайлт гаргах үүрэг хүлээлгэхгүйгээр гэрээний давуу талыг олгохгүй гэсэн зохицуулалт бүхий өөрийн Хамаарах татварын гэрээнд хэрэглэхгүй;

д) Энэ зүйлийг бүхэлд нь аливаа хувь хүнээс бусад этгээд Хэлэлцэн тохирогч нэгээс дээш Хэлэлцэн тохирогч улсын оршин суугч байх тохиолдолд Хэлэлцэн тохирогч улсуудын эрх бүхий байгууллагууд харилцан тохиролцох замаар аль нэг Хэлэлцэн тохирогч улсын оршин суугчаар тодорхойлохоор хүчин чармайлт гаргах үүрэгтэй бөгөөд хоёр талын эрх бүхий байгууллагууд ингэж харилцан тохиролцож чадахгүй тохиолдолд уг этгээдэд Хамаарах татварын гэрээний хүрээнд ямар нөхцөл олгох асуудлыг тусгасан зохицуулалт бүхий өөрийн Хамаарах татварын гэрээнд хэрэглэхгүй;

е) Хамаарах татварын гэрээний зорилгоор тэдгээрийн 1 дэх хэсгийн сүүлийн өгүүлбэрийг дараах өгүүлбэрээр солих:

“Ийм харилцан тохиролцоогүйгээр тухайн этгээд Хамаарах татварын гэрээнд заасан аливаа татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэхгүй.”

ф) Энэ зүйлийг бүхэлд нь энэ хэсгийн е)-д заасан тайлбар хийсэн Оролцогч талуудтай байгуулсан Хамаарах татварын гэрээнд хэрэглэхгүй байх.

4. Энэ зүйлийн 3 дахь хэсгийн а)-д заасны дагуу тайлбар хийгээгүй Оролцогч тал бүр тэдгээрийн Хамаарах татварын гэрээ нь энэ зүйлийн б)-ээс д) -д заасны дагуу тайлбарт үл хамаарах, энэ зүйлийн 2 дахь хэсэгт тодорхойлсон зохицуулалтыг агуулсан эсэхийг хадгалагчид мэдэгдэх ба хэрэв тийм бол тухайн зохицуулалт бүхий өөрийн Хамаарах татварын гэрээнд хэрэглэхгүй;

Хамаарах татварын гэрээний зохицуулатын талаар Хэлэлцэн тохиролцогч бүх улс ийнхүү мэдэгдсэн бол тус зохицуулалт нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар солино. Бусад тохиолдолд Хамаарах татварын гэрээний зохицуулалт нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасантай зөрчилдсөн тохиолдолд энэ зүйлийн 1 дэх хэсгийг хэрэглэнэ.



5 дугаар зүйл.

Татварын давхардлыг арилгах аргуудыг хэрэглэх

1. Аль нэг Оролцогч тал энэ зүйлийн 2, 3 дахь хэсэг (А хувилбар), 4, 5 дахь хэсэг (В Хувилбар), эсхүл 6, 7 дахь хэсэг (С Хувилбар) –ийг хэрэглэхээр, эсхүл дурдсан аль ч хувилбарыг хэрэглэхээр сонгохгүй байж болно.

Аль нэг Хамаарах татварын гэрээний Хэлэлцэн тохирогч улсууд ялгаатай хувилбарыг сонгосон (эсхүл аль нэг Хэлэлцэн тохирогч улс нь аль нэг хувилбарыг хэрэглэхээр сонгосон бөгөөд нөгөө Хэлэлцэн тохирогч улс аль ч хувилбарыг хэрэглээр сонгоогүй) бол Хэлэлцэн тохирогч улсын сонгосон хувилбар нь түүний нутаг дэвсгэрт оршин суугч этгээдийн хувьд үйлчилнэ.


А Хувилбар

2. Татварын давхардлыг арилгах зорилгоор Хэлэлцэн тохирогч улсын оршин суугчийн орлого, эсхүл хөрөнгөд тухайн улсад татвараас чөлөөлөх тухай Хамаарах татварын гэрээний зохицуулалтыг, хэрэв нөгөө Хэлэлцэн тохирогч улс гэрээний энэхүү зохицуулалтыг тухайн орлого, эсхүл хөрөнгийг татвараас чөлөөлөх, эсхүл тэдгээрт ногдуулах татварын хувь хэмжээг хязгаарлах байдлаар хэрэглэдэг бол, түүнийг дагаж мөрдөхгүй. Энэ тохиолдолд, эхэнд дурдсан Хэлэлцэн тохирогч улс нь оршин суугчийн орлого болон хөрөнгөд ногдуулах татвараас Хэлэлцэн тохирогч нөгөө улсад төлөгдсөн татварын хэмжээгээр хасаж тооцохыг зөвшөөрнө. Энэ хасалт нь нөгөө Хэлэлцэн тохирогч улсад татвар ногдуулж болох орлого, эсхүл хөрөнгөд хасалт хийхийн өмнө тооцож ногдуулсан татварын дүнгээс хэтрэхгүй байна.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсгийг Хэлэлцэн тохирогч улс энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан орлого, эсхүл түүнд дурдсан хөрөнгийг татвараас чөлөөлөх үүрэг хүлээсэн Хамаарах татварын гэрээнд хэрэглэнэ.

В Хувилбар

4. Татварын давхардлыг арилгах зорилгоор Хэлэлцэн тохирогч улсын оршин суугчийн орлогыг ногдол ашиг гэж тооцон тухайн улсад орлогыг татвараас чөлөөлөх тухай Хамаарах татварын гэрээний зохицуулалтыг, Хэлэлцэн тохирогч нөгөө улсын хуулийн дагуу тус улсын оршин суугчийн татвар ногдуулах орлогыг тооцоход татварын хасалт хийхэд хүргэж байгаа тохиолдолд, хэрэглэхгүй. Энэ тохиолдолд эхэнд дурдсан Хэлэлцэн тохирогч улс нь оршин суугчийн орлогод ногдуулах татвараас Хэлэлцэн тохирогч нөгөө улсад төлөгдсөн татварын хэмжээгээр хасаж тооцохыг зөвшөөрнө. Энэ хасалт нь нөгөө Хэлэлцэн тохирогч улсад татвар ногдуулж болох орлогод хасалт хийхийн өмнө тооцож ногдуулсан татварын дүнгээс хэтрэхгүй байна.



5. Энэ зүйлийн 4 дэх хэсгийг Хэлэлцэн тохирогч улс энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасан орлогыг татвараас чөлөөлөх үүрэг хүлээсэн Хамаарах татварын гэрээнд хэрэглэнэ.

С Хувилбар

6. а) Хэлэлцэн тохирогч улсын оршин суугч нь Хамаарах татварын гэрээний дагуу нөгөө Хэлэлцэн тохирогч улсад татвар ногдох орлого олсон, эсхүл хөрөнгө эзэмшдэг тохиолдолд (нөгөө Хэлэлцэн тохирогч улсын оршин суугчийн олсон орлого учраас энэ гэрээний дагуу нөгөө Хэлэлцэн тохирогч улс зөвхөн татвар ногдуулах эрхтэйгээс бусад тохиолдолд) дээр дурдсан Хэлэлцэн тохирогч улс дараах зүйлийг зөвшөөрнө:

i) Тухайн оршин суугчийн орлогод ногдуулсан татвараас нөгөө Хэлэлцэн тохирогч улсад төлсөн орлогын албан татварын хэмжээгээр хасалт хийх;

ii) Тухайн оршин суугчийн хөрөнгөд ногдуулсан татвараас нөгөө Хэлэлцэн тохирогч улсад төлсөн хөрөнгийн албан татварын хэмжээгээр хасалт хийх;

Энэ хасалт нь нөгөө Хэлэлцэн тохирогч улсад татвар ногдуулж болох орлого, эсхүл хөрөнгөд хасалт хийхийн өмнө тооцож ногдуулсан татварын дүнгээс хэтрэхгүй байна.

б) Хамаарах татварын гэрээний аль нэг заалтын дагуу Хэлэлцэн тохирогч улсын оршин суугч нь тухайн улсад хөрөнгийн болон орлогын албан татвараас чөлөөлөгдсөн тохиолдолд, тухайн Хэлэлцэн тохирогч улс нь тэр оршин суугчийн үлдэгдэл хөрөнгө болон орлогод ногдуулах татварын хэмжээг тогтоох явцад чөлөөлсөн хөрөнгийн болон орлогын татварыг заавал харгалзан үзнэ.

7. Энэ зүйлийн 6 дахь хэсгийг Хамаарах татварын гэрээний татварыг давхардуулан ногдуулахгүй байх зорилгоор аль нэг Хэлэлцэн тохиролцогч улсын оршин суугчийн орлого болон хөрөнгөд Хамаарах татварын гэрээний дагуу Хэлэлцэн тохиролцогч нөгөө улс татвар ногдуулах боломжтой тохиолдолд уг орлогыг Хэлэлцэн тохирогч улс татвараас чөлөөлөхөөр зохицуулсан заалтуудын оронд хэрэглэнэ.

8. Энэ зүйлд заасан хувилбаруудаас аль нэгийг нь хэрэглэхээр сонгоогүй аль нэг Оролцогч тал энэхүү зүйлийг бүхэлд нь өөрийн нэг болон түүнээс дээш Хамаарах татварын гэрээнд (эсхүл өөрийн бүх Хамаарах татварын гэрээнд) хэрэглэхгүй байх эрхтэй.



9. Энэ зүйлд заасан С хувилбарыг хэрэглэхээр сонгоогүй аль нэг Оролцогч тал нь нэг болон түүнээс дээш Хамаарах татварын гэрээнд (эсхүл өөрийн бүх Хамаарах татварын гэрээнд) нөгөө Хэлэлцэн тохирогч улсуудыг С хувилбарыг хэрэглэхийг зөвшөөрөхгүй байх эрхтэй.

10. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аль нэг хувилбарыг хэрэглэхээр сонгосон Оролцогч тал бүр сонгосон хувилбарынхаа тухай хадгалагчид мэдэгдэнэ. Ийм мэдэгдэлд дараах зүйлийг тусгана:

а) Аль нэг Оролцогч тал нь А хувилбарыг хэрэглэхээр сонгосон бол энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан зохицуулалтыг агуулж буй өөрийн Хамаарах татварын гэрээний жагсаалт, ийм зохицуулалт бүрийн зүйл, заалтын дугаар;

б) Аль нэг Оролцогч тал нь В хувилбарыг хэрэглэхээр сонгосон бол энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасан зохицуулалтыг агуулж буй өөрийн Хамаарах татварын гэрээний жагсаалт, ийм зохицуулалт бүрийн зүйл, заалтын дугаар;

с) Аль нэг Оролцогч тал нь С хувилбарыг хэрэглэхээр сонгосон бол энэ зүйлийн 7 дахь хэсэгт заасан зохицуулалтыг агуулж буй өөрийн Хамаарах татварын гэрээний жагсаалт, ийм зохицуулалтын зүйл, заалтын дугаар;

Оролцогч тал нь аль нэг хувилбарыг хэрэглэхээр сонгосон бөгөөд Хамаарах татварын гэрээний холбогдох зохицуулалтын тухай мэдэгдэл хийсэн бол тухайн хувилбар нь зөвхөн Хамаарах татварын гэрээний тухайн зохицуулалтад үйлчилнэ.

3 ДУГААР БҮЛЭГ

ГЭРЭЭГ УРВУУЛАН АШИГЛАХ

6 дугаар зүйл.

Хамаарах татварын гэрээний зорилго

1. Хамаарах татварын гэрээний оршил хэсэгт дараах өгүүлбэрийг нэмж, өөрчилнө.

"Татвараас зугтах, эсхүл зайлсхийх (тухайлбал, гуравдагч улсын оршин суугчид шууд бус ашиг бий болгохоор энэ гэрээнд заасан хөнгөлөлт эдлэх зорилгоор гэрээг урвуулан ашиглах) замаар татвар ногдуулахгүй байх, эсхүл татварын хувь хэмжээг бууруулах боломжийг үүсгэхгүйгээр энэ гэрээнд хамаарах татваруудад давхар татвар ногдуулахгүй байхыг эрмэлзэн,"

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан өгүүлбэрийг Хамаарах татварын гэрээнд хэрэглэхдээ оршил хэсэгт заасан татварын давхардлыг арилгах зорилт бүхий өгүүлбэрийн татвар ногдуулахгүй байх болон татварын хувь хэмжээг бууруулах

Монгол Улсын Гадаад харилцааны яам
АЛБАН ЁСНЫ ОРЧУУЛГА МӨН

Гарын үсэг /Signature: *Ж.С* 9

2023 оны 10 сарын 15 өдөр
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs of Mongolia
OFFICIAL TRANSLATION

боломжийг үүсгэхгүй байх гэж заасныг үл харгалзан түүний оронд, эсхүл байхгүй үед хэрэглэнэ.

3. Аль нэг Оролцогч тал нь татварын асуудлаар хамтын ажиллагааг өргөжүүлэх, эсхүл эдийн засгийн харилцааг хөгжүүлэхийг эрмэлзэх талаар өөрийн Хамаарах татварын гэрээний оршил хэсэгт заагаагүй бол Хамаарах татварын гэрээний оршил хэсэгт дараах өгүүлбэрийг нэмж оруулахаар сонгож болно:

"Татварын асуудлаарх Талуудын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх болон эдийн засгийн харилцааг цаашид үргэлжүүлэн хөгжүүлэхийг зорьж,"

4. Аль нэг Оролцогч тал нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасныг татвараас чөлөөлөх, эсхүл татварын хувь хэмжээг бууруулах боломжийг үүсгэхгүйгээр татварын давхардлыг арилгах тухай өгүүлбэрийг оршил хэсэгт тусгасан бөгөөд үүнд татвараас зугтах, эсхүл зайлсхийх (тухайлбал, гуравдагч улсын оршин суугчид шууд бус ашиг бий болгохоор энэ гэрээнд заасан хөнгөлөлт эдлэх зорилгоор гэрээг урвуулан ашиглах) нөхцөлийг хязгаарласан, эсхүл илүү өргөн хүрээнд зохицуулсан өөрийн Хамаарах татварын гэрээнд хэрэглэхгүй гэж тайлбар гаргах эрхтэй.


5. Энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу хийсэн тайлбараас бусад тохиолдолд Оролцогч тал бүр өөрийн Хамаарах татварын гэрээнүүд энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан оршил хэсгийн өгүүлбэрийг агуулсан эсэх, хэрэв агуулсан бол энэ хэсгийг хадгалагчид мэдэгдэнэ. Тухайн Хамаарах татварын гэрээний бүх Хэлэлцэн тохирогч улс оршил хэсгийн агуулгатай холбоотой ийм мэдэгдэл хийсэн бол уг хэсэг нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар солигдоно. Бусад тохиолдолд 1 дэх хэсэгт заасан өгүүлбэрийг оршил хэсэгт нэмж оруулна.

6. Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасныг хэрэглэхээр сонгосон аливаа Оролцогч тал нь энэ тухайгаа хадгалагчид мэдэгдэнэ. Ийм мэдэгдэлд эдийн засаг харилцааг хөгжүүлэх, татварын асуудлаарх хамтын ажиллагааг гүнзгийрүүлэхийг эрмэлзэх тухай оршил хэсэгт заагаагүй Хамаарах татварын гэрээний жагсаалтыг оруулна. Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан өгүүлбэрийг зөвхөн тухайн Хамаарах татварын гэрээний бүх улсууд энэ заалтыг хэрэглэхээр сонгосон бөгөөд энэ тухайгаа хадгалагчид мэдэгдсэн тохиолдолд уг гэрээнд нэмж оруулна.

7 дугаар зүйл

Гэрээг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх

1. Хамаарах татварын гэрээний аливаа зохицуулалтад харшлахгүйгээр аливаа орлого болон хөрөнгийн зүйлийн хувьд холбогдох бүх баримт, нөхцөл байдлыг харгалзан үзэхэд [давхар татварын гэрээнээс гарах] давуу талыг шууд болон шууд бус байдлаар эдэлж байгаа уг ажил гүйлгээг зөвхөн уг давуу талыг эдлэх үндсэн зорилгоор хийсэн гэж үзэх үндэслэлтэй бол, тухайн нөхцөлд уг гэрээний давуу талыг эдлүүлэх нь гэрээний тухайн зохицуулалтын зорилго зорилтуудад нийцэж байгаа нь тогтоогдсоноос бусад тохиолдолд Хамаарах татварын гэрээний давуу талыг олгохгүй.



2. Энэ зүйлийн 2 дахь хэсгийг Хамаарах татварын гэрээний давуу талыг олж авах нь аливаа зохион байгуулалт буюу ажил гүйлгээний, эсхүл тэдгээрт оролцож буй этгээдийн үндсэн зорилго, эсхүл үндсэн зорилгуудын нэг байсан бол Хамаарах гэрээний дагуу өөр тохиолдолд олгох байсан давуу талыг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн эдлүүлэхгүй гэсэн Хамаарах гэрээний зохицуулалтын оронд, эсхүл тийм зохицуулалт байхгүй бол хэрэглэнэ.

3. Энэ зүйлийн 15 дахь хэсгийн а)-д заасны дагуу тайлбар хийгээгүй аль нэг Оролцогч тал нь энэ зүйлийн 4 дэх хэсгийг өөрийн Хамаарах татварын гэрээнд хэрэглэхээр сонгож болно.


4. Хамаарах татварын гэрээний давуу талыг олж авах нь аливаа зохион байгуулалт буюу ажил гүйлгээ, эсхүл тэдгээрт оролцож буй этгээдийн үндсэн зорилго, эсхүл үндсэн зорилгуудын нэг байсан бол Хамаарах татварын гэрээ (энэхүү конвенцоор өөрчлөгдсөн хувилбар)-ний дагуу өөр тохиолдолд түүний эдлэх байсан давуу талыг бүхэлд нь буюу зарим хэсгийг эдлүүлэхгүй гэсэн Хамаарах татварын гэрээний зохицуулалтын улмаас Хамаарах татварын гэрээний дагуу давуу тал эдлэх эрхтэй этгээдэд давуу талыг олгохоос татгалзсан тохиолдолд Хэлэлцэн тохирогч улсын эрх бүхий байгууллага нь тухайн этгээдийн хүсэлтийн дагуу холбогдох нөхцөл байдлыг харгалзан энэ давуу тал нь тухайн этгээдэд тухайн зохион байгуулалт буюу ажил гүйлгээ хийгдээгүй байсан ч олгогдох ёстой гэж тогтоосон бол тэрээр тухайн этгээдийн уг давуу тал, эсхүл тодорхой орлого, хөрөнгийн зүйлтэй холбоотой өөр давуу талыг хүртэх эрхтэй гэж үзнэ.

Тухайн Хэлэлцэн тохирогч улсын эрх бүхий байгууллага нь нөгөө Хэлэлцэн тохирогч улсын оршин суугчийн энэ зүйлийн 1 дэх хэсгийн дагуу гаргасан хүсэлтэд татгалзахаасаа өмнө энэ хүсэлтийн талаар нөгөө Хэлэлцэн тохирогч улсын эрх бүхий байгууллагатай зөвлөлдөнө.

5. Энэ зүйлийн 4 дэх хэсгийг Хамаарах татварын гэрээний давуу талыг олж авах нь аливаа зохион байгуулалт буюу ажил гүйлгээ, эсхүл тэдгээрт оролцож буй аливаа этгээдийн үндсэн зорилго, эсхүл зорилгуудын нэг байсан бол Хамаарах татварын гэрээний дагуу өөр тохиолдолд эдлэх байсан давуу талыг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн эдлүүлэхгүй гэсэн Хамаарах татварын гэрээ(энэ конвенцын дагуу өөрчлөгдсөн хувилбар)-ний зохицуулалтад хэрэглэнэ.

6. Аль нэг Оролцогч тал нь энэ зүйлийн 17 дахь хэсгийн с)-гийн дагуу мэдэгдэл хүргүүлснээр өөрийн Хамаарах татварын гэрээнүүдэд энэ зүйлийн 8-13 дахь хэсэг (цаашид “Давуу талыг хязгаарлах хялбаршуулсан зохицуулалт” гэх)-ийг хэрэглэхээр мөн сонгож болно.

Тухайн Хэлэлцэн тохирогч улсын эрх бүхий байгууллага нь нөгөө Хэлэлцэн тохирогч Давуу талыг хязгаарлах хялбаршуулсан зохицуулалтыг зөвхөн аль нэг Хамаарах татварын гэрээний бүх Хэлэлцэн тохирогч улс хэрэглэхээр сонгосон тохиолдолд л тухайн Хамаарах татварын гэрээнд хэрэглэнэ.



7. Аль нэг Хамаарах татварын гэрээний Хэлэлцэн тохирогч бүх улс биш, зөвхөн зарим улс энэ зүйлийн 6 дахь хэсгийн дагуу давуу талыг хязгаарлах хялбаршуулсан зохицуулалтыг хэрэглэхээр сонгосон тохиолдолд энэ зүйлийн 6 дахь хэсэгт харшлахгүйгээр тухайн Хамаарах татварын гэрээний дагуу олгох давуу талын хувьд давуу талыг хязгаарлах хялбаршуулсан зохицуулалтыг хэрэглэнэ. Үүнд:

а) Энэ зүйлийн 6 дахь хэсгийн дагуу давуу талыг хязгаарлах хялбаршуулсан зохицуулалтыг хэрэглэхээр сонгоогүй Хэлэлцэн тохирогч бүх улс энэ дэд хэсгийг хэрэглэхээр сонгосон бөгөөд энэ тухай хадгалагчид мэдэгдэх замаар ийм байдлаар уг зохицуулалтыг хэрэглэхийг зөвшөөрсөн бол Хэлэлцэн тохирогч бүх улсаар; эсхүл

б) Энэ зүйлийн 6 дахь хэсгийн дагуу давуу талыг хязгаарлах хялбаршуулсан зохицуулалтыг хэрэглэхээр сонгоогүй Хэлэлцэн тохирогч бүх энэ дэд хэсгийг хэрэглэхээр сонгосон бөгөөд энэ тухай хадгалагчид мэдэгдэх замаар ийм байдлаар уг зохицуулалтыг хэрэглэхийг зөвшөөрсөн бол давуу талыг хязгаарлах хялбаршуулсан зохицуулалтыг хэрэглэхээр сонгосон Хэлэлцэн тохирогч улсуудаар.

Давуу талыг хязгаарлах хялбаршуулсан зохицуулалт

8. Давуу талыг хязгаарлах хялбаршуулсан зохицуулалтад өөрөөр заагаагүй бол Хэлэлцэн тохирогч улсын оршин суугч нь Хамаарах татварын гэрээний давуу талаас ялгаатай, Хамаарах татварын гэрээгээр өөр тохиолдолд эдлэх байсан давуу талыг эдлэх эрхгүй бөгөөд:

а) Хэлэлцэн тохирогч улсын оршин суугчийг тодорхойлсон Хамаарах татварын гэрээний зохицуулалтаас шалтгаалан нэгээс дээш Хэлэлцэн тохирогч улсын оршин суугчийн харьяалалттай хувь хүнээс бусад этгээдийн оршин суугчийн харьялалыг зохицуулсан;

б) Хэлэлцэн тохирогч улс нь тухайн улсын аж ахуйн нэгжид Хамаарах татварын гэрээний дагуу нөгөө Хэлэлцэн тохирогч улсын олгосон эхний тохируулгын дараагаар холбогдох хуулийн этгээдийн олсон ашигт эхэнд дурдсан Хэлэлцэн тохирогч улсын ногдуулсан татварын хэмжээнд тохируулан бууруулсан; эсхүл

с) Хэлэлцэн тохирогч улсын оршин суугч нь Хамаарах татварын гэрээнд нийцээгүй татвар ногдуулсан гомдлыг шалгуулах хүсэлтийг Хэлэлцэн тохиролцогч тухайн улсын эрх бүхий байгууллагад гаргаж болно.

Энэ зүйлийн 9 дэх хэсэгт тодорхойлсны дагуу тухайн давуу талыг олгох үед, уг оршин суугч нь "шаардлага хангасан этгээд" байхаас бусад тохиолдолд

9. Хэлэлцэн тохирогч улсын оршин суугч нь Хамаарах татварын гэрээний дагуу давуу тал эдлэх үед шаардлага хангасан этгээд байна. Хэрэв, тэр үед тухайн оршин суугч нь:

Монгол Улсын Гадаад харилцааны яам
АЛБАН ЁСНЫ ОРЧУУЛГА МӨН

Гарын үсэг /Signature/ *А.С.*¹²

2023 оны 10 сарын 15 өдөр
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs of Mongolia
OFFICIAL TRANSLATION

a) Хувь хүн;

b) уг Хэлэлцэн тохирогч улс, эсхүл түүний улс нутаг дэвсгэрийн нэгж, эсхүл түүний засаг захиргаа, эсхүл Хэлэлцэн тохирогч тухайн улсын байгууллага, эдгээрийн улс төрийн дэд нэгж эсхүл орон нутгийн засаг захиргаа;

c) Хэрэв нэг болон түүнээс дээш хүлээн зөвшөөрөгдсөн хөрөнгийн биржээр хувьцааны үндсэн ангилал нь байнга арилждаг бол компани, эсхүл бусад аж ахуйн нэгж;

d) Хувь хүнээс бусад этгээд нь:

i) Хэлэлцэн тохирогч улсууд ноот бичиг солилцох замаар тохиролцсон нэг төрлийн ашгийн бус байгууллага; эсхүл

ii) Тухайн Хэлэлцэн тохирогч улсын татварын хуулийн дагуу бие даасан этгээдээр тооцогдож буй тухайн Хэлэлцэн тохирогч улсад байгуулагдсан хуулийн этгээд, эсхүл зохион байгуулалт байх:

A) Хувь хүмүүст тэтгэвэр олгох болон тусламж үзүүлэх, эсхүл нэмэлт- болон дагалдах тусламж үзүүлэх, эсхүл зохицуулахад төвлөрөн, эсхүл голлон үйл ажиллагаа явуулдаг, эсхүл явуулахаар байгуулагдсан бөгөөд ийм төрлийн үйл ажиллагаанд тухайн Хэлэлцэн тохирогч улс, эсхүл тухайн улсын нутгийн захиргааны байгууллага хуулийн дагуу зохицуулалт хийдэг; эсхүл

B) Аж ахуйн нэгжийн, эсхүл энэ зүйлийн 9 дэх хэсгийн ii)-ийн A)-д заасан зохион байгуулалт, эсхүл аж ахуйн нэгжийн үр ашигт зориулан санхүүжилт хийхэд төвлөрөн эсхүл голлон үйл ажиллагаа явуулдаг, эсхүл явуулахаар байгуулагдсан;

e) Хувь хүнээс бусад этгээд нь, хэрэв, гэрээний давуу хүртэх үеийг оролцуулан хамгийн багадаа арван хоёр сарын хугацааны хагаст нь тухайн Хэлэлцэн тохирогч улсын оршин суугчийн хувьцааны хамгийн багадаа 50 хувийг шууд болон шууд бусаар эзэмшдэг бол энэ зүйлийн a) –аас d) дэх заалтийн дагуу Хамаарах татварын гэрээний давуу талыг эдлэх эрхтэй.

10. a) Хэлэлцэн тохирогч улсын оршин суугч нь түүнийг шаардлага хангасан этгээд мөн эсэхээс үл хамааран тус улсад идэвхтэй бизнесийн үйл ажиллагаа эрхэлж байгаа ба уг бизнесийн үйл ажиллагаанаас олсон, эсхүл үүнтэй хамааралтай Хэлэлцэн тохиролцогч нөгөө улсад байгаа орлого буюу Хэлэлцэн тохиролцогч нөгөө улсад холбогдох тодорхой орлогын хувьд Хамаарах татварын гэрээний давуу талыг эдлэх эрхтэй. Давуу талыг

Монгол Улсын Гадаад харилцааны яам
ALBAN ECHYI ORCHUULGA MОН
13
Гарын үсэг /Signature/ *Ж.С*
2023 оны 10 сарын 16 өдөр
ТӨР АНГ
Ministry of Foreign Affairs of Mongolia
Орхон, Увс

хязгаарлах хялбаршуулсан зохицуулалтын зорилгоор “идэвхтэй бизнес эрхэлдэг” гэдэгт дараах үйл ажиллагаа, эсхүл аливаа хослолууд хамаарахгүй. Үүнд:


- i) Хувьцаат компани хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулдаг;
- ii) Бүлэг компаний удирдлага, эсхүл ерөнхий хяналт
- iii) Бүлэг компаний санхүүжилт, (бэлэн мөнгөний нөөцийг оруулан); эсхүл
- iv) Банк, даатгалын компани, эсхүл бүртгэлтэй үнэт цаасны дилерүүд өөрсдийн ердийн үйл ажиллагааны хүрээнд хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа явуулах эсхүл удирдан зохицуулахаас бусад хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа явуулах, эсхүл түүнийг удирдан зохицуулах;

b) Хэрэв Хамаарах татварын гэрээний нэг тал болох Хэлэлцэн тохирогч улсын оршин суугч нь өөрийн эрхэлдэг бизнесийн үйл ажиллагаагаар, эсхүл холбоотой этгээдээрээ дамжуулан нөгөө Хэлэлцэн тохиролцогч улсаас орлогын зүйл олсон бол а) дэд заалтад заасан нөхцөлүүдийг тухайн орлогын зүйлийн хувьд, эхэнд дурдсан Хэлэлцэн тохирогч улсын оршин суугчийн эрхэлдэг уг орлогын зүйлийг бий болгосон бизнесийн үйл ажиллагаа нь нөгөө Хэлэлцэн тохирогч улс дахь түүний холбоотой этгээдийн явуулж буй ижил үйл ажиллагаа, эсхүл ижил туслах үйл ажиллагаатай харьцуулахад илүү том хэмжээтэй байх тохиолдолд зөвхөн түүнийг шаардлага хангасан гэж үзнэ. Энэ дэд заалтыг хэрэглэх хүрээнд, бизнесийн үйл ажиллагаа нь илүү том хэмжээтэй эсэхийг тогтоохын тулд холбогдох бүх баримт, нөхцөл байдлыг харгалзан үзнэ.

c) Энэхүү заалтыг хэрэглэх зорилгоор Хэлэлцэн тохирогч улсын оршин суугчийн холбоотой этгээдүүдийн явуулсан үйл ажиллагааг тус оршин суугчийн явуулсан үйл ажиллагаа гэж үзнэ.

11. Хэлэлцэн тохирогч улсын оршин суугч бөгөөд шаардлага хангаагүй этгээд нь Хамаарах татварын гэрээний давуу талуудыг эдлэх үеийг багтаасан хамгийн багадаа арван хоёр сарын хугацааны хагас өдрийн хугацаанд адилтгах ашиг хүртэгч оршин суугчийн эзэмшилд шууд болон шууд бусаар байгаа өмчлөх эрхийн 75 хувийг хамгийн багадаа эзэмшдэг бол орлогын зүйлтэй холбоотой Хамаарах татварын гэрээний давуу талын эдлэх эрхтэй.

12. Хэрэв аль нэг Хамаарах татварын гэрээний Хэлэлцэн тохиролцогч улсын оршин суугч нь энэ зүйлийн 9 дэх хэсэгт заасны дагуу шаардлага хангасан этгээд биш, эсхүл энэ зүйлийн 10, эсхүл 11-т заасны дагуу давуу талыг эдлэх эрхгүй бол, нөгөө Хэлэлцэн тохиролцогч улсын эрх бүхий байгууллага Хамаарах татварын гэрээний зорилго болон зорилтыг харгалзан зөвхөн тухайн оршин суугч нь түүний



үүсгэн байгуулалтын, худалдан авалтын, эсхүл үйлчилгээний гол зорилгууд, мөн өөрийн үйл ажиллагааны гол зорилгуудын аль нь ч Хамаарах татварын гэрээний давуу талыг олж авахын төлөө биш гэдгийг тухайн эрх бүхий байгууллагад хангалттай нотлох хүрээнд Хамаарах татварын гэрээний давуу тал, эсхүл тодорхой орлогын хувьд давуу талыг олгож болно. Энэхүү зүйлд заасны дагуу аль нэг Хэлэлцэн тохиролцогч улсын оршин суугчаас гаргасан хүсэлтийг зөвшөөрөх, эсхүл татгалзахаас өмнө, уг хүсэлтийг хүлээн авагч нөгөө Хэлэлцэн тохиролцогч улсын эрх бүхий байгууллага нь эхэнд дурдсан Хэлэлцэн тохирогч улсын эрх бүхий байгууллагатай зөвлөлдөнө.

13. Давуу талыг хязгаарлах хялбаршуулсан зохицуулалтын зорилгоор:

а) “Хүлээн зөвшөөрөгдсөн хөрөнгийн бирж” гэдэг нь дараах утгатай. Үүнд:

i) Аль нэг Хэлэлцэн тохиролцогч улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан ба хуулиар зохицуулагдах аливаа хөрөнгийн бирж; ба

ii) тухайн Хэлэлцэн тохиролцогч улсуудын эрх бүхий байгууллагаар хүлээн зөвшөөрөгдсөн аливаа бусад хөрөнгийн бирж;


б) “Хувьцааны үндсэн ангилал” гэдэг нэр томъёо гэж нийт саналын дийлэнхийг төлөөлсөн компанийн хувьцааны ангилал болон ангилалууд ба төлөөлсөн хуулийн этгээдийн үнэ цэнийг ба хуулийн этгээдийн нийт саналын дийлэнхийг эсхүл өмчлөх эрх “beneficial interests”-ийн ангилал болон ангиллууд;

с) “Адилтгах ашиг хүртэгч” гэж тухайн орлогын хувьд Хамаарах татварын гэрээний Хэлэлцэн тохиролцогч улсын дотоодын хууль тогтоомжийн дагуу тус улсаас олгож буй, Хамаарах татварын гэрээний дагуу, эсхүл бусад олон улсын гэрээ дагуу олгож буй давуу тал нь тухайн орлогын хувьд Хамаарах татварын гэрээний дагуу олгож буй давуу талтай адил, эсхүл түүнээс илүү таатай нөхцөл бүхий давуу талыг эдлэх эрхтэй аливаа этгээдийг хэлнэ;

Ногдол ашгийн хувьд аливаа этгээд нь “Адилтгах ашиг хүртэгч” мөн эсэхийг тодорхойлох зорилгоор тухайн этгээдийг, ногдол ашгийн хувьд давуу талыг шаардагч компаний эзэмшиж буй хөрөнгөтэй адил ногдол ашиг төлж буй компаний хөрөнгийг эзэмшиж байгаа этгээд гэж тооцно.

д) Компани бус аж ахуйн нэгжийн хувьд “хувьцаа” гэсэн нэр томъёо нь хувьцаатай адилтгах хувь хөрөнгийн эрхийг хэлнэ;

е) Хоёр этгээдийн нэг нь хамгийн багадаа нөгөө этгээдийн хөрөнгийн 50 хувийг шууд болон шууд бусаар эзэмшдэг байх (эсхүл, компани байх тохиолдолд, хамгийн багадаа компанийн хувьцааны нийт үнийн дүнгийн болон нийт саналын эрхийн 50 хувь), эсхүл өөр нэг этгээд нь хамгийн багадаа этгээд тус бүрийн хөрөнгийн 50 хувийг эзэмшдэг (эсхүл, компани байх



тохиолдолд, хамгийн багадаа компанийн хувьцааны нийт үнийн дүнгийн болон нийт саналын эрхийн 50 хувь) байх тохиолдолд «холбогдсон этгээдүүд» болно;

Хэрэв холбогдох бүх баримт болон нөхцөл байдлыг харгалзан нэг этгээд нь нөгөө этгээдийн хяналтад доор, эсхүл хоёул нэг этгээдийн, эсхүл этгээдүүдийн хяналтад доор байгаа бол нэг этгээд нь нөгөө этгээдтэй ямар ч тохиолдолд холбогдсон гэж үзнэ.

14. Давуу талыг хязгаарлах хялбаршуулсан зохицуулалт нь нэг болон түүнээс дээш шалгуурыг хангасан, Хамаарах татварын гэрээний дагуу давуу тал эдлэх эрхтэй оршин суугчид зөвхөн давуу тал эдлүүлэх тухай (Хамаарах татварын гэрээний Хэлэлцэн тохиролцогч улсын оршин суугчаар зөвхөн хязгаарлагдахгүй эдлүүлэх давуу тал, эсхүл үл ялгаварлах, эсхүл холбогдсон аж ахуйн нэгж, оршин суугаа газартай холбогдуулан Хамаарах татварын гэрээний дагуу эдлүүлэх давуу талаас бусад давуу талыг хязгаарласан) Хамаарах татварын гэрээний зохицуулалтын оронд, эсхүл байхгүй тохиолдолд үйлчилнэ.


15. Аль нэг Оролцогч тал дараах тайлбар хийх эрхтэй:

а) Давуу талыг хязгаарлах хялбаршуулсан дэлгэрэнгүй зохицуулалт, сувгийн санхүүжилтийн бүтэцтэй тэмцэх журам, эсхүл гол зорилгын шалгуурыг нэвтрүүлэх болон ийм байдлаар BEPS-ийн багцын дагуу Гэрээг урвуулан ашиглахаас сэргийлэхэд зориулсан наад захын стандартыг хангахыг эрмэлзэж буйг үндэслэн энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасныг өөрийн Хамаарах татварын гэрээнд хэрэглэхгүй байх; энэ тохиолдолд тухайн наад захын стандартыг хангасан, харилцан сэтгэл хангалуун байх шийдэлд хүрэхийг Хэлэлцэн тохирогч улсууд эрмэлзэнэ;

б) Энэ зүйлийн 1 дэх хэсэг (мөн аль нэг Оролцогч тал хэрэглэхээр сонгосон тохиолдолд энэ зүйлийн 4 дэх хэсэг)-ийг аливаа зохион байгуулалт, буюу ажил гүйлгээ, эсхүл түүнд оролцсон этгээдийн гол зорилго, эсхүл гол зорилгуудын нэг нь Хамаарах татварын гэрээний давуу талыг олж авах байсан бол Хамаарах татварын гэрээний дагуу өөр тохиолдолд эдлэх байсан бүхий л давуу талыг эдлүүлэхгүй байх зохицуулалт бүхий өөрийн Хамаарах татварын гэрээнд ашиглахгүй байх;

в) Энэ зүйлийн 14 дэх хэсэгт заасан зохицуулалтыг агуулсан өөрийн Хамаарах татварын гэрээнд давуу талыг хязгаарлах хялбаршуулсан зохицуулалтыг хэрэглэхгүй байх.

16. Энэ зүйлийн 7 дахь хэсэгт заасны дагуу нэг болон түүнээс дээш Оролцогч талууд Хамаарах татварын гэрээний дагуу давуу тал эдлүүлэхтэй холбогдуулан давуу талыг хязгаарлах хялбаршуулсан зохицуулалтыг хэрэглэхээс бусад тохиолдолд энэ зүйлийн 6 дахь хэсгийн дагуу давуу талыг хязгаарлах хялбаршуулсан зохицуулалтыг хэрэглэхээр сонгосон аль нэг Оролцогч тал нь нэг



болон түүнээс дээш нөгөө Хэлэлцэн тохиролцогч улсууд давуу талыг хязгаарлах хялбаршуулсан зохицуулалтыг хэрэглэхээр сонгоогүй учраас энэ зүйлийг бүхэлд нь өөрийн Хамаарах татварын гэрээний хувьд үйлчлэхгүй гэж тайлбар хийх эрхтэй.

Энэ тохиолдолд Хэлэлцэн тохиролцогч улсууд BEPS-ийн багцын дагуу гэрээг урвуулан ашиглахаас сэргийлэх наад захын стандартыг хангасан, харилцан сэтгэл хангалуун байх шийдэлд хүрэхийг эрмэлзэнэ.

17.

а) Энэ зүйлийн 15 дахь хэсгийн а)-д заасны дагуу тайлбар хийгээгүй Оролцогч тал бүр өөрийн Хамаарах татварын гэрээ нь энэ зүйлийн 15 дахь хэсгийн б)-д заасан тайлбарт хамаарахгүй бөгөөд гэрээ бүр энэ зүйлийн 2 дахь хэсгийн зохицуулалтыг агуулсан тухай хадгалагчид мэдэгдэх бөгөөд ийм зохицуулалт агуулсан бол тухайн зохицуулалтын зүйл, заалтын дугаарыг мэдэгдэнэ.

Хамаарах татварын гэрээний дагуу бүх Хэлэлцэн тохиролцогч улс ийм мэдэгдэл хийсэн бол тэрхүү заалт нь энэ зүйлийн 1 дэх хэсгээр солигдоно (тохиромжтой үед энэ зүйлийн 4 дэх хэсэгт). Бусад тохиолдолд, Хамаарах татварын гэрээний заалтууд энэ зүйлийн 1 хэсэгтэй зөрчилдсөн тохиолдолд зөвхөн энэ зүйлийн 1 дэх хэсэг (тохиромжтой үед энэ зүйлийн 4 дэх хэсэг)-ийг хэрэглэнэ.

Энэхүү заалтын дагуу мэдэгдэл гаргаж буй аль нэг Оролцогч тал нь энэ зүйлийн 1 дэх хэсгийг дангаар нь завсарын үед хэрэглэхийг хүлээн зөвшөөрч байгаа ба боломжтой тохиолдолд энэ зүйлийн 1 дэх хэсэгт нэмэлтээр, эсхүл түүний оронд хоёр талт хэлэлцээ хийх замаар давуу талыг хязгаарлах зохицуулалтыг батлахаар зорьж байгаагаа мэдэгдэж болно.

б) Энэ зүйлийн 4 дэх хэсгийг хэрэглэхээр сонгосон Оролцогч тал энэ тухайгаа хадгалагчид мэдэгдэнэ. Ийм мэдэгдлийг бүх Хэлэлцэн тохирогч тал гаргасан тохиолдолд л зөвхөн энэ зүйлийн 4 дэх хэсэг тухайн Хамаарах татварын гэрээний хувьд үйлчилнэ.

с) Энэ зүйлийн 6 дахь хэсгийн дагуу давуу талыг хязгаарлах хялбаршуулсан зохицуулалтыг хэрэглэхээр сонгосон аливаа Оролцогч тал нь энэ тухайгаа хадгалагчид мэдэгдэнэ. Энэ зүйлийн 15 дахь хэсгийн с)-д заасны дагуу тайлбар хийгээгүй тохиолдолд уг мэдэгдэлд энэ зүйлийн 14 дэх хэсэгт заасныг агуулсан Хамаарах татварын гэрээний жагсаалт болон зүйл, заалтын дугаарын хамт тусгана.

д) Энэ зүйлийн 6 дахь хэсэгт заасны дагуу давуу талыг хялбарчилсан хязгааралтын заалтыг хэрэглэхээр сонгоогүй боловч 7 дахь хэсгийн а), эсхүл б) заалтыг хэрэглэхээр сонгосон Оролцогч тал нь энэ тухайгаа хадгалагчид мэдэгдэнэ. Энэ зүйлийн 15 дахь хэсгийн с)-д заасны дагуу тайлбар хийгээгүй тохиолдолд энэ зүйлийн 14 дэх хэсэгт заасан зохицуулалтыг агуулсан

Монгол Улсын Гадаад харилцааны чам
АЛБАН ЁСНЫ ОРЧУУЛГА МОНГОЛ

Гарын үсэг /Signature/ *2023*

2023 оны 10 сарын 16
Улаанбаатар х

Ministry of Foreign Affairs
OFFICIAL TRANSLATION

Хамаарах татварын гэрээний жагсаалт болон зүйл, заалтын дугаарыг мөн уг мэдэгдэлд тусгана.

е) Хамаарах татварын гэрээний зохицуулалтай холбогдуулан энэ хэсгийн с) эсхүл d)-д заасны дагуу бүх Хэлэлцэн тохирогч тал мэдэгдэл хүргүүлсэн бол тухайн Хамаарах татварын гэрээний зохицуулалт нь давуу талыг хязгаарлах хялбаршуулсан зохицуулалтаар солигдоно. Бусад тохиолдолд, Хамаарах татварын гэрээний зохицуулалт давуу талыг хязгаарласан хялбаршуулсан зохицуулалттай зөрчилдсөн тохиолдолд давуу талыг хязгаарлах хялбаршуулсан зохицуулалтыг хэрэглэнэ.

8 дугаар зүйл

Ногдол ашиг шилжүүлэх гүйлгээ

1. Ногдол ашиг эзэмшигч, эсхүл хүлээн авагч нь нөгөө Хэлэлцэн тохирогч улсын оршин суугч бөгөөд ногдол ашиг тарааж буй тухайн компанийн хөрөнгө, хувьцаа, үнэт цаас, саналын эрх, санал өгөх эрх, эсхүл ижил төстэй эзэмших эрхийн тодорхой хэмжээнээс илүүг эзэмшдэг, эсхүл хянадаг компани бол аливаа Хэлэлцэн тохирогч улсын оршин суугч компаниас тарааж буй ногдол ашигт ногдуулах боломжтой татвараас чөлөөлөх, эсхүл татварын хувь хэмжээ хязгаарлах тухай Хамаарах татварын гэрээний зохицуулалт нь хэрэв тухайн заалтуудад тодорхойлсон эзэмших эрхийн нөхцөлүүдийг ногдол ашгийг тараах өдрийг оролцуулан 365 өдрийн хугацаанд хангасан тохиолдолд л (тухайн хугацааг тооцоолох зорилгоор хувьцаа эзэмшдэг эсхүл ногдол ашиг тараах компанийг нийлүүлэх эсхүл хуваах гэх мэт корпорацын бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтөөс шууд үүсэх эзэмших эрхэд орох өөрчлөлт оруулах ямар ч асуудал байж болохгүй) зөвхөн үйлчилнэ.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хамгийн багадаа үргэлжлэх хугацаа нь Хамаарах татварын гэрээнд заасан хөрөнгө эзэмших доод хугацааны оронд, эсхүл байхгүй тохиолдолд хэрэглэнэ.

3. Аль нэг Оролцогч тал нь дараах тайлбар хийх эрхтэй:


а) Энэ зүйлийг бүхэлд нь өөрийн Хамаарах татварын гэрээнд хэрэглэхгүй байх;

б) Энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан зохицуулалт нь аль хэдийн дараах агуулгатай байх хүрээнд өөрийн Хамаарах татварын гэрээнүүдэд энэ зүйлийг бүхэлд нь хэрэглэхгүй байх. Үүнд:

i) Хөрөнгө эзэмших доод хугацаа;

ii) 365 өдрөөс богино хөрөнгө эзэмших доод хугацаа; эсхүл

iii) 365 өдрөөс урт хөрөнгө эзэмших доод хугацаа



4. Энэ зүйлийн 3 дахь хэсгийн а)-д дагуу тайлбар хийгээгүй аливаа Оролцогч тал тус бүр нь өөрийн Хамаарах татварын гэрээ нь энэ зүйлийн 3 дахь хэсгийн б) д заасны дагуу тайлбар хийх шаардлагагүй, 1 дэх хэсэгт дурдсан зохицуулалтыг агуулсан эсэхийг, мөн агуулсан бол тухайн зохицуулалтын зүйл, заалтын дугаарыг хадгалагчид мэдэгдэнэ.

Энэ зүйлийн 1 дэх хэсгийг зөвхөн бүх Хэлэлцэн тохирогч улс тухайн заалттай холбогдуулан ийм мэдэгдэл гаргасан бол тухайн Хамаарах татварын гэрээнд хэрэглэнэ.

9 дүгээр зүйл

Этгээдийн үндсэн үнэлгээ нь үл хөдлөх хөрөнгөөс гаралтай хувь оролцоо, эсхүл хувьцаа шилжүүлснээс олсон хөрөнгийн орлого

1. Хэрэв аливаа этгээдийн хувьцаа, эсхүл бусад оролцооны эрхийн үнийн дүнгийн тодорхой хувиас илүү хэсэг нь нөгөө Хэлэлцэн тохирогч улсад орших үл хөдлөх хөрөнгөөс үүсэлтэй бол (эсхүл тухайн этгээдийн хөрөнгийн тодорхой хувиас илүү хэсэг нь ийм үл хөдлөх хөрөнгөөс бүрдэж байгаа бол) Хэлэлцэн тохирогч улсын байнгын оршин суугчийн тухайн хувьцаа, эсхүл эрхийг шилжүүлснээс олсон орлогод нөгөө Хэлэлцэн тохирогч улсад татвар ногдуулж болно гэсэн Хамаарах татварын гэрээний заалт нь:


а) Шилжүүлэхээс өмнөх 365 өдрийн хугацааны аль ч үед холбогдох үнийн дүнгийн босгонд хүрэх тохиолдолд үйлчилнэ; мөн

б) тухайн заалтад нэгэнт хамаарах хувьцаа, эсхүл эрхт нэмж хувьцаа, эсхүл адилтгах эрх, түүнчлэн аливаа нөхөрлөл, эсхүл траст дахь эрх (эдгээр хувьцаа, эсхүл эрх нь энэ заалтад нэгэнт хамаарахгүй үед) –д үйлчилнэ.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн а)-д заасан хугацаа нь Хамаарах татварын гэрээний заалтын дагуу энэ хэсэгт заасан холбогдох үнийн дүнгийн босгонд хүрсэн эсэхийг тодорхойлох хугацааны оронд, эсхүл ийм хугацаа байхгүй тохиолдолд үйлчилнэ.

3. Аль нэг Оролцогч тал нь өөрийн Хамаарах татварын гэрээнд энэ зүйлийн 4 дэх хэсгийг хэрэглэхээр мөн сонгож болно.

4. Хамаарах татварын гэрээний зорилгоор, хэрэв хувьцаа, эсхүл бусад эрх, түүнчлэн нөхөрлөл, эсхүл трастын эрхийн үнийн дүнгийн 50 хувиас илүү хэсэг нь түүнийг шилжүүлэхээс өмнөх 365 хоногийн хугацааны аль ч үед нөгөө Хэлэлцэн тохирогч улсад орших үл хөдлөх хөрөнгөөс шууд болон шууд бусаар үүсэлтэй бол тухайн хувьцаа, эсхүл адилтгах эрхийг шилжүүлснээс олсон Хэлэлцэн тохирогч улсын байнгын оршин суугчийн орлогод нөгөө Хэлэлцэн тохирогч улс татвар ногдуулж болно.



5. Хэрэв аливаа этгээдийн хувьцаа, эсхүл бусад оролцооны эрхийн үнийн дүнгийн тодорхой хувиас илүү хэсэг нь нөгөө Хэлэлцэн тохирогч улсад орших үл хөдлөх хөрөнгөөс үүсэлтэй бол (эсхүл тухайн этгээдийн хөрөнгийн тодорхой хувиас илүү хэсэг нь ийм үл хөдлөх хөрөнгөөс бүрдэж байгаа бол) Хэлэлцэн тохирогч улсын байнгын оршин суугчийн тухайн хувьцаа, эсхүл эрхийг шилжүүлснээс олсон орлогод нөгөө Хэлэлцэн тохирогч улсад татвар ногдуулж болно гэсэн Хамаарах татварын гэрээний заалтын оронд, эсхүл байхгүй тохиолдолд энэ зүйлийн 4 дэх хэсгийг хэрэглэнэ.

6. Аль нэг Оролцогч тал нь дараах тайлбар хийх эрхтэй:

а) Энэ зүйлийн 1 дэх хэсгийг өөрийн Хамаарах татварын гэрээнд хэрэглэхгүй;

б) Энэ зүйлийн 1 дэх хэсгийн а) заалтыг өөрийн Хамаарах татварын гэрээнд хэрэглэхгүй;

с) Энэ зүйлийн 1 дэх хэсгийн б) заалтыг өөрийн Хамаарах Татварын гэрээнд хэрэглэхгүй;

д) Холбогдох үнийн босгонд хүрсэн эсэхийг тодорхойлох хугацааг багтаасан энэ зүйлийн 1 дэх хэсэгт тодорхойлсон төрлийн зохицуулалтыг бүхий өөрийн Хамаарах татварын гэрээнд энэ зүйлийн 1 дэх хэсгийн а) заалтыг хэрэглэхгүй;

е) Хувьцаанаас бусад эрхийг шилжүүлэхэд үйлчлэх энэ зүйлийн 1 дэх хэсэгт тодорхойлсон төрлийн зохицуулалт бүхий өөрийн Хамаарах гдах татварын гэрээнд энэ зүйлийн 1 дэх хэсгийн б)-г хэрэглэхгүй;

ф) Энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасан зохицуулалт бүхий өөрийн Хамаарах татварын гэрээнд энэ зүйлийн 4 дэх хэсгийг хэрэглэхгүй.

7. Энэ зүйлийн 6 дахь хэсгийн а)-д заасны дагуу тайлбар хийгээгүй аливаа Оролцогч тал өөрийн Хамаарах татварын гэрээнд энэ зүйлийн 1 дэх хэсэгт тодорхойлсон зохицуулалт байгаа эсэх, мөн байгаа тохиолдолд зохицуулалтын зүйл, заалтыг дугаарын хамт хадгалагчид мэдэгдэнэ.

Бүх Хэлэлцэн тохирогч улс тус зохицуулалттай холбоотой мэдэгдэл хийсэн тохиолдолд л зөвхөн тухайн Хамаарах татварын гэрээний тухайн зохицуулалтад энэ зүйлийн 1 дэх хэсэг үйлчилнэ.

8. Энэ зүйлийн 4 дэх хэсгийг хэрэглэхээр сонгосон аливаа Оролцогч тал нь өөрийн сонголтын талаар хадгалагчид мэдэгдэнэ. Бүх Хэлэлцэн тохирогч улс ийнхүү мэдэгдэл хийсэн тохиолдолд зөвхөн энэ зүйлийн 4 дэх хэсгийг тухайн Хамаарах татварын гэрээнд хэрэглэнэ. Ийм тохиолдолд энэ зүйлийн 1 дэх хэсэг Хамаарах татварын гэрээнд үйлчлэхгүй.



Аль нэг Оролцогч тал нь энэ зүйлийн 6 дахь хэсгийн f)-д заасны дагуу тайлбар хийгээгүй бөгөөд 6 дахь хэсгийн a)-д заасны дагуу тайлбар хийсэн тохиолдолд тухайн Оролцогч тал мэдэгдэлдээ мөн энэ зүйлийн 5 дахь хэсгийг агуулсан өөрийн бүх Хамаарах татварын гэрээний жагсаалт болон тэдгээрийн холбогдох зүйл, заалтын дугаарыг тусгах ёстой.

Энэ зүйлийн 8, эсхүл 7 дахь хэсгийн дагуу бүх Хэлэлцэн тохирогч улс Хамаарах татварын гэрээний зохицуулалттай холбоотой мэдэгдэл хийсэн тохиолдолд гэрээний зохицуулалт нь энэ зүйлийн 4 дэх хэсгээр солино. Бусад тохиолдолд Хамаарах гэрээний зохицуулалт энэ зүйлийн 4 дэх хэсэгтэй зөрчилдсөн тохиолдолд зөвхөн энэ зүйлийн 4 дэх хэсгийн заалтыг хэрэглэнэ.

10 дугаар зүйл

Гуравдагч улсад байрлах төлөөний газрыг урвуулан ашиглахын эсрэг дүрэм

1. Хэрэв

a) Хамаарах татварын гэрээний аль нэг Хэлэлцэн тохирогч улсын аж ахуйн нэгж нь нөгөө Хэлэлцэн тохирогч улсаас орлого олсон ба эхэнд дурдсан Хэлэлцэн тохирогч улс энэхүү орлогыг тухайн аж ахуйн нэгжийн гуравдагч улсад байрлах төлөөний газарт хамаарна гэж үзсэн; ба


b) Төлөөний газарт хамаарах ашгийг эхэнд дурдсан Хэлэлцэн тохирогч улсад татвараас чөлөөлөх бол,

тухайн төлөөний газар нь эхэнд дурдсан Хэлэлцэн тохирогч улсад байрладаг байсан бол тус улсаас тухайн орлогод ногдуулах байсан татварын 60 хувиас бага татвар гуравдагч улс ногдуулах аливаа орлогын зүйлд Хамаарах татварын гэрээний давуу талууд үйлчлэхгүй.

Энэ тохиолдолд, Хамаарах татварын гэрээний аливаа бусад заалтаас үл хамааран энэ хэсгийн заалтууд үйлчилдэг аливаа орлогод нөгөө Хэлэлцэн тохирогч улсын дотоодын хуулийн дагуу татвар ногдуулна.

2. Хэрэв энэ зүйлийн 1 дэх хэсэгт тодорхойлсон Хэлэлцэн тохирогч нөгөө улсаас олсон орлогыг тухайн төлөөний газар (эдгээр үйл ажиллагаанууд нь нэг банк, даатгалын компани, эсхүл бүртгэлтэй үнэт цаасны дилер тус бүрийн эрхэлдэг банк, даатгал, эсхүл үнэт цаасны үйл ажиллагаанууд биш байх тохиолдолд тухайн аж ахуйн нэгжийн өөрийн дансанд хөрөнгө оруулалт хийх, удирдах эсхүл энгийнээр эзэмшдэг бизнесээс бусад)-аар дамжуулан хэрэгжүүлж буй аж ахуйн идэвхтэй үйл ажиллагаатай холбоотойгоор эсхүл ийм төрлийн үйл ажиллагаатай холбогдсон бол энэ зүйлийн 1 дэх хэсэг үйлчлэхгүй.

3. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн дагуу Хэлэлцэн тохирогч улсын оршин суугчийн тодорхой орлогод Хамаарах татварын гэрээний давуу талыг олгохгүй бол Хэлэлцэн



тохирогч нөгөө улсын холбогдох байгууллага тухайн оршин суугчийн хүсэлтэд үндэслэн энэ зүйлийн 1 болон 2 дахь хэсэгт заасан шаардлагыг тухайн оршин суугч хангаагүй шалтгааныг харгалзан давуу талыг олгох үндэслэлтэй гэж тогтоосон тохиролдолд Хэлэлцэн тохирогч нөгөө улсын эрх бүхий байгууллага энэхүү орлогод давуу талыг олгож болно.

Хэлэлцэн тохирогч нөгөө улсын оршин суугчийн энэ зүйлийн 1 дэх хэсгийн дагуу гаргасан хүсэлтийг хүлээн авсан Хэлэлцэн тохирогч улсын холбогдох эрх бүхий байгууллага хүсэлтийг хүлээн авах, эсхүл хүсэлтэд татгалзахаасаа өмнө Хэлэлцэн тохирогч нөгөө улсын холбогдох эрх бүхий байгууллагатай зөвлөлдөнө.

4. Гуравдагч улсад байрлах Хэлэлцэн тохирогч улсын аж ажуйн нэгжийн төлөөний газарт хамааруулах боломжтой Хэлэлцэн тохирогч нөгөө улсаас олсон Хэлэлцэн тохирогч улсын аж ахуйн нэгжийн орлогод бусад тохиолдолд олгох байсан давуу талыг хязгаарласан, эсхүл олгохоос татгалзсан Хамаарах татварын гэрээний зохицуулалтын оронд, эсхүл тийм заалт байхгүй тохиолдолд энэ зүйлийн 1-ээс 3 дахь хэсгийг хэрэглэнэ.

5. Аль нэг Оролцогч тал нь дараах тайлбар хийх эрхтэй:

а) Энэхүү зүйлийг бүхэлд нь өөрийн Хамаарах татварын гэрээнд хэрэглэхгүй байх;

б) Энэ зүйлийг бүхэлд нь 4 дэх хэсэгт заасан зохицуулалтыг агуулсан Хамаарах татварын гэрээнд хэрэглэхгүй байх;


с) Энэ зүйлийг 4 дэх хэсэгт заасан зохицуулалтыг агуулсан Хамаарах татварын гэрээнд зөвхөн хэрэглэх.

6. Энэ зүйлийн 5 дахь хэсгийн а), эсхүл б)-д заасны дагуу тайлбарыг гаргаагүй аливаа Оролцогч тал нь өөрийн Хамаарах татварын гэрээ бүр энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасан зохицуулалтыг агуулсан эсэхийг Эх хадгалагчид мэдэгдэх бөгөөд ийм заалт байгаа тохиолдолд холбогдох зүйл, заалтын дугаарын хамт мэдэгдэнэ. Хамаарах татварын гэрээний зохицуулалтын талаар бүх Хэлэлцэн тохирогч улс ийм мэдэгдэл гаргасан бол холбогдох зохицуулалт энэ зүйлийн 1-ээс 3 дахь хэсгээр солигдоно. Бусад тохиолдолд Хамаарах гэрээний зохицуулалт нь энэ зүйлийн 1—ээс 3 дахь хэсэгтэй зөрүүтэй байх тохиолдолд л зөвхөн энэ хэсэг давуу хүчинтэй үйлчилнэ.

11 дүгээр зүйл

Өөрийн оршин суугчид татвар ногдуулах аль нэг Оролцогч талын эрхийг хязгаарласан татварын гэрээг хэрэглэх

1. Хамаарах татварын гэрээний зохицуулалтын дагуу давуу тал олгохоос бусад тохиолдолд Хамаарах татварын гэрээ нь Хэлэлцэн тохирогч аливаа улсын өөрийн оршин суугчдад татвар ногдуулах эрхийг хөндөхгүй.



а) Үүний дагуу Хэлэлцэн тохирогч улс нь Хамаарах татварын гэрээний дагуу нөгөө Хэлэлцэн тохирогч улс анхны залруулга хийсний дараагаар эхэнд дурдсан Хэлэлцэн тохирогч улсын аж ахуйн нэгжид, түүний төлөөний газар, эсхүл нийлсэн аж ахуйн нэгжийн Хэлэлцэн тохирогч улсад олсон ашигт ногдуулах татварын хэмжээний талаарх холбогдох хариу залруулгыг хийх үүрэгтэй.

б) Хэлэлцэн тохирогч улсын оршин суугч хувь этгээд нь Хэлэлцэн тохирогч нөгөө улсад, эсхүл Хэлэлцэн тохирогч улсын засаг захиргааны нэгж, эсхүл бусад адилтгах нэгжид үйлчилгээ үзүүлсэнтэй холбогдуулан орлого олох тохиолдолд түүнд Хэлэлцэн тохирогч улс татвар ногдуулж байгаатай адил арга хэлбэрээр хөндөж болно;

с) Хэлэлцэн тохирогч улсын оршин суугч хувь этгээд нь Хамаарах татварын гэрээний шаардлагыг хангасан сурагч, бизнесийн дагалдан эсхүл дадлагажигч, эсхүл багш, профессор, илтгэгч, сургагч, судлаач эсхүл эрдэм шинжилгээний ажилтан байх тохиолдолд түүнд Хэлэлцэн тохирогч улс татвар ногдуулахтай адил арга хэлбэрээр хөндөж болно;


д) Үүний дагуу Хэлэлцэн тохирогч улс нь Хамаарах татварын гэрээний дагуу Хэлэлцэн тохирогч нөгөө улс татвар ногдуулж болох орлого (Хамаарах татварын гэрээний дагуу Хэлэлцэн тохирогч нөгөө улсад байрладаг төлөөний газарт хамаарч болох ашгийг багтаан) -той холбогдуулан өөрийн оршин суугчид татварын хөнгөлөлт, эсхүл чөлөөлөлт эдлүүлэх үүрэгтэй;

1. Хамаарах татварын гэрээний зохицуулалтын дагуу давуу тал олгохоос бусад тохиолдолд Хамаарах татварын гэрээ нь Хэлэлцэн тохирогч аливаа улсын өөрийн оршин суугчдад татвар ногдуулах эрхийг хөндөхгүй.

а) Үүний дагуу Хэлэлцэн тохирогч улс нь Хамаарах татварын гэрээний дагуу нөгөө Хэлэлцэн тохирогч улс анхны залруулга хийсний дараагаар эхэнд дурдсан Хэлэлцэн тохирогч улсын аж ахуйн нэгжид, түүний төлөөний газар, эсхүл нийлсэн аж ахуйн нэгжийн Хэлэлцэн тохирогч улсад олсон ашигт ногдуулах татварын хэмжээний талаарх холбогдох хариу залруулгыг хийх үүрэгтэй.

б) Хэлэлцэн тохирогч улсын оршин суугч хувь этгээд нь нөгөө Хэлэлцэн тохирогч улсад, эсхүл Хэлэлцэн тохирогч улсын засаг захиргааны нэгж, эсхүл бусад адилтгах нэгжид үйлчилгээ үзүүлсэнтэй холбогдуулан орлого олох тохиолдолд түүнд Хэлэлцэн тохирогч улс татвар ногдуулж байгаатай адил арга хэлбэрээр хөндөж болно;

с) Хэлэлцэн тохирогч улсын оршин суугч хувь этгээд нь Хамаарах татварын гэрээний шаардлагыг хангасан сурагч, бизнесийн дагалдан эсхүл дадлагажигч, эсхүл багш, профессор, илтгэгч, сургагч, судлаач эсхүл эрдэм



шинжилгээний ажилтан байх тохиолдолд түүнд Хэлэлцэн тохирогч улс татвар ногдуулахтай адил арга хэлбэрээр хөндөж болно;

d) Үүний дагуу Хэлэлцэн тохирогч улс нь Хамаарах татварын гэрээний дагуу нөгөө Хэлэлцэн тохирогч улс татвар ногдуулж болох орлого (Хамаарах татварын гэрээний дагуу Хэлэлцэн тохирогч нөгөө улсад байрладаг төлөөний газарт хамаарч болох ашгийг багтаан)-той холбогдуулан өөрийн оршин суугчдад татварын хөнгөлөлт, эсхүл чөлөөлөлт эдлүүлэх үүрэгтэй;

e) Энэ нь Хэлэлцэн тохирогч улсын оршин суугчийг Хэлэлцэн тохирогч улсын тодорхой ялгаварлан гадуурхсан татвар ногдуулах аргачлалаас хамгаална;

f) Үүний дагуу Хэлэлцэн тохирогч улсын оршин суугч нь Хамаарах татварын гэрээний дагуу татвар ногдуулаагүй учир шалтгааныг шалгуулахаар Хэлэлцэн тохирогч улсын, эсхүл нөгөө Хэлэлцэн тохирогч улсын эрх бүхий байгууллагад хүсэлтээ гаргаж болно;

g) Хэлэлцэн тохирогч улсын оршин суугч хувь хүн нь нөгөө Хэлэлцэн тохирогч улсын төлөөлөгч, эсхүл Дипломат төлөөлөгчийн газар, эсхүл Консулын төлөөлөгчийн газрын гишүүн байх тохиолдолд түүнд Хэлэлцэн тохирогч улс татвар ногдуулахтай адил арга хэлбэрээр хөндөж болно;


h) Үүний дагуу нөгөө Хэлэлцэн тохирогч улсын нийгмийн даатгалын хууль тогтоомжийн дагуу олгосон тэтгэмж, эсхүл бусад төлбөрт зөвхөн Хэлэлцэн тохирогч нөгөө улс татвар ногдуулж болно;

i) Үүний дагуу нөгөө Хэлэлцэн тохирогч улсаас олгосон тэтгэмж болон түүнтэй адил төлбөрүүд, тэтгэвэр, гэрлэлт цуцалсны тэтгэмж, эсхүл бусад тэтгэмжийн төлбөрүүдэд зөвхөн нөгөө Хэлэлцэн тохирогч улс татвар ногдуулж болно; эсхүл

j) Хэлэлцэн тохирогч улсын өөрийн оршин суугчид татвар ногдуулах эрхийг санаатайгаар хязгаарласан, эсхүл Хэлэлцэн тохирогч улсаас үүсэлтэй орлогод Хэлэлцэн тохирогч улс татвар ногдуулах тусгай эрхтэй гэдгийг тодорхой заасан.

2. Хамаарах татварын хэлэлцээр нь Хэлэлцэн тохирогч улс өөрийн оршин суугчид татвар ногдуулахад нөлөөлөхгүй хэмээн заасан Хамаарах татварын гэрээний зохицуулалтын оронд, эсхүл тийм зохицуулалт байхгүй тохиолдолд энэ зүйлийн 1 дэх хэсгийг хэрэглэнэ.

3. Аль нэг Оролцогч тал нь дараах тайлбарыг хийх эрхтэй:



а) Энэ зүйлийг бүхэлд нь өөрийн Хамаарах татварын гэрээнд хэрэглэхгүй байх;

б) Энэ зүйлийн 2 дахь хэсэг заасан зохицуулалтыг агуулсан өөрийн Хамаарах татварын гэрээнд энэ зүйлийг бүхэлд нь хэрэглэхгүй байх.

4. Энэ зүйлийн 3 дахь хэсгийн а), эсхүл б)-д заасан тайлбарыг гаргаагүй аливаа Оролцогч тал бүр өөрийн Хамаарах татварын гэрээнд энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан зохицуулалтыг агуулсан эсэхийг мөн агуулсан тохиолдолд эдгээр Хамаарах татварын гэрээний холбогдох зүйл, заалтын дугаарын хамт Эх хадгалагчид мэдэгдэнэ.

Хамаарах татварын гэрээний зохицуулалтын талаар бүх Хэлэлцэн тохирогч улс ийм мэдэгдэл гаргасан бол холбогдох зохицуулалт нь энэ зүйлийн 1 дэх хэсгээр солигдоно.

Бусад тохиолдолд Хамаарах гэрээний зохицуулалт нь энэ зүйлийн 1—ээс 3 дахь хэсэгтэй зөрчилдсөн тохиолдолд л зөвхөн энэ энэ зүйлийн 1 дэх хэсгийг хэрэглэнэ.

4 ДҮГЭЭР БҮЛЭГ

ТӨЛӨӨНИЙ ГАЗАР ҮҮСГЭХЭЭС ЗАЙЛСХИЙХ


12 дугаар зүйл

Төлөөлөн гүйцэтгэгчээр болон төстэй аргаар төлөөний газар үүсгэхээс хиймлээр зайлсхийх

1. “Төлөөний газар” гэсэн нэр томъёог тодорхойлсон Хамаарах татварын гэрээний зохицуулалтыг үл харгалзан, энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу аливаа этгээд нь аж ахуйн нэгжийн нэрийн өмнөөс Хамаарах татварын гэрээний Хэлэлцэн тохирогч улсад үйл ажиллагаа явуулдаг бөгөөд ингэхдээ байнга гэрээ байгуулдаг, тухайн аж ахуйн нэгжээс агуулгын өөрчлөлт оруулахгүйгээр тогтмол байгуулдаг гэрээг байгуулахад голлох үүрэг гүйцэтгэдэг ба эдгээр гэрээ нь:

- а) Тухайн аж ахуйн нэгжийн нэрийн өмнөөс; эсхүл
- б) Тухайн аж ахуйн нэгжийн эзэмшил, эсхүл ашиглалтад байгаа үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг шилжүүлэх, эсхүл ашиглах эрхээ олгох чиглэсэн; эсхүл
- с) Тухайн аж ахуйн нэгжээс үйлчилгээ үзүүлэхэд чиглэсэн,

тухайн аж ахуйн нэгжийн өмнөөс дээрх этгээдийн хийсэн үйл ажиллагаа нь нөгөө Хэлэлцэн тохирогч улсад байрлах тогтсон газраар дамжуулан явуулсан боловч Хамаарах татварын гэрээний (энэ конвенцоор өөрчлөгдсөн хувилбар) төлөөний газрын тухай тодорхойлолтын хүрээнд уг тогтсон байрлал нь төлөөний газар



болохгүйгээс бусдаар тухайн аж ахуйн нэгж нь нөгөө Хэлэлцэн тохирогч улсад төлөөний газартайд тооцогдоно.

2. Хамаарах татварын гэрээний Хэлэлцэн тохирогч улсын нутаг дэвсгэрт нөгөө Хэлэлцэн тохирогч улсын аж ахуйн нэгжийн өмнөөс үйл ажиллагаа явуулдаг этгээд эхэнд дурдсан Хэлэлцэн тохирогч улсад бие даасан агентын хувиар үйл ажиллагаа эрхэлдэг бөгөөд тухайн аж ахуйн нэрийн өмнөөс бизнесийн байнгын үйл ажиллагаа явуулдаг бол энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасныг хэрэглэхгүй. Харин аливаа этгээд нь дан ганц, эсхүл бараг дан ганц нэг болон хэд хэдэн харилцан хамаарал бүхий аж ахуйн нэгжийн өмнөөс үйл ажиллагаа явуулдаг бол тухайн этгээд нь энэ хэсгийн утгын хүрээнд аливаа тухайлсан аж ахуйн нэгжийн бие даасан агентад тооцогдохгүй.

3. а) Энэ зүйлийн 1 дэх хэсгийг аж ахуйн нэгжийн нэрийн өмнөөс бие даасан агентаас бусад этгээдийн явуулдаг үйл ажиллагаатай холбогдуулан тухайн аж ахуйн нэгжийг нөгөө Хэлэлцэн тохирогч улсад Төлөөлөгчийн газартай гэж тооцох (эсхүл тухайн этгээдийг Хэлэлцэн тохирогч нөгөө улсад байрлах Төлөөлөгчийн газар гэж тооцох) нөхцөлийг заасан Хамаарах татварын гэрээний зохицуулалтын оронд зөвхөн тухайн этгээд тус Хэлэлцэн тохирогч улсад дээрх аж ахуй нэгжийн нэрийн өмнөөс гэрээ байгуулахад төлөөлөх эрхтэй бөгөөд уг эрхээ байнга хэрэгжүүлэх нөхцөлийн талаар заасан Хамаарах гэрээний зохицуулалтын хүрээнд хэрэглэнэ.


б) Энэ зүйлийн 2 дахь хэсгийг аж ахуйн нэгжийн өмнөөс бие даасан агентын явуулдаг үйл ажиллагаатай холбогдуулан тухайн аж ахуйн нэгжийг Хэлэлцэн тохирогч улсад Төлөөлөгчийн газартай гэж тооцохгүй талаар заасан Хамаарах татварын гэрээний зохицуулалтын оронд хэрэглэнэ.

4. Аливаа Оролцогч тал энэ зүйлийг бүхэлд нь өөрийн Хамаарах татварын гэрээнд хэрэглэхгүй байх эрхтэй.

5. Энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу тайлбар хийгээгүй Оролцогч тал бүр өөрийн Хамаарах татварын гэрээ тус бүр энэ зүйлийн 3 дахь хэсгийн а)-д заасан зохицуулалтыг агуулсан эсэхийг зохицуулалтын зүйл, заалтын дугаарын хамт хадгалагчид мэдэгдэнэ. Хэлэлцэн тохирогч бүх улс тухайн зохицуулалттай холбоотой ийм мэдэгдэл гаргасан тохиолдолд зөвхөн энэ зүйлийн 1 дэх хэсгийг хэрэглэнэ.

6. Энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу тайлбар хийгээгүй Оролцогч тал бүр өөрийн Хамаарах татварын гэрээ тус бүр энэ зүйлийн 3 дахь хэсгийн б)-д заасан зохицуулалтыг агуулсан эсэхийг зохицуулалтын зүйл, заалтын дугаарын хамт хадгалагчид мэдэгдэнэ.

Бүх Хэлэлцэн тохирогч улс тухайн зохицуулалттай холбоотой ийм мэдэгдэл гаргасан тохиолдолд зөвхөн энэ зүйлийн 2 дахь хэсгийг заасныг хэрэглэнэ.



13 дугаар зүйл

Тодорхой үйл ажиллагаанд хамаарах татварын чөлөөлөлтийг ашиглах замаар төлөөний газар үүсгэхээс санаатайгаар зайлсхийх

1. Аливаа Оролцогч тал нь энэ зүйлийн 2 дахь хэсэг (Хувилбар А), 3 дахь хэсэг (Хувилбар В) -ийг хэрэглэхээр сонгох, эсхүл эдгээр хувилбарын алийг ч хэрэглэхгүй байхаар сонгож болно.

Хувилбар А

2. "Төлөөний газар" гэдэг нэр томъёог тодорхойлсон Хамаарах татварын гэрээний зохицуулалтыг үл харгалзан дараах тохиолдлыг "Төлөөний газар" гэдэг нэр томъёонд хамааруулахгүй. Үүнд:

а) Үйл ажиллагаа нь бэлтгэх, эсхүл туслах шинж чанартай байх гэсэн Төлөөний газрын статус олгохоос татгалзах нөхцөлийг хангасан эсэхийг үл харгалзан, Төлөөний газарт тооцохгүй байхаар Хамаарах татварын гэрээ (энэхүү конвенцоор өөрчлөлт оруулахаас өмнө)-нд тусгайлан заасан үйл ажиллагаа;

б) Энэ хэсгийн а)-д заагаагүй аливаа үйл ажиллагааг тухайн аж ахуйн нэрийн өмнөөс явуулах дан ганц зорилготой аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тогтсон газар;

с) Энэ хэсгийн а) болон б)-д заасан аливаа үйл ажиллагаануудыг тухайн аж ахуйн нэгжийн нэрийн өмнөөс явуулах дан ганц зорилготой аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тогтсон газар,

Хэрэв тухайн үйл ажиллагаа, эсхүл энэ хэсгийн с)-д заасан аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тогтсон газрын үйл ажиллагаа нь бүхэлдээ бэлтгэх, туслах шинж чанартай бол.

Хувилбар В

3. "Төлөөний газар" гэдэг нэр томъёог тодорхойлсон Хамаарах татварын гэрээний заалтуудыг үл харгалзан дараах тохиолдлыг "Төлөөний газар" гэдэг нэр томъёонд хамааруулахгүй. Үүнд:

а) Тодорхой үйл ажиллагаа нь бэлтгэх, эсхүл туслах шинж чанартай бол Төлөөний газарт тооцохгүй гэж тодорхой заасан Хамаарах татварын гэрээний холбогдох зохицуултаас бусад, үйл ажиллагаа нь бэлтгэх, эсхүл туслах шинж чанартай байх гэсэн Төлөөний газрын статус олгохоос татгалзах нөхцөлийг хангасан эсэхийг үл харгалзан, Төлөөний газарт тооцохгүй байхаар Хамаарах татварын гэрээ (энэхүү конвенцоор өөрчлөлт оруулахаас өмнө)-нд тусгайлан заасан үйл ажиллагаа;



b) Энэ хэсгийн а)-д заагаагүй үйл ажиллагаа нь бэлтгэх, эсхүл туслах шинж чанартай бол түүнийг тухайн аж ахуйн нэгжийн нэрийн өмнөөс явуулах дан ганц зорилготой аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тогтсон газар;

с) Энэ хэсгийн а) болон б)-д заасан үйл ажиллагаануудаас үүссэн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тогтсон газрын нийт үйл ажиллагаа нь бэлтгэх, эсхүл туслах шинж чанартай бол түүнийг явуулах дан ганц зорилготой аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тогтсон газар.

4. Аль нэг аж ахуйн нэгж, эсхүл түүнтэй харилцан хамаарал бүхий аж ахуйн нэгж Хэлэлцэн тохирогч нэг улсад нэг газар, эсхүл өөр өөр газарт аж ахуйн үйл ажиллагаа явуулдаг бол тухайн аж ахуйн нэгжийн ашиглаж, эсхүл үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа эрхлэх тогтсон газрын хувьд тодорхой үйл ажиллагааг Төлөөний газарт тооцохгүй байхаар заасан Хамаарах татварын гэрээний заалт (Энэ зүйлийн 2 болон 3 дугаар хэсэгт зааснаар өөрчлөгдсөн байж болох) үйлчлэхгүй бөгөөд ингэхдээ:

а)Төлөөний газрыг тодорхойлсон Хамаарах татварын заалтын дагуу тухайн аж ахуйн нэгж, эсхүл түүнтэй харилцан хамаарал бүхий аж ахуйн нэгжийн хувьд төлөөний газар гэж тооцох газар эсхүл бусад газар; эсхүл

б) Нэг газарт хоёр аж ахуйн нэгж явуулсан, эсхүл хоёр газарт нэг аж ахуйн нэгж, эсхүл түүнтэй харилцан хамаарал бүхий аж ахуйн нэгжүүд явуулсан аж ахуйн үйл ажиллагаа нь нэгдмэл аж ахуйн үйл ажиллагааны нэг хэсэг болсон нэмэгдэл чиг үүргийг бүрдүүлдэг бол нэг газарт хоёр аж ахуйн нэгжийн явуулсан, эсхүл хоёр газарт нэг аж ахуйн нэгж, эсхүл түүнтэй харилцан хамаарал бүхий аж ахуйн нэгжүүдийн явуулсан үйл ажиллагаануудаас үүссэн бэлтгэх, эсхүл туслах шинж чанаргүй нийт үйл ажиллагаа;

5. а) Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тогтсон газраар (эсхүл Хамрагдах татварын гэрээний ижил үйлчлэлтэй заалтууд) дамжуулан үйл ажиллагаа явуулж байгаа хэдий ч тодорхой үйл ажиллагааг төлөөний газарт тооцохгүй гэсэн Хамаарах татварын гэрээний заалтуудын холбогдох хэсгийн оронд энэ зүйлийн 2, эсхүл 3 дахь хэсгийг хэрэглэнэ.

б) Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тогтсон газраар (эсхүл Хамрагдсан татварын гэрээний ижил үйлчлэлтэй заалтууд) дамжуулан үйл ажиллагаа явуулж байгаа хэдий ч тодорхой үйл ажиллагааг төлөөний газар тооцохгүй гэсэн Хамаарах татварын гэрээний (энэ зүйлийн 2 эсхүл 3 дахь хэсгээр өөрчлөгдсөн байж болох) заалтуудад энэ зүйлийн 4 дэх хэсгийг хэрэглэнэ.

6. Аль нэг Оролцогч тал нь дараах тайлбар хийх эрхтэй:

а) Энэ зүйлийг бүхэлд нь өөрийн Хамаарах татварын гэрээнд хэрэглэхгүй;



б) Энэ зүйлийн 2 дахь хэсгийн б) заалтыг үйл ажиллагаа бүр нь бэлтгэх, эсхүл туслах шинж чанартай байх тохиолдолд л төлөөний газарт тооцохгүй гэж үзсэн үйл ажиллагааны жагсаалтыг илэрхий агуулсан Хамаарах татварын гэрээнд хэрэглэхгүй;

с) Энэ зүйлийн 4 дэх хэсгийг өөрийн Хамаарах татварын гэрээнд хэрэглэхгүй.

7. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн дагуу аль нэг Хувилбарыг хэрэглэхээр сонгосон аливаа Оролцогч тал нь хадгалагчид энэ тухайгаа мэдэгдэнэ. Энэ зүйлийн 5 дахь хэсгийн а)-д заасан зохицуулалтыг агуулсан өөрийн Хамаарах татварын гэрээний жагсаалтыг, мөн ийм зохицуулалт бүхий зүйл, заалтын дугаарыг энэхүү мэдэгдэлд тусгана. Хэлэлцэн тохирогч бүх улс ижил Хувилбар хэрэглэхээр сонгосон ба энэ зохицуулалттай холбогдох мэдэгдлийг гаргасан тохиолдолд зөвхөн аль нэг Хувилбарыг Хамаарах татварын гэрээний холбогдох заалтын хувьд хэрэглэнэ.


8. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн дагуу аль нэг Хувилбарыг хэрэглэхээр сонгоогүй бөгөөд энэ зүйлийн 6 дахь хэсгийн а) эсхүл с)-д заасны дагуу тайлбар хийгээгүй аливаа Оролцогч тал нь өөрийн Хамаарах татварын гэрээ бүр нь энэ зүйлийн 5 дахь хэсгийн б)-д заасан зохицуулалтыг агуулсан эсэх, мөн тус ийм зохицуулалт бүрийн зүйл, заалтын дугаарыг хадгалагчид мэдэгдэнэ.

Энэ зүйлийн 7 дугаар хэсэг, эсхүл энэ хэсгийн дагуу Хэлэлцэн тохиролч бүх улс өөрийн Хамаарах татварын гэрээний зохицуулалттай холбогдуулан мэдэгдэл хийсэн тохиолдолд зөвхөн энэ зүйлийн 4 дэх хэсгийг Хамаарах татварын гэрээний зохицуулалттай холбогдуулан хэрэглэнэ.

14 дүгээр зүйл Гэрээ хуваах

1. Аливаа хугацаа (эсхүл хугацаанууд)-ны дараа тодорхой төсөл, эсхүл үйл ажиллагааг Төлөөний газарт тооцохоор заасан Хамаарах татварын гэрээний зохицуулалтын дагуу тухайн хугацаа (эсхүл хугацаанууд) хэтэрсэн эсэхийг тогтоох дан ганц зорилгоор:

а) Хэлэлцэн тохирогч нэг улсын аж ахуйн нэгж Хэлэлцэн тохирогч нөгөө улсад барилгын талбай, барилга угсралт, суурьлуулалт, эсхүл Хамаарах татварын гэрээний холбогдох заалтад тодорхойлсон тодорхой төсөл болох газарт үйл ажиллагаа явуулж буй, эсхүл ийм газартай холбоотойгоор удирдах, эсхүл зөвлөх үйл ажиллагаа эрхлэж байгаа бол, Хамаарах татварын гэрээний зохицуулалтаар ийм үйл ажиллагаа болон үйл ажиллагаануудыг Хамаарах татварын гэрээний холбогдох заалтад заасан хугацаа, эсхүл хугацаануудыг хэтрүүлэхгүйгээр явуулсан боловч тэдгээрийн үргэлжлэх нэг, эсхүл түүнээс дээш хугацаа нь нийтдээ 30 өдрөөс хэтэрсэн бол; болон



b) Эхний дурдсан аж ахуйн нэгжтэй харилцан хамаарал бүхий нэг, эсхүл хэд хэдэн аж ахуйн нэгжийн өөр өөр цаг хугацаанд нөгөө Хэлэлцэн тохирогч улсад хийсэн тухайлсан барилгын талбай, барилга угсралт, суурьлуулалтын (эсхүл, Хамаарах татварын гэрээний холбогдох заалтын удирдлагын үйл ажиллагаа, зөвлөгөө) эсхүл Хамаарах татварын гэрээний холбогдох заалтад тодорхойлсон тодорхой төсөл болох газарт хийсэн хоорондоо холбоотой үйл ажиллагаанууд тус бүр нь 30 хоног хэтэрсэн бол, эдгээр өөр өөр цаг хугацаа нь эхний дурдсан аж ахуйн нэгж тухайн барилгын талбай, барилга угсралт, суурьлуулалтын ажлыг, эсхүл Хамаарах татварын гэрээний холбогдох заалтад тодорхойлсон төсөл болох бусад газарт ажил хийсэн хугацаанд тохио эдгээр хугацааны нийлбэрээр тооцно.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт тодорхойлсон тодорхой төсөл, хөтөлбөрийн гэрээний үйл ажиллагааг хувааж, олон хэсэг болгосноор цаг хугацааны шалгуурын хувьд төлөөний газар болохоос зайлсхийхийг хязгаарлах тухай Хамаарах татварын гэрээний заалтын оронд, эсхүл байхгүй үед энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасныг хэрэгжүүлнэ.

3. Аль нэг Оролцогч тал дараах тайлбар хийх эрхтэй:

a) Энэ зүйлийг бүхэлд нь өөрийн Хамаарах татварын гэрээнд хэрэглэхгүй;

b) Энэхүү зүйлийг бүхэлд нь байгалийн баялгийн хайгуул, эсхүл олборлолттой холбогдох Хамаарах татварын гэрээний заалтуудын хувьд хэрэглэхгүй.

4. Энэ зүйлийн 3 дахь хэсгийн a)-д заасны дагуу тайлбар хийгээгүй аливаа Оролцогч тал өөрийн Хамаарах татварын гэрээнд энэ зүйлийн 3 дахь хэсгийн b)-д заасны дагуу тайлбарт хамаарахгүй бөгөөд 2 дахь хэсэгт заасан зохицуулалтыг агуулсан эсэх, ийм зохицуулалт агуулсан бол түүний зүйл, заалтын дугаарын хамт хадгалагчид мэдэгдэнэ.


Хэлэлцэн тохирогч улсууд Хамаарах татварын гэрээний холбогдох заалтад ийнхүү тайлбар хийсэн тохиолдолд энэ холбогдох заалтыг энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу мөн зүйлийн 1 дэх хэсгээр солигдоно.

Бусад тохиолдолд Хамаарах татварын гэрээний зохицуулалт энэ зүйлийн 1 дэх хэсэгтэй зөрчилдөх тохиолдолд энэ зүйлийн 1 дэх хэсгийг хэрэглэнэ.

15 дугаар зүйл

Аж ахуйн нэгжтэй харилцан хамаарал бүхий этгээдийг тодорхойлох

1. Энэ конвенцын 12 дугаар зүйл (Төлөөлөн гүйцэтгэгчээр болон төстэй аргаар төлөөний газар үүсгэхээс хиймлээр зайлсхийх)-ийн 2 дахь хэсэг, 13 дугаар зүйл (Тодорхой үйл ажиллагаанд хамаарах татварын чөлөөлөлтийг ашиглах замаар төлөөний газар үүсгэхээс санаатайгаар зайлсхийх)-ийн 4 дэх хэсэг, эсхүл 14 дүгээр



зүйл (Гэрээ хуваах)-ийн 1 дэх хэсгийн дагуу өөрчлөгдсөн Хамаарах татварын гэрээний зохицуулалтын зорилгоор холбогдох бүх баримт болон нөхцөл байдлыг харгалзан нэг этгээд нэг аж ахуйн нэгжийг, эсхүл нэг аж ахуйн нэгж нэг этгээдийг удирддаг, эсхүл хоёулаа нэг этгээд, эсхүл аж ахуйн нэгжийн удирдлага дор байдаг бол тухайн этгээдийг аж ахуйн нэгжтэй харилцан хамаарал бүхий гэнэ.

Аль ч тохиолдолд, нэг этгээд нь нөгөө этгээдийн хөрөнгийн эрхийн 50-аас илүү хувийг (эсхүл компанийн нийт саналын эрх, хувьцаа, эцсийн эзэмшигчдийн өмчийн 50-аас илүү хувийг) шууд болон шууд бусаар эзэмшдэг, эсхүл өөр этгээд нь тухайн этгээд болон аж ахуйн нэгжийн өгөөжийн ашиг сонирхлын 50-аас илүү хувийг (эсхүл, компанийн нийт саналын эрх, хувьцаа, эцсийн эзэмшигчдийн өмчийн 50-аас илүү хувийг) шууд болон шууд бусаар эзэмшдэг тохиолдолд, этгээд нь аж ахуйн нэгжтэй харилцан хамаарал бүхийд тооцогдоно.

2. Энэ конвенцын 12 дугаар зүйл (Төлөөлөн гүйцэтгэгчээр болон төстэй аргаар төлөөний газар үүсгэхээс хиймлээр зайлсхийх)-ийн 4 дэх хэсэг, 13 дугаар зүйл (Тодорхой үйл ажиллагаанд хамаарах татварын чөлөөлөлтийг ашиглах замаар төлөөний газар үүсгэхээс санаатайгаар зайлсхийх)- ийн 6 дахь хэсгийн а) эсхүл с), болон 14 дүгээр зүйл (Гэрээ хуваах)-ийн 3 дахь хэсгийн а) –д заасан тайлбар хийсэн аливаа Оролцогч тал нь эдгээр тайлбар үйлчлэх Хамаарах татварын гэрээнд энэ зүйлийг бүхэлд нь хэрэглэхгүй гэж тайлбар хийж болно.

5 ДУГААР БҮЛЭГ

МАРГААН ШИЙДВЭРЛЭЛТИЙГ САЙЖРУУЛАХ

16 дугаар зүйл

Харилцан тохиролцох ажиллагаа

1. Аливаа этгээд нь Хэлэлцэн тохирогч нэг, эсхүл тухайн хоёр улсаас авсан арга хэмжээ нь Хамаарах татварын гэрээнд нийцээгүй татвар ногдуулах, эсхүл ногдуулахад хүргэж байна гэж үзвэл тухайн этгээд Хэлэлцэн тохирогч улсуудын дотоодын хууль тогтоомжид заасан эрх зүйн хамгаалалтуудыг үл харгалзан Хэлэлцэн тохирогч аль ч улсын эрх бүхий байгууллагад гомдол гаргаж болно.

Хамаарах татварын гэрээнд нийцээгүй татвар ногдуулахад хүргэж буй арга хэмжээний талаарх анхны мэдэгдлээс хойш гурван жилийн дотор гомдол гаргана.

2. Эрх бүхий байгууллага нь татгалзлыг үндэслэлтэй үзэж байгаа бөгөөд шаардлага хангасан шийдэлд өөрөө хүрч чадахгүй бол Хамаарах татварын гэрээнд нийцээгүй татвар ногдуулахгүй байх зорилгоор Хэлэлцэн тохирогч нөгөө улсын эрх бүхий байгууллагатай харилцан тохиролцох замаар гомдлыг шийдвэрлэхээр хүчин чармайлт гаргана.

Аливаа тохиролцоог Хэлэлцэн тохирогч улсуудын дотоодын хууль тогтоомжид заасан цаг хугацааны хязгаарлалтыг үл харгалзан хэрэгжүүлнэ.

Монгол Улсын Гадаад харилцааны яам
АЛБАН ЁСНЫ ОРЧУУЛГА МӨН

31

Гарын үсэг /Signature *Ж.С*

2023 оны 10 сарын 16 өдөр
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs of Mongolia
OFFICIAL TRANSLATION

i) Энэ зүйлийн 1 болон 4 дэх хэсгийн “энэ конвенц Хамаарах татварын гэрээний Хэлэлцэн тохирогч улс бүрийн хувьд хүчин төгөлдөр болсон хамгийн сүүлчийн өдөр” гэснийг; ба

ii) Энэ зүйлийн 5 дахь хэсгийн “гэрээний жагсаалтын өргөтгөлийн мэдэгдлийн тухай хадгалагч мэдэгдсэн өдөр” гэснийг;

“Хамаарах татварын тодорхой гэрээтэй холбогдуулан энэхүү конвенцыг хүчин төгөлдөр үйлчлэхэд шаардлагатай дотоодын процедураа дуусгасан тухай 35 дугаар зүйл (Хүчин төгөлдөр үйлчлэх)-ийн 7 дахь хэсэгт заасан тайлбарыг хийсэн Хэлэлцэн тохирогч улс бүрээс гаргасан мэдэгдлийн сүүлийн мэдэгдлийг хадгалагч хүлээн авснаас хойш 30 дахь хоног» гэснээр солих;

iii) Энэ конвенцын 28 дугаар зүйл (Тайлбар)-ийн 9 дэх хэсгийн а)-д “тайлбарыг эгүүлэн авсан, эсхүл солисныг хадгалагч мэдэгдсэн өдөр” гэснийг; ба


iv) Энэ конвенцын 28 дугаар зүйл (Тайлбар)-ийн 9 дэх хэсгийн б)-д “тухайн Хэлэлцэн тохирогч улсуудын хувьд конвенц хүчин төгөлдөр болсон хамгийн сүүлчийн өдөр” гэснийг;

“Хамаарах татварын холбогдох гэрээнд хийсэн тайлбарыг эгүүлэн авах, эсхүл өөрчлөлтийг хүчин төгөлдөр үйлчлэхэд шаардлагатай дотоодын процедураа дуусгасан тухай 35 дугаар зүйл (Хүчин төгөлдөр үйлчлэх)-ийн 7 дахь хэсэгт заасан тайлбар хийсэн Хэлэлцэн тохирогч улс бүрээс гаргасан мэдэгдлийн хамгийн сүүлчийн мэдэгдлийг хадгалагч хүлээн авсан өдрөөс хойш 30 дахь хоног” гэсэн хэсгээр;

v) Энэ конвенцын 29 дүгээр зүйл (Мэдэгдэл хийх)-ийн 6 дахь хэсгийн а)-д заасан “нэмэлт мэдэгдлийг хадгалагч мэдэгдсэн өдөр” гэснийг; ба
vi) Энэ конвенцын 29 дүгээр зүйл (Мэдэгдэл хийх)-ийн 6 дахь хэсгийн б)-ийн “тухайн Хэлэлцэн тохирогч улсуудын хувьд конвенц хүчин төгөлдөр болсон хамгийн сүүлчийн өдөр” гэснийг;

“Тухайн хамаарах татварын гэрээнд холбогдох нэмэлт мэдэгдлийг хүчин төгөлдөр үйлчлэхэд шаардлагатай дотоодын процедураа дуусгасан тухай 35 дугаар зүйл (Хүчин төгөлдөр үйлчлэх)-ийн 7 дахь хэсэгт заасан тайлбар хийсэн Хэлэлцэн тохирогч улс бүрээс гаргасан мэдэгдлийн хамгийн сүүлчийн мэдэгдлийг хадгалагч хүлээн авсан өдрөөс хойш 30 дахь өдөр” гэсэн хэсгээр;

vii) 36 дугаар зүйл (6 дугаар бүлэг хүчин төгөлдөр үйлчлэх)-ийн 1 болон 2 дахь хэсгийн “Хамаарах татварын гэрээний Хэлэлцэн тохирогч улс тус бүрийн хувьд энэ конвенц хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш” гэснийг; “Хамаарах татварын холбогдох гэрээний хувьд энэ конвенц хүчин төгөлдөр үйлчлэхэд шаардлагатай дотоодын процедураа



3. Хэлэлцэн тохирогч улсуудын эрх бүхий байгууллагууд нь Хамаарах татварын гэрээг тайлбарлах, эсхүл хэрэгжүүлэхтэй холбогдуулан гарсан аливаа хүндрэл, эсхүл эргэлзээг харилцан тохиролцох замаар шийдвэрлэхээр хүчин чармайлт гаргана. Эрх бүхий байгууллагууд нь Хамаарах татварын гэрээнд заагаагүй давхар татварыг арилгах зорилгоор хамтран зөвлөлдөж болно.


4. а)

i) Аливаа этгээд нь Хэлэлцэн тохирогч нэг, эсхүл хоёр улсаас авсан арга хэмжээний улмаас Хамаарах татварын гэрээнд нийцээгүй татварыг түүнд ногдуулсан, эсхүл ногдуулна гэж үзвэл тухайн этгээд нь тэдгээр Хэлэлцэн тохирогч улсуудын дотоодын хууль тогтоомжид заасан эрх зүйн хамгаалалтуудыг үл харгалзан тухайн асуудлаар оршин суугаа Хэлэлцэн тохирогч улсын эрх бүхий байгууллагад гомдол гаргаж болох ба хэрэв тухайн этгээдийн гаргасан гомдол нь иргэний харьяаллаар ялгаварлан гадуурхахгүй байх зарчимтай холбогдох Хамаарах татварын гэрээний заалтад хамаарах тохиолдолд уг гомдлыг тухайн этгээдийн харьяалах Хэлэлцэн тохирогч улсын эрх бүхий байгууллагад гаргана гэж заасан Хамаарах татварын гэрээний заалтын оронд, эсхүл тийм заалт байхгүй байх нөхцөлд энэ зүйлийн 1 дэх хэсгийн эхний өгүүлбэрийг хэрэглэнэ.

ii) Энэ зүйлийн 1 дэх хэсгийн хоёр дахь өгүүлбэрийг мөн зүйлийн эхний өгүүлбэрт заасан гомдлыг Хамрагдах татварын гэрээнд нийцээгүй татвар ногдуулахад хүргэж буй арга хэмжээний талаар анх мэдсэнээс хойш гурван жилийн дотор гаргах ёстой гэсэн Хамаарах татварын гэрээний заалтын оронд, эсхүл Хамаарах татварын гэрээнд гомдлыг багтаан гаргах ёстой цаг хугацааг тодорхойлсон заалт байхгүй үед хэрэглэнэ.

b) i) Эрх бүхий байгууллага нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан этгээдийн гаргасан гомдлыг үндэслэлтэй гэж үзэж байгаа бөгөөд шаардлага хангасан шийдвэрийг өөрөө гаргах боломжгүй бол нөгөө Хэлэлцэн тохирогч улсын эрх бүхий байгууллагатай харилцан тохиролцож, Хамаарах татварын гэрээнд нийцээгүй татвар ногдуулахгүй байхаар гомдлыг шийдвэрлэхийг эрмэлзэнэ гэсэн Хамаарах татварын гэрээний заалт байхгүй үед энэ зүйлийн 2 дахь хэсгийн эхний өгүүлбэрийг хэрэглэнэ.

ii) Энэ зүйлийн 2 дахь хэсгийн хоёр дахь өгүүлбэрийг аливаа тохиролцоог Хэлэлцэн тохирогч улсуудын дотоодын хууль тогтоомжид заасан цаг хугацааны хязгаарлалтыг үл харгалзан хэрэгжүүлнэ гэсэн Хамаарах татварын гэрээний заалт байхгүй үед хэрэглэнэ.



с) i) Энэ зүйлийн 3 дахь хэсгийн эхний өгүүлбэрийг Хэлэлцэн тохирогч улсуудын эрх бүхий байгууллагууд нь Хамаарах татварын гэрээг хэрэглэх, эсхүл тайлбарлахад гарсан эргэлзээ болон бэрхшээлтэй асуудлуудыг харилцан тохиролцох замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ гэсэн Хамаарах татварын гэрээний заалт байхгүй үед хэрэглэнэ.

ii) Энэ зүйлийн 3 дахь хэсгийн хоёр дахь өгүүлбэрийг мөн түүнчлэн Хамаарах татварын гэрээнд зохицуулаагүй давхар татварын асуудлыг арилгах зорилгоор Хэлэлцэн тохирогч улсын эрх бүхий байгууллагууд хамтран зөвлөлдөж болно гэсэн Хамаарах татварын гэрээний заалт байхгүй үед хэрэглэнэ.

5. Аль нэг Оролцогч тал нь дараах тайлбар хийх эрхтэй:

а) Өөрийн Хамаарах татварын гэрээ тус бүр (аль нэг этгээдийг аль ч Хэлэлцэн тохирогч улсын эрх бүхий байгууллагад гомдол гаргахыг зөвшөөрсөн Хамаарах татварын гэрээнээс бусад)-д аль нэг этгээд Хэлэлцэн тохирогч нэг, эсхүл хоёр улсаас авсан арга хэмжээний улмаас Хамаарах татварын гэрээнд заагдаагүй татварыг түүнд ногдуулсан, эсхүл ногдуулахад хүргэж байна гэж үзсэн тухайн этгээд нь тэдгээр Хэлэлцэн тохирогч улсуудын дотоодын хууль тогтоомжид заасан эрх зүйн хамгаалалтыг үл харгалзан уг асуудлаар өөрийн оршин суугаа Хэлэлцэн тохирогч улсынхаа эрх бүхий байгууллагад гомдол гаргах эрхтэй, эсхүл тухайн этгээдийн гаргасан гомдол нь иргэний харьяаллаар ялгаварлан гадуурхахгүй байхтай холбоотой Хамаарах татварын гэрээний зохицуулалтад хамаарах тохиолдолд уг гомдлыг өөрийн харьяалах Хэлэлцэн тохирогч улсын эрх бүхий байгууллагад гаргах эрхтэй; тухайн Хэлэлцэн тохирогч улсын эрх бүхий байгууллага нь татвар төлөгчийн эсэргүүцлийг хууль ёсны гэж үзэхгүй байгаа бөгөөд харилцан тохиролцох ажиллагааны зүйл болох гомдлыг хүлээн авсан Хэлэлцэн тохирогч нөгөө улсын эрх бүхий байгууллагатай уг гомдлын талаар хоёр талын мэдэгдэл, эсхүл зөвлөлгөөний үйл ажиллагааг хэрэгжүүлнэ гэж зааснаар Хэлэлцэн тохирогч улс BEPS-ийн багцын дагуу маргаан шийдвэрлэлтийг сайжруулах хамгийн доод стандартыг хангахыг эрмэлзэж байгаа учраас өөрийн Хамаарах татварын гэрээнд энэ зүйлийн 1 дэх хэсгийн эхний өгүүлбэрийг хэрэглэхгүй байх;

б) Бүх Хамаарах татварын гэрээнүүдийн зорилгоор энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан татвар төлөгч Хамаарах татварын гэрээнд нийцээгүй татвар ногдуулахад хүргэж буй арга хэмжээний тухай анхны мэдэгдлээс хойш хамгийн багадаа 3 жилийн дотор гомдол эрхтэй болохыг баталгаажуулах замаар BEPS-ийн багцын дагуу маргаан шийдвэрлэлтийг сайжруулах хамгийн доод стандартад нийцүүлэх үндэслэлээр энэ зүйлийн 1 дэх хэсгийн эхний өгүүлбэрт заасан гомдлыг гаргах тодорхой хугацаа заагаагүй өөрийн Хамаарах татварын гэрээнүүдэд энэ зүйлийн 1 дэх хэсгийн хоёр дахь өгүүлбэрийг хэрэглэхгүй байх;

Монгол Улсын Гадаад харилцааны яам
АЛБАН ЁСНЫ ОРЧУУЛГА МӨН

Гарын үсэг /Signature/ *М.С* 33

2023 оны 10 сарын 16 өдөр
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs of Mongolia
OFFICIAL TRANSLATION

с) Өөрийн Хамаарах татварын гэрээний зорилгыг үндэслэн өөрийн Хамаарах татварын гэрээнүүдэд энэ зүйлийн 2 дахь хэсгийн хоёр дахь өгүүлбэрийг хэрэглэхгүй байх, үүнд:

i) Харилцан тохиролцох ажиллагааны замаар хүрсэн аливаа тохиролцоог Хэлэлцэн тохирогч улсуудын дотоодын хууль тогтоомжид заасан аливаа цаг хугацааны хязгаарыг үл харгалзан хэрэгжүүлнэ; эсхүл

ii) өөрийн хоёр талт гэрээний талаарх хэлэлцээнд дараах гэрээний зохицуулалтыг хүлээн зөвшөөрөх замаар BEPS-ийн багцын дагуу маргаан шийдвэрлэлтийг сайжруулах хамгийн доод стандартыг хангахыг эрмэлзэнэ.

А) аль нэг Хэлэлцэн тохирогч улсын аж ахуйн нэгжийн төлөөний газарт тухайн ашгийг хамааруулан тооцож болох байсан татварын жилийн эцсээс Хэлэлцэн тохирогч хоёр улс хооронд харилцан тохиролцсон хугацаа өнгөрсний дараа Хэлэлцэн тохирогч талууд тухайн төлөөний газарт хамааруулан тооцож болох ашигт залруулга хийхгүй (хууран мэхлэх, хайхрамжгүй байдал эсхүл санаатайгаар гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдлуудад энэ заалтыг хэрэглэхгүй); ба

В) Аль нэг аж ахуйн нэгж ашиг орсон байх татварын жилийн эцсээс Хэлэлцэн тохирогч хоёр улсын харилцан тохиролцсон хугацаа өнгөрсний дараа Хэлэлцэн тохирогч улсууд тухайн аж ахуйн нэгжийн олох байсан хэдий ч Хамаарах татварын гэрээний хамаарал бүхий аж ахуйн нэгжтэй холбогдох заалтад дурдсан нөхцөлөөс шалтгаалан олоогүй ашгийг тухайн аж ахуйн нэгжийн ашигт тооцохгүй бөгөөд татвар ногдуулахгүй.(хууран мэхлэх, хайхрамжгүй байдал эсхүл санаатайгаар гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдлуудад энэ заалтыг хэрэглэхгүй).

6. а) Энэ зүйлийн 5 дахь хэсгийн а)-д заасны дагуу тайлбарыг хийгээгүй аливаа Оролцогч тал энэ зүйлийн 4 дэх хэсгийн а) заалтын i) дэд заалтад тодорхойлсон зохицуулалтыг өөрийн Хамаарах татварын гэрээ агуулсан эсэхийг, мөн агуулсан бол уг зохицуулалтын зүйл, заалтын дугаарыг эх хадгалагчид мэдэгдэнэ. Хэлэлцэн тохирогч бүх улс Хамаарах татварын гэрээний аль нэг зохицуулалттай холбоотой мэдэгдэл хийсэн бол уг зохицуулалт энэ зүйлийн 1 дэх хэсгийн эхний өгүүлбэрээр солигдоно. Бусад тохиолдолд энэ зүйлийн 1 дэх хэсгийн эхний өгүүлбэр нь зөвхөн тухайн өгүүлбэртэй таарахгүй Хамаарах Татварын Гэрээний заалтуудыг хүчингүй болгоно.

Монгол Улсын Гадаад харилцааны яам
АЛБАН ЁСНЫ ОРЧУУЛГА МӨН

Гарын үсэг /Signature. *Ж.С.* 34

2023 оны 10 сарын 16 өдөр
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs of Mongolia
OFFICIAL TRANSLATION

b) Энэ зүйлийн 5 дахь хэсгийн b)-д заасны дагуу тайлбар хийгээгүй аливаа Оролцогч тал дараах зүйлсийг эх хадгалагчид мэдэгдэнэ. Үүнд:

i) Хамаарах татварын гэрээнд нийцээгүй татвар ногдуулахад хүргэж буй арга хэмжээний тухай эхний мэдэгдлээс хойш 3 жилээс богино тодорхой хугацаанд энэ зүйлийн 1 дэх хэсгийн эхний өгүүлбэрт дурдсан гомдлыг гаргасан байх ёстой гэсэн зохицуулалтыг агуулж байгаа өөрийн Хамаарах татварын гэрээний жагсаалтыг, мөн энэхүү зохицуулалтын зүйл болон заалтын дугаарыг; Үүнтэй холбогдуулан Хамаарах татварын гэрээний Хэлэлцэн тохирогч бүх улс холбогдох мэдэгдлийг гаргасан бол энэ зүйлийн 1 дэх хэсгийн хоёр дахь өгүүлбэрээр Хамаарах татварын гэрээний холбогдох зохицуулалт солигдоно; бусад тохиолдолд энэ зүйлийн 6 дахь хэсгийн b)-гийн ii)-т заасны дагуу зөвхөн энэ зүйлийн 1 дэх хэсгийн хоёр дахь өгүүлбэр нь зөвхөн тухайн өгүүлбэртэй таарахгүй байгаа Хамаарах татварын гэрээний заалтуудыг хүчингүй болгоно.


ii) Хамаарах татварын гэрээнд нийцээгүй татвар ногдуулахад хүргэж буй арга хэмжээний тухай эхний мэдэгдлээс хойш хамгийн багадаа 3 жилийн дотор тодорхой хугацаанд энэ зүйлийн 1 дэх хэсгийн эхний өгүүлбэрт дурдсан гомдлыг гаргасан байх ёстой гэсэн зохицуулалтыг агуулж байгаа өөрийн Хамаарах татварын гэрээний жагсаалтыг, мөн ийм зохицуулалт бүрийн зүйл болон заалтын дугаарыг; Үүнтэй холбогдуулан Хамаарах татварын гэрээний Хэлэлцэн тохирогч аль нэг улс холбогдох мэдэгдлийг гаргасан бол энэ зүйлийн 1 дэх хэсгийн хоёр дахь өгүүлбэр тухайн Хамаарах татварын гэрээнд үйлчлэхгүй.

c) Аливаа Оролцогч тал дараах зүйлийг эх хадгалагчид мэдэгдэнэ. Үүнд::

i) Энэ зүйлийн 4 дэх хэсгийн b)-гийн i)-д заасан зохицуулалтыг агуулаагүй өөрийн Хамаарах татварын гэрээний жагсаалт; Аль нэг Хамаарах татварын гэрээтэй холбогдуулан Хэлэлцэн тохирогч бүх улс ийм мэдэгдэл гаргасан бол энэ зүйлийн 2 дахь хэсгийн эхний өгүүлбэрийг зөвхөн тухайн Хамаарах татварын гэрээнд хэрэглэнэ;

ii) Энэ зүйлийн 5 дахь хэсгийн c)-д заасны дагуу тайлбар хийгээгүй тохиолдолд энэ зүйлийн 4 дэх хэсгийн b)-гийн ii)-г заасан зохицуулалтыг агуулаагүй өөрийн Хамаарах татварын гэрээнүүдийн жагсаалт; Аль нэг Хамаарах татварын гэрээтэй холбогдуулан Хэлэлцэн тохирогч бүх улс ийм мэдэгдэл гаргасан бол энэ зүйлийн 2 дахь хэсгийн хоёр дахь өгүүлбэрийг зөвхөн тухайн Хамаарах татварын гэрээнд хэрэглэнэ.

d) Аль нэг Оролцогч тал дараах зүйлийг хадгалагчид мэдэгдэнэ. Үүнд:



i) Энэ зүйлийн 4 дэх хэсгийн с)-гийн i)-т заасан зохицуулалтыг агуулаагүй өөрийн Хамаарах татварын гэрээний жагсаалт; аль нэг Хамаарах татварын гэрээтэй холбогдуулан Хэлэлцэн тохирогч бүх улс ийм мэдэгдэл гаргасан бол энэ зүйлийн 3 дахь хэсгийн эхний өгүүлбэрийг зөвхөн тухайн Хамаарах татварын гэрээнд хэрэглэнэ.

ii) Энэ зүйлийн 4 дэх хэсгийн с)-гийн ii)-т заасан зохицуулалтыг агуулаагүй өөрийн Хамаарах татварын гэрээний жагсаалтыг; Хамаарах татварын гэрээтэй холбогдуулан Хэлэлцэн тохирогч бүх улс ийм мэдэгдэл гаргасан бол энэ зүйлийн 3 дахь хэсгийн хоёр дахь өгүүлбэрийг зөвхөн тухайн Хамаарах татварын гэрээнд хэрэглэнэ.

17 дугаар зүйл

Харилцан тохируулга хийх


1. Аль нэг Хэлэлцэн тохирогч улс нь нөгөө Хэлэлцэн тохирогч улсын аль нэг аж ахуйн нэгжийн нөгөө Хэлэлцэн тохирогч улсад татвар ногдуулсан ашгийг өөрийн аль нэг аж ахуйн нэгжийн ашигт хамааруулан тооцож, татвар ногдуулсан бөгөөд ийнхүү хамааруулан тооцсон ашиг нь хоёр аж ахуйн нэгжийн хооронд харилцан тохиролцсон нөхцөл нь бие даасан аж ахуйн нэгжүүдийн өөр хоорондоо харилцан тохиролцсон нөхцөлтэй адил байх үед эхэнд дурдсан Хэлэлцэн тохирогч улсын аж ахуйн нэгжийн олох байсан ашиг бол Хэлэлцэн тохирогч нөгөө улс тухайн ашигт өөрийн улсад ногдуулан төлөх татварын хэмжээнд зохих тохируулгыг хийнэ. Ийм тохиргоог тодорхойлохдоо Хамаарах татварын гэрээний бусад зохицуулалтыг харгалзан үзэх ба шаардлагатай тохиолдолд Хэлэлцэн тохирогч улсуудын эрх бүхий байгууллагууд хоорондоо зөвлөлдөнө.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсгийг Хэлэлцэн тохирогч нөгөө улс Хэлэлцэн тохирогч улсын аж ахуйн нэгжийн ашгийг өөрийн аж ахуйн нэгжийн ашигт хамааруулан тооцож татвар ногдуулсан бөгөөд ийнхүү хамааруулан тооцсон ашиг нь хоёр аж ахуйн нэгж хооронд тохиролцсон нөхцөл, бие даасан аж ахуйн нэгжүүд өөр хоорондоо тохиролцсон нөхцөлтэй адил байх үед Хэлэлцэн тохирогч нөгөө улсын аж ахуйн нэгжийн олох байсан ашиг бол Хэлэлцэн тохирогч улсын аж ахуйн нэгжийн ашигт Хэлэлцэн тохирогч улсад ногдуулсан татварын хэмжээнд зохих тохируулга хийх Хэлэлцэн тохирогч улсын үүргийн тухай зохицуулалтын оронд, эсхүл байхгүй тохиолдолд хэрэглэнэ.

3. Аль нэг Оролцогч тал нь дараах тайлбар хийх эрхтэй:

а) Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан зохицуулалтыг агуулсан өөрийн Хамаарах татварын гэрээнүүдэд энэ зүйлийг бүхэлд нь хэрэглэхгүй байх;

б) Энэ зүйлийг бүхэлд нь өөрийн Хамаарах татварын гэрээнд энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан аль нэг зохицуулалт байхгүй учир өөрийн Хамаарах татварын гэрээнд хэрэглэхгүй байх;



i) Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан зохих тохиргоог хийнэ; эсхүл

ii) Түүний эрх бүхий байгууллага харилцан тохиролцох ажиллагаатай холбогдох Хамаарах татварын гэрээний зохицуулалтын дагуу гомдлыг шийдвэрлэхээр хүчин чармайлт гаргана;

с) 16 дугаар зүйл (Харилцан тохиролцох ажиллагаа)-ийн 5 дахь хэсгийн с)-гийн ii)-т заасны дагуу тайлбар хийсэн аль нэг Оролцогч талын хувьд Хэлэлцэн тохирогч улсууд энэ зүйлийн 1 дэх хэсэгт агуулагдсан төрлийн гэрээний зохицуулалт болон 16 дугаар зүйл (Харилцан тохиролцох ажиллагаа)-ийн 5 дахь хэсгийн с)-гийн ii)-т заасан зохицуулалтын талаар тохиролцоонд хүрэх боломжтой бол энэ зүйлийн 1 дэх хэсэгт агуулагдсан төрлийн гэрээний зохицуулалтыг хоёр талт гэрээний хэлэлцээний хүрээнд хүлээн зөвшөөрч байгаа учир энэ зүйлийг бүхэлд нь өөрсдийн Хамаарах татварын гэрээнд хэрэглэхгүй.

4. Энэ зүйлийн 3 дахь хэсгийн дагуу тайлбар хийгээгүй аливаа Оролцогч тал өөрийн Хамаарах татварын гэрээнд энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан зохицуулалтыг агуулсан эсэхийг, мөн агуулсан бол зохицуулалт тус бүрийн зүйл болон заалтын дугаарыг эх хадгалагчид мэдэгдэнэ. Хэлэлцэн тохирогч бүх улс өөрийн Хамаарах татварын гэрээний зохицуулалттай холбоотой ийм мэдэгдэл гаргасан бол уг заалт энэ зүйлийн 1 дэх хэсгээр солигдоно. Бусад тохиолдолд Хамаарах татварын гэрээний зохицуулалтууд энэ зүйлийн 1 дэх хэсэгтэй нийцэхгүй байх хүрээнд энэ зүйлийн 1 дэх хэсэг тэдгээр зохицуулалтыг хүчингүй болгоно.

6 ДУГААР БҮЛЭГ

АРБИТР

18 дугаар зүйл

6 дугаар бүлгийг хэрэглэх хувилбар


Аль нэг Оролцогч тал нь энэ бүлгийг өөрийн Хамаарах татварын гэрээнд хэрэглэхээр сонгож болох бөгөөд энэ тухайгаа эх хадгалагчид мэдэгдэнэ. Хэлэлцэн тохирогч хоёр улс хоёулаа ийм мэдэгдэл гаргасан бол энэ бүлгийг зөвхөн тухайн Хамаарах татварын гэрээтэй холбоотой Хэлэлцэн тохирогч хоёр улсын хувьд хэрэглэнэ.

19 дүгээр зүйл

Арбитрын шийдвэрийг заавал дагаж мөрдөх нөхцөл

1. Хэрэв:

а) Аливаа этгээд нь аль нэг, эсхүл хоёр Хэлэлцэн тохирогч улсаас авсан арга хэмжээний улмаас Хамаарах татварын гэрээ (энэхүү конвенцоор өөрчлөлт орсон хувилбараар)-нд нийцээгүй татварыг түүнд ногдуулахад хүргэнэ, эсхүл



ногдуулна гэж үзвэл тухайн этгээд аль нэг Хэлэлцэн тохирогч улсын эрх бүхий байгууллагад гомдол гаргах эрхтэй гэсэн Хамаарах татварын гэрээ (16 дугаар зүйл (Харилцан тохиролцох ажиллагаа)-ийн 1 дэх хэсгийн дагуу өөрчлөлт орсон хувилбар) -ний заалтын дагуу аль нэг, эсхүл хоёр Хэлэлцэн тохирогч улсаа авсан арга хэмжээ нь Хамаарах татварын гэрээ (энэхүү конвенцоор өөрчлөлт орсон хувилбараар) –нд нийцээгүй татвар ногдуулсан учраас Хэлэлцэн тохирогч улсын эрх бүхий байгууллагад гомдол гаргасан тохиолдолд; болон

b) Аль нэг Хэлэлцэн тохирогч улсын эрх бүхий байгууллага нь Хэлэлцэн тохирогч нөгөө улсын эрх бүхий байгууллагатай харилцан зөвшилцөх замаар тухайн гомдлыг шийдвэрлэхээр хүчин чармайлт гаргана гэсэн Хамаарах татварын гэрээ (16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн дагуу өөрчлөгдсөн хувилбараар)-ний зохицуулалтын дагуу эрх бүхий байгууллагууд нь энэ зүйлийн 8 дахь хэсэг, эсхүл тухайн нөхцөлөөс хамаарч 9 дэх хэсэгт заасан эхлэх хугацаанаас хоёр жилийн дотор (Хэлэлцэн тохирогч улсуудын эрх бүхий байгууллагууд энэхүү хугацааг дуусгавар болохоос өмнө тухайн гомдлыг шийдвэрлэх өөр хугацаа тохиролцсон бөгөөд энэ тухайгаа гомдол гаргасан этгээдэд мэдэгдснээс бусад тохиолдолд) гомдлыг шийдвэрлэхээр харилцан тохиролцож чадаагүй бол

Тухайн этгээдийн бичгээр хүсэлт гаргасан хүсэлтийн дагуу гомдлоос үүдэлтэй шийдвэрлэгдээгүй үлдсэн аливаа асуудлуудыг энэ бүлэгт заасан аргаар, энэ зүйлийн 10 дахь хэсгийн дагуу Хэлэлцэн тохирогч улсуудын эрх бүхий байгууллагуудын харилцан тохиролцсон дүрэм болон журмын дагуу Арбитрт шилжүүлнэ.

2. Аль нэг эрх бүхий байгууллагаас нэг, эсхүл түүнээс олон ижил асуудалтай холбоотой гомдол нь шүүх, эсхүл захиргааны хэргийн шүүхэд шилжсэн гэсэн шалтгаанаар энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан харилцан тохиролцох ажиллагааг түр зогсоосон тохиолдолд шүүх, эсхүл захиргааны шүүхийн эцсийн шийдвэр гарах хүртэл, эсхүл гомдлыг буцаах, эсхүл түр зогсоох хүртэл энэ зүйлийн 1 дэх хэсгийн b)-д заасан хугацааг зогсооно.

Мөн түүнчлэн гомдол гаргасан этгээд болон эрх бүхий байгууллага нь харилцан тохиролцох ажиллагааг зогсоохоор тохиролцсон бол харилцан тохирох ажиллагааг үргэлжлүүлэх хүртэл энэ зүйлийн 1 дэх хэсгийн b)-д заасан хугацааг түр зогсооно.

Мөн түүнчлэн гомдол гаргасан этгээд болон эрх бүхий байгууллага нь харилцан тохиролцох ажиллагааг зогсоохоор тохиролцсон бол харилцан тохирох ажиллагааг үргэлжлүүлэх хүртэл энэ зүйлийн 1 дэх хэсгийн b)-д заасан хугацааг түр зогсооно.

3. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн b)-д заасан хугацаа эхэлсний дараа тухайн гомдолтой шууд хамааралтай аливаа этгээд хоёр талын эрх бүхий байгууллагаас шаардсан нэмэлт мэдээллийг хугацаанд нь гаргаж өгөөгүй гэдэгт хоёр талын эрх бүхий байгууллагууд санал нэгтэй байгаа бол энэ зүйлийн 1 дэх хэсгийн b)-д заасан

Монгол Улсын Гадаад харилцааны яам
АЛБАН ЁСНЫ ОРЧУУЛГА МӨН

38

Гарын үсэг /Signature/ *М.С.*

2023 оны 10 сарын 16 өдөр
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs of Mongolia
OFFICIAL TRANSLATION

хугацаа нь мэдээлэл шаардсан өдрөөс эхлэн мэдээлэл гаргаж өгсөн өдөр хүртэлх хугацаагаар сунгагдана.

4. а) Арбитрт гаргасан асуудалтай холбогдох арбитрын шийдвэрийг энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан гомдолтой холбогдох харилцан тохиролцох журмын дагуу хэрэгжүүлнэ. Уг арбитрын шийдвэр эцсийн шийдвэр байна.

б) Дор дурдсанаас бусад тохиолдолд Хэлэлцэн тохирогч хоёр улс арбитрын шийдвэрийг заавал дагаж мөрдөнө. Үүнд:

i) Тухайн гомдолд шууд хамааралтай этгээд нь арбитрын шийдвэрийг хэрэгжүүлэх харилцан тохиролцоог хүлээн зөвшөөрөхгүй бол. Ийм тохиолдолд уг гомдлыг тухайн эрх бүхий байгууллага үргэлжлүүлэн хэлэлцэхгүй. Гомдол шууд хамааралтай тухайн этгээдэд гомдлын тухай арбитрын шийдвэрийг хэрэгжүүлэх харилцан тохиролцооны мэдэгдлийг хүргүүлснээс хойш 60 хоногийн дотор тухайн этгээд нь арбитрын шийдвэрийг хэрэгжүүлэх харилцан тохиролцоонд дурдсан шийдвэрлэгдсэн асуудлыг шүүх эсхүл захиргааны шүүхээр хэлэлцүүлэхээс татгалзаагүй, эсхүл ийм асуудалтай холбоотой явцдаа байгаа шүүх, эсхүл захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг харилцан тохиролцоонд нийцсэн байдлаар дуусгавар болгоогүй тохиолдолд арбитрын шийдвэрийг хэрэгжүүлэх харилцан тохиролцоог гомдолд шууд хамааралтай тухайн этгээд хүлээн зөвшөөрөөгүй гэж үзнэ.


ii) Аль нэг Хэлэлцэн тохирогч улсын шүүх арбитрын шийдвэрийг хүчингүй гэж шийдвэр гаргасан бол. Ийм тохиолдолд энэ зүйлийн 1 дэх хэсгийн дагуу арбитрт гаргасан хүсэлтийг гаргаагүйд тооцох ба арбитрын ажиллагааг явуулаагүй гэж тооцно (21 (Арбитрын шүүх ажиллагааны нууцлал) ба 25 (Арбитрын үйл ажиллагааны зардал)-ын зорилгоос гадна). Ийм тохиолдолд эрх бүхий этгээдүүд арбитрт дахин хүсэлт гаргахыг зөвшөөрөх ёсгүй гэж тохиролцсоноос бусад тохиолдолд арбитрт дахин хүсэлт гаргаж болно.

iii) Гомдолд шууд хамааралтай этгээд нь арбитрын шийдвэрийг хэрэгжүүлэх харилцан тохиролцоогоор шийдвэрлэгдсэн асуудлаар шүүхэд эсхүл захиргааны шүүхэд нэхэмжлэл гаргах тохиолдолд.

5. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн а)-д тодорхойлсон харилцан тохиролцох ажиллагааны анхны хүсэлтийг хүлээн авсан эрх бүхий байгууллага нь хүсэлтийг хүлээн авснаас хойш хуанлийн хоёр сарын дотор дараах зүйлийг мэдэгдэнэ:

а) Гомдол гаргасан этгээдэд хүсэлт хүлээн авсан тухай мэдэгдэнэ; мөн

б) Хүсэлтийн мэдэгдлийг хуулбарын хамт нөгөө Хэлэлцэн тохирогч улсын эрх бүхий байгууллагад хүргүүлнэ. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн а)-д тодорхойлсон харилцан тохирох журмын анхны хүсэлтийг хүлээн авсан эрх бүхий байгууллага нь хүсэлтийг хүлээн авснаас хойш хуанлийн хоёр сарын дотор:



6. Эрх бүхий байгууллага нь харилцан тохиролцох ажиллагааны хүсэлтийг хүлээн авснаас (эсхүл түүний хуулбарыг нөгөө Хэлэлцэн тохирогч улсын эрх бүхий этгээд хүлээн авснаас) хойш хуанлийн гурван сарын дотор:

а) Тухайн гомдлыг хянан шийдвэрлэхэд шаардлагатай мэдээллийг хүлээн авсан тухайгаа гомдол гаргасан этгээд болон нөгөө эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ; эсхүл

б) Дээр дурдсан зорилгоор тухайн этгээдээс нэмэлт мэдээлэл шаардана.

7. Энэ зүйлийн 6 дахь хэсгийн б)-д заасны дагуу, нэг эсхүл аль аль эрх бүхий байгууллага нь тухайн гомдол гаргасан этгээдээс гомдлыг хянан шийдвэрлэхэд шаардлагатай нэмэлт мэдээлэл хүссэн тохиолдолд, нэмэлт мэдээлэл хүссэн эрх бүхий байгууллага нь нэмэлт мэдээллийг тухайн этгээдээс хүлээн авснаас хойш хуанлийн гурван сарын дотор тухайн этгээдэд болон нөгөө эрх бүхий байгууллагад:

а) Шаардсан мэдээллээ хүлээн авсан тухай; эсхүл

б) Шаардсан мэдээллийн зарим хэсэг нь дутуу байгаа тухай мэдэгдэнэ.

8. Хоёр талын эрх бүхий байгууллагууд энэ зүйлийн 6 дахь хэсгийн б)-д заасны дагуу нэмэлт мэдээлэл шаардаагүй бол энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан эхлэх хугацаа нь дараах хоёр өдрөөс өмнө байна. Үүнд:


а) Хоёр талын эрх бүхий байгууллагууд энэ зүйлийн 6 дахь хэсгийн а)-д заасны дагуу гомдол гаргасан этгээдэд мэдэгдэл хүргүүлсэн өдөр; ба

б) Энэ зүйлийн 5 дахь хэсгийн б)-д заасны дагуу нөгөө Хэлэлцэн тохирогч улсын эрх бүхий байгууллагад мэдэгдсэнээс хойш хуанлийн гурван сарын дараагийн өдөр.

9. Энэ зүйлийн 6 дахь хэсгийн б)-д заасны дагуу нэмэлт мэдээлэл шаардсан бол энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан эхлэх хугацаа нь дараах хоёр өдрөөс эрт байна. Үүнд:

а) Нэмэлт мэдээлэл шаардсан эрх бүхий байгууллага гомдол гаргасан этгээд болон нөгөө талын эрх бүхий байгууллагад энэ зүйлийн 7 дахь хэсгийн а)-д заасны дагуу мэдэгдэл хүргүүлсэн хамгийн сүүлчийн өдөр; ба

б) Аль нэг эрх бүхий байгууллагын гомдол гаргасан этгээдээс шаардсан бүх мэдээллийг хоёр талын эрх бүхий байгууллагууд хүлээн авснаас хойш хуанлийн гурван сарын дараагийн өдөр.



Нэг талын, эсхүл хоёр талын эрх бүхий байгууллага энэ зүйлийн 7 дахь хэсгийн б)-д заасны дагуу мэдэгдэл хүргүүлсэн бол энэ нь энэ зүйлийн 6 дахь хэсгийн б)-д заасны дагуу нэмэлт мэдээллийн шаардлага гэж тооцно.

10. Хэлэлцэн тохирогч улсуудын эрх бүхий байгууллагууд харилцан тохиролцох замаар (харилцан тохиролцох ажиллагаатай холбоотой Хамаарах татварын гэрээний зүйлийн дагуу) энэ бүлгийг хэрхэн хэрэглэх, мөн гомдол хянан шийдвэрлэхэд эрх бүхий байгууллагад хамгийн багадаа ямар мэдээлэл шаардлагатай болох асуудлыг зохицуулна.

Энэхүү зохицуулалтыг гомдлын хүрээнд шийдвэрлэгдээгүй асуудлуудыг арбитра анх шилжүүлэх боломжтой болсон өдрөөс болон түүнээс хойш өөрчлөгдөж болзошгүй хугацаанаас өмнө хийнэ.

11. Аль нэг Оролцогч тал нь энэ зүйлийг өөрийн Хамаарах татварын гэрээнд хэрэглэх зорилгоор энэ зүйлийн 1 дэх хэсгийн б)-д заасан хоёр жилийн хугацааг гурван жилийн хугацаагаар солих эрхтэй.

12. Аль нэг Оролцогч тал нь энэ зүйлийн бусад заалтуудыг үл харгалзан өөрийн Хамаарах татварын гэрээнд дараах дүрмийг хэрэглэх эрхтэй:

а) Харилцан тохиролцох ажиллагааны хүрээнд шийдвэрлэх, мөн өөрөөр энэ конвенцод заасан арбитраын ажиллагааны хэрэглэх хүрээнд хамаарах гомдлоос үүссэн шийдвэрлэгдээгүй аливаа асуудлыг Хэлэлцэн тохирогч аль нэг улсын шүүхээр, эсхүл захиргааны шүүхээр шийдвэрлэсэн бол түүнийг арбитра шилжүүлэхгүй.

б) Хэрэв арбитра хүсэлт гаргаснаас хойш бөгөөд арбитраын шийдвэрийг Хэлэлцэн тохирогч улсын эрх бүхий байгууллагуудад хүргүүлэхээс өмнөх аль ч хугацаанд Хэлэлцэн тохирогч аль нэг улсын шүүх, эсхүл захиргааны шүүхээр тухайн асуудлыг шийдвэрлэсэн бол уг арбитраын ажиллагааг зогсооно.


20 дугаар зүйл

Арбитрадыг томилох

1. Хэлэлцэн тохирогч улсуудын эрх бүхий байгууллагууд өөр журмыг харилцан тохиролцсоноос бусад тохиолдолд энэ бүлгийн зорилгоор энэ зүйлийн 2-4 дэх хэсгийг хэрэглэнэ.

2. Арбитраын бүрэлдэхүүний гишүүдийг томилохдоо дараах журмыг баримтална:

а) Арбитраын бүрэлдэхүүн нь олон улсын татварын асуудлаар мэргэшсэн, туршлагатай гурван гишүүнээс бүрдэнэ.



б) Аливаа эрх бүхий байгууллага нь 19 дүгээр зүйл (Арбитрын шийдвэрийг заавал дагаж мөрдөх нөхцөл)-ийн 1 дэх хэсэгт заасны дагуу арбитрын хүсэлт гаргасан өдрөөс хойш 60 хоногийн дотор бүрэлдэхүүний нэг гишүүнийг томилно. Ийнхүү томилогдсон хоёр гишүүн нь тэдгээрийн сүүлийн томилгооноос 60 хоногийн дотор Арбитрын бүрэлдэхүүнийг даргалагч гурав дахь гишүүнийг томилно. Даргалагч нь Хэлэлцэн тохирогч хоёр улсын аль нэгнийхэн иргэн, эсхүл байнгын оршин суугч байж болохгүй.

с) Арбитрын бүрэлдэхүүнд томилогдсон аливаа нь томилгоог зөвшөөрсөн хугацаанаас эхлэн Хэлэлцэн тохирогч улсуудын эрх бүхий байгууллага, татварын алба, сангийн яам болон энэ гомдолд шууд хамааралтай аливаа этгээдээс хараат бус, бие даасан байж, ажиллагааны туршид өөрийн хараат бус, бие даасан байдлаа хадгалах ба тус ажиллагаа дууссанаас хойш зохих тодорхой хугацаанд арбитрч арбитрын ажиллагаатай холбоотой арбитрчийн бие даасан, хараат бус байдалд эргэлзэхэд хүргэх аливаа зан үйлдэл хийхээс сэргийлнэ.

3. Аль нэг Хэлэлцэн тохирогч улсын эрх бүхий байгууллага нь энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан, эсхүл Хэлэлцэн тохирогч нөгөө улсын эрх бүхий байгууллагатай тохиролцсон хугацаанд багтаан арбитрын бүрэлдэхүүний гишүүнийг томилж чадаагүй тохиолдолд гишүүнийг тухайн эрх бүхий байгууллагын өмнөөс Хэлэлцэн тохирогч хоёр улсын иргэншилгүй, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Татварын бодлого, захиргааны төвийн хамгийн өндөр албан тушаалтан томилно.

4. Арбитрын бүрэлдэхүүний эхний хоёр гишүүн нь энэ зүйлийн 2 дахь хэсэгт тусгайлан заасан хугацаанд, эсхүл Хэлэлцэн тохирогч улсуудын эрх бүхий байгууллагууд харилцан тохиролцсон хугацаанд багтаан зөвлөлийн даргыг томилж чадаагүй бол даргалагчийг Хэлэлцэн тохирогч улсуудын иргэншилгүй, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Татварын бодлого, захиргааны төвийн хамгийн өндөр албан тушаалтан томилно.

21 дүгээр зүйл

Арбитрын ажиллагаанд нууцлалыг хадгалах

1. Арбитрын бүрэлдэхүүний гишүүд болон гишүүн тус бүрийн хамгийн ихдээ гурван ажилтан (мөн цаашид арбитрчаар томилогдож болох этгээд зөвхөн өөрийн арбитрчийн ур чадварын шаардлагаа биелүүлж чадахаа батлах хэмжээнд) нь харилцан мэдээлэл солилцох, нууцлал болон захиргааны туслалцаа үзүүлэхтэй холбоотой Хэлэлцэн тохирогч улсын дотоодын хууль тогтоомж, Хамаарах татварын гэрээний холбогдох зохицуулалт, түүнчлэн энэ бүлгийн зохицуулалтын зорилгоор мэдээлэлтэй танилцах эрх бүхий албан байгууллага, эсхүл эрх бүхий этгээд гэж үзнэ. Арбитрын бүрэлдэхүүн, эсхүл цаашид арбитрчаар томилогдож болох этгээдийн хүлээн авсан мэдээлэл, мөн арбитрын бүрэлдэхүүнээс эрх бүхий байгууллагын хүлээн авсан мэдээллийг харилцан мэдээлэл солилцох болон захиргааны туслалцаатай холбоотой Хамаарах татварын гэрээний заалтын дагуу харилцан солилцсон мэдээлэл гэж үзнэ.

Монгол Улсын Гадаад харилцааны яам
АЛБАН ЕСНЬ ОРЧУУЛГА МӨН

Гарын үсэг /Signature: *М.С.* 42.....

2023 оны 10 сарын 16 өдөр
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs of Mongolia
OFFICIAL TRANSLATION

2. Харилцан тохирогч улсуудын эрх бүхий этгээдүүд нь арбитрын ажиллагаанд оролцож эхлэхээс нь өмнө арбитрын бүрэлдэхүүний гишүүд болон тэдгээрийн ажилчид арбитрын ажиллагатай холбоотой аливаа мэдээлэлд Хамаарах татварын гэрээний харилцан мэдээлэл солилцох болон захиргааны туслалцааны заалтуудад заасны дагуу нууцлалтай хандана гэдгээ бичгэн хэлбэрээр баталгаажуулна.

22 дугаар зүйл

Арбитрын дүгнэлтээс өмнө хэргийг шийдвэрлэх

Энэ бүлэг болон харилцан тохиролцох замаар гомдлыг шийдвэрлэх Хамаарах татварын гэрээний зохицуулалтын зорилгоор арбитрт хүсэлт гаргаснаас хойш болон арбитрын бүрэлдэхүүнээс Хэлэлцэн тохирогч улсын эрх бүхий байгууллагад арбитрын шийдвэрийг хүргүүлэхээс өмнө гомдолтой холбогдох харилцан тохиролцох ажиллагааг болон арбитрын ажиллагааг дараах тохиолдолд зогсооно. Үүнд:

- a) Хэлэлцэн тохирогч улсуудын эрх бүхий байгууллагууд харилцан тохиролцох замаар гомдлыг шийдвэрлэсэн бол; эсхүл
- b) Гомдол гаргасан этгээд нь харилцан тохиролцох ажиллагааны хүсэлт, эсхүл арбитрын хүсэлтээсээ татгалзсан бол.

23 дугаар зүйл


Арбитрын ажиллагааны төрөл

1. Хэлэлцэн тохирогч улсуудын эрх бүхий байгууллагууд өөр дүрэм харилцан тохиролцсоноос бусад тохиолдолд арбитрын ажиллагаанд энэ зүйлийн дагуу дараах дүрмийг хэрэглэнэ:

a) Гомдлыг арбитрт гаргасны дараа Хэлэлцэн тохирогч улс бүрийн эрх бүхий байгууллага нь тухайн гомдлын шийдвэрлэгдээгүй бүх асуудлуудын тухай шийдвэрийн төслийг харилцан тохиролцсон хугацаанд арбитрын бүрэлдэхүүнд хүргүүлнэ (гомдлыг шийдвэрлэхээр Хэлэлцэн тохирогч улсын эрх бүхий байгууллага хоорондын харилцан тохиролсон өмнөх шийдвэрийг харгалзан үзнэ).

Шийдвэрийн төсөл нь гомдлын тохируулга болон төсөөтэй асуудал бүрт тодорхой мөнгөн хэмжээг тогтоосон (жишээлбэл орлого, эсхүл зарлага), эсхүл тусгайлан заасан тохиолдолд Хамаарах татварын гэрээнд заасан татварын дээд хувь хэмжээгээр хязгаарлагдана.

Хэлэлцэн тохирогч улсуудын эрх бүхий байгууллагууд нь хувь хүн нь оршин суугч эсэх, эсхүл төлөөний газар байгаа эсэх гэх мэт холбогдох Хамаарах татварын гэрээний заалтуудыг (цаашид "босго асуулт" гэх) хэрэглэх нөхцөлийн талаарх асуудлаар тохиролцоонд хүрч чадаагүй бол эрх бүхий байгууллагууд нь шийдвэр нь тухайн босго асуултаас хамаарахтай байх шийдвэрийн төслийн өөр хувилбарыг хүргүүлж болно.



b) Хэлэлцэн тохирогч улс бүрийн эрх бүхий байгууллага нь Арбитрын бүрэлдэхүүнд хэлэлцүүлэхээр байр сууриа илэрхийлсэн баримт бичгийг мөн ирүүлж болно. Шийдвэрийн төсөл, эсхүл байр сууриа илэрхийлсэн баримт бичгийг хүргүүлж буй эрх бүхий байгууллага бүр эдгээр баримт бичгийн хувийг нөгөө эрх бүхий байгууллагад шийдвэрийн төсөл, эсхүл байр сууриа илэрхийлсэн баримт бичгийг хүргүүлсэн байх ёстой хугацаанд багтаан хүргүүлнэ. Эрх бүхий байгууллага бүр тохиролцсон хугацаанд нөгөө эрх бүхий байгууллагаас ирүүлсэн шийдвэрийн төсөл болон байр сууриа илэрхийлсэн баримт бичигт холбогдох хариуг арбитрын бүрэлдэхүүнд хүргүүлнэ. Хувийг нөгөө эрх бүхий байгууллагад хариу хүргүүлсэн байх ёстой хугацаанд багтаан хүргүүлнэ.

с) Арбитрын бүрэлдэхүүн аливаа асуудал болон аливаа босго асуултуудтай холбогдуулан эрх бүхий байгууллагуудаас ирүүлсэн шийдвэрийн төслүүдийн аль нэгийг өөрийн шийдвэрээр сонгох ба тухайн шийдвэрт аливаа үндэслэл, эсхүл аливаа бусад тайлбарыг тусгахгүй. Шийдвэрийг Арбитрын бүрэлдэхүүн ердийн олонхын саналаар батална. Арбитрын бүрэлдэхүүн шийдвэрээ Хэлэлцэн тохирогч улсуудын эрх бүхий байгууллагуудад бичгээр хүргүүлнэ.


Арбитрын шийдвэрт өмнөх аливаа шийдвэрүүдийг харгалзан үзэхгүй.

2. Аливаа Оролцогч тал нь өөрийн Хамаарах татварын гэрээнд энэ зүйлийг хэрэглэх зорилгоор энэ зүйлийн 1 дэх хэсгийг өөрийн Хамаарах татварын гэрээнд хэрэглэхгүй гэж тайлбар хийх эрхтэй. Ийм тохиолдолд Хэлэлцэн тохирогч улсуудын эрх бүхий байгууллагууд өөр журам харилцан тохиролцсоноос бусад тохиолдолд арбитрын ажиллагаанд дараах журам үйлчилнэ:

a) Арбитрт гомдол гаргасны дараа Хэлэлцэн тохирогч улс бүрийн эрх бүхий байгууллагууд нь Арбитрын бүрэлдэхүүний бүх гишүүдэд арбитрын шийдвэрт шаардлагатай байж болох аливаа мэдээллийг нэн даруй гаргаж өгнө. Хэлэлцэн тохирогч улсуудын эрх бүхий байгууллагууд нь өөрөөр тохиролцоогүй бол арбитрт хүсэлт гаргахаас өмнө эрх бүхий байгууллагуудад байгаагүй аливаа мэдээллийг шийдвэр гаргахад харгалзан үзэхгүй.

b) Арбитрын бүрэлдэхүүн арбитрт гаргасан асуудлыг Хамаарах татварын гэрээний холбогдох заалтууд болон Хэлэлцэн тохирогч улсуудын дотоодын хууль тогтоомжийн дагуу эдгээр заалтуудын дагуу шийдвэрлэнэ. Арбитрын бүрэлдэхүүний гишүүд Хэлэлцэн тохирогч улсуудын эрх бүхий байгууллагууд харилцан тохиролцох замаар шууд тодорхойлсон аливаа бусад эх сурвалжийг мөн харгалзан үзнэ.

с) Арбитрын шийдвэрийг Хэлэлцэн тохирогч улсуудын эрх бүхий байгууллагуудад бичгээр хүргүүлэх бөгөөд шийдвэрт хамаарах эрх зүйн эх сурвалж, тухайн үр дүнд хүргэсэн үндэслэлийг дурдана. Арбитрын бүрэлдэхүүний гишүүдийн ердийн олонхын саналаар арбитрын шийдвэрийг



гаргана. Арбитрын шийдвэрт өмнөх аливаа шийдвэрүүдийг харгалзан үзэхгүй. Аль нэг тал нь өөрийн Хамрагдах татварын хэлэлцээрүүдэд энэ Зүйлийг хэрэглэх зорилгоор энэ зүйлийн 1 дэх хэсгийг өөрийн Хамрагдах татварын хэлэлцээрүүдэд хэрэглэхгүй байж болно. Ийм тохиолдолд Хэлэлцэн тохирогч улсуудын Эрх бүхий байгууллагууд нь өөр нөхцлөөр харилцан тохиролцсоноос бусад тохиолдолд арбитрын үйл ажиллагаанд дараах журамууд үйлчилнэ:

3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт тодорхойлсон тайлбарыг хийгээгүй аливаа Оролцогч тал нь тухайн тайлбар хийсэн Оролцогч талтай байгуулсан өөрийн Хамаарах татварын гэрээнд энэ зүйлийн 1 болон 2 дахь хэсгүүд хэрэглэхгүй гэж тайлбар хийж болно. Энэ тохиолдолд тухайн Хамаарах татварын гэрээний Хэлэлцэн тохирогч улсын эрх бүхий байгууллагууд нь тухайн Хамаарах татварын гэрээнд хэрэглэх арбитрын ажиллагааны төрлийг харилцан тохиролцохоор хүчин чармайлт гаргана. Ийм тохиролцоонд хүрэх хүртэл 19 (Арбитрыг заавал дагаж мөрдөх нөхцөл)-ийг тухайн Хамаарах татварын гэрээнд хэрэглэхгүй.


4. Аливаа Оролцогч тал нь энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасныг өөрийн Хамаарах татварын гэрээнд хэрэглэхээр сонгож болох ба энэ тухай эх хадгалагчид мэдэгдэнэ. Хамаарах татварын гэрээний Хэлэлцэн тохирогч аль нэг улс нь тухайн мэдэгдлийг хийсэн бол энэ зүйлийн 5 дахь хэсэг нь тухайн Хамаарах татварын гэрээний Хэлэлцэн тохирогч хоёр улсын хувьд үйлчилнэ.

5. Арбитрын ажиллагаа эхлэхээс өмнө Хэлэлцэн тохирогч улсуудын эрх бүхий байгууллагууд нь гомдол гаргасан аливаа этгээд болон тэдгээрийн зөвлөхүүд арбитрын ажиллагааны явцад арбитрын бүрэлдэхүүнээс, эсхүл эрх бүхий байгууллагуудын нэгнээс хүлээн авсан мэдээллээ бусад этгээдэд задруулахгүй гэдгийг бичгээр баталгаажуулна.

Арбитрт хүсэлт гаргаснаас хойш арбитрын бүрэлдэхүүн Хэлэлцэн тохирогч улсуудын эрх бүхий байгууллагад шийдвэрээ хүргүүлэх хүртэлх хугацаанд гомдол гаргасан аливаа этгээд, эсхүл тухайн этгээдийн зөвлөхүүдийн нэг нь уг тохиролцоог ноцтой зөрчсөн бол Хамаарах татварын гэрээний дагуу харилцан тохиролцоо ажиллагаа, мөн энэ бүлгийн дагуу арбитрын ажиллагааг тухайн гомдолд холбогдуулан зогсооно.

6. Энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасныг хөндөхгүйгээр энэ зүйлийн 5 дахь хэсгийг хэрэглэхээр сонгоогүй аливаа Оролцогч тал нь нэг, эсхүл түүнээс дээш Хамаарах татварын тодорхой гэрээнд, эсхүл өөрийн Хамаарах татварын бүх гэрээнд энэ зүйлийн 5 дахь хэсгийг хэрэглэхгүй гэж тайлбар хийж болно.

7. Энэ зүйлийн 5 дахь хэсгийг хэрэглэхээр сонгосон аливаа Оролцогч тал нь нөгөө Хэлэлцэн тохирогч улс энэ зүйлийн 6 дахь хэсэгт заасны дагуу тайлбар хийсэн Хамаарах татварын бүх гэрээнд энэ бүлгийг хэрэглэхгүй гэж тайлбар хийж болно.



24 дүгээр зүйл

Зөрүүтэй шийдвэр дээр тохиролцох

1. Аливаа Оролцогч тал нь өөрийн Хамаарах татварын гэрээнд энэ бүлгийг хэрэглэх зорилгоор энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасныг хэрэглэхээр сонгож болох ба энэ тухайгаа хадгалагчид мэдэгдэнэ. Хамаарах татварын гэрээний Хэлэлцэн тохирогч хоёр улс ийм мэдэгдэл гаргасан тохиолдолд энэ зүйлийн 2 дахь хэсгийг зөвхөн тухайн Хамаарах татварын гэрээнд хэрэглэнэ.
2. Энэ конвенцын 19 дүгээр зүйл (Арбитрын шийдвэрийг заавал дагаж мөрдөх нөхцөл)-ийн 4 дэх хэсгийг хөндөхгүйгээр энэ бүлгийн дагуух арбитрын шийдвэрийг аль нэг Хамаарах татварын гэрээний Хэлэлцэн тохирогч улс заавал дагаж мөрдөхгүй ба хэрэв Хэлэлцэн тохирогч улсуудын эрх бүхий байгууллага нь арбитрын шийдвэрийг тэдэнд хүргүүлснээс хойш хуанлийн гурван сарын дотор шийдвэрлэгдээгүй бүх асуудлуудыг өөрөөр шийдвэрлэхээр тохиролцсон бол арбитрын шийдвэрийг хэрэгжүүлэхгүй.
3. Энэ зүйлийн 2 дахь хэсгийг хэрэглэхээр сонгосон аливаа Оролцогч тал нь зөвхөн 23 дугаар зүйл (Арбитрын ажиллагааны төрөл)-ийн 2 дахь хэсэг үйлчлэх өөрийн Хамаарах Татварын гэрээнүүдэд энэ зүйлийн 2 дахь хэсгийг хэрэглэнэ гэж тайлбар хийж болно.

25 дугаар зүйл

Арбитрын үйл ажиллагааны зардал


Энэ бүлгийн дагуу арбитрын ажиллагаанд Арбитрын бүрэлдэхүүний гишүүдийн цалин, зардал, мөн Хэлэлцэн тохирогч улсуудад арбитрын үйл ажиллагатай холбоотой гарсан аливаа зардлыг Хэлэлцэн тохирогч улсуудын эрх бүхий байгууллага хооронд харилцан тохиролцох замаар Хэлэлцэн тохирогч улсууд гаргана.

Ийм харилцан тохиролцоонд хүрээгүй бол Хэлэлцэн тохирогч улс бүр тус тусын болон өөрсдийн томилсон бүрэлдэхүүний гишүүний зардлыг хариуцна. Хэлэлцэн тохирогч улсууд арбитрын бүрэлдэхүүнийг даргалагчийн цалин болон арбитрын ажиллагаатай холбоотой бусад зардлыг тэнцүү хариуцна.

26 дугаар зүйл

Тохирох байдал

1. Энэ конвенцын 18 дугаар зүйл (6 дугаар бүлгийг хэрэглэх хувилбар)-ийн дагуу харилцан тохиролцох ажиллагааны гомдлоос үүссэн шийдвэрлэгдээгүй үлдсэн асуудалд арбитрын ажиллагаа явуулахаар заасан Хамаарах татварын гэрээний зохицуулалтын оронд, эсхүл тийм заалт байхгүй үед энэ бүлгийн заалтуудыг хэрэглэнэ.



Энэ бүлгийг хэрэглэхээр сонгосон аливаа Оролцогч тал энэ зүйлийн 4 дэх хэсгийн дагуу хийсэн тайлбарт хамаарахгүй өөрийн Хамаарах татварын гэрээнд ийм зохицуулалт байгаа эсэх, тийм бол тухайн зохицуулалтын зүйл, заалтын дугаарыг эх хадгалагчид мэдэгдэнэ. Хэлэлцэн тохирогч хоёр улс тухайн Хамаарах татварын гэрээний зохицуулалттай холбоотой мэдэгдэл хийсэн бол уг зохицуулалтын оронд Хэлэлцэн тохирогч дээрх хоёр улсын хооронд энэ бүлгийн заалтыг хэрэглэнэ.

2. Харилцан тохиролцох ажиллагааны гомдлоос үүссэн шийдвэрлэгдээгүй үлдсэн асуудлыг заавал дагаж мөрдөх шийдвэр гаргах арбитрын ажиллагаагаар шийдвэрлэхээр заасан хоёр талт, эсхүл олон талт олон улсын гэрээний дагуу арбитрын бүрэлдэхүүн, эсхүл ижил төсөлтэй зөвлөл урьдчилан байгуулагдсан гомдолд тухайн асуудал хамаарч байгаа бол түүнийг арбитр шилжүүлэхгүй.

3. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу, Хэлэлцэн тохирогч улс оролцогч тал, эсхүл оролцогч тал болох бусад конвенцуудын дагуух харилцан тохиролцох ажиллагааны хүрээнд шийдвэрлэгдээгүй үлдсэн асуудлыг шийдвэрлэх арбитрын ажиллагаатай холбогдон гарах өргөн хүрээний үүргийн биелэлтэд энэ бүлэг бүхэлдээ нөлөөлөхгүй.

4. Аливаа Оролцогч тал нь харилцан тохирох ажиллагааны гомдлоос үүсэх шийдвэрлэгдээгүй үлдсэн асуудлыг заавал дагаж мөрдөх шийдвэр гаргах арбитрын ажиллагаагаар шийдвэрлэх зохицуулалт бүхий нэг, эсхүл түүнээс дээш Хамаарах татварын тодорхой гэрээнд (эсхүл бүх Хамаарах татварын гэрээнд) энэ бүлгийг хэрэглэхгүй байж болно.

7 ДУГААР БҮЛЭГ

ТӨГСГӨЛИЙН ЗААЛТУУД

27 дугаар зүйл


Гарын үсэг зурах, соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх эсхүл батлах

1. Энэхүү конвенц нь 2016 оны 12-р сарын 31-ний өдрөөс эхлэн дараах этгээдүүдэд гарын үсэг зурахад нээлттэй. Үүнд:

а) Бүх Улс;

б) Гернсэй (Их Британи ба Умард Ирландын Нэгдсэн Вант Улс); Айсл ов Ман (Их Британи ба Умард Ирландын Нэгдсэн Вант Улс); Жерсей (Их Британи ба Умард Ирландын Нэгдсэн Вант Улс); болон

в) Оролцогч талууд болон гэрээнд гарын үсэг зурсан тал санал нэгтгэйгээр гаргасан шийдвэрийн дагуу энэ конвенцын Оролцогч тал болох эрхтэй болсон аливаа нутаг дэвсгэр.




2. Энэхүү конвенцыг соёрхон батлах, батлах эсхүл хүлээн зөвшөөрнө.

28 дугаар зүйл


Тайлбар

1. Энэ зүйлийн 2 дахь хэсгийн дагуу энэ конвенцод зөвхөн дараах заалтад тодорхойлсон тайлбар хийхийг зөвшөөрнө:

- a) 3 дугаар зүйл (ил тод этгээдүүд) -ийн 5 дахь хэсэг;
- b) 4 дүгээр зүйл (Байнга оршин суугчийн давхар харьяалалтай этгээдүүд)-ийн 3 дахь хэсэг;
- c) 5 дугаар зүйл (Татварын давхардлыг арилгах аргуудыг хэрэглэх) -ийн 8, 9 дэх хэсэг;
- d) 6 дугаар зүйл (Хамаарах татварын гэрээний зорилго)-ийн 4 дэх хэсэг;
- e) 7 дугаар зүйл (Гэрээг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх)-ийн 15, 16 дахь хэсэг;
- f) 8 дугаар зүйл (Ногдол ашиг шилжүүлэх гүйлгээ)-ийн 3 дахь;
- g) 9 дүгээр зүйл (Этгээдийн үндсэн үнэлгээ нь үл хөдлөх хөрөнгөөс гаралтай хувь оролцоо, эсхүл хувьцаа шилжүүлснээс олсон хөрөнгийн орлого)-ийн 6 дахь хэсэг;
- h) 10 дугаар зүйл (Гуравдагч улсад байрлах төлөөний газрыг урвуулан ашиглахын эсрэг дүрэм)-ийн 5 дахь хэсэг;
- i) 11 дүгээр зүйл (Өөрийн оршин суугчид татвар ногдуулах аль нэг Оролцогч талын эрхийг хязгаарласан татварын гэрээг хэрэглэх)-ийн 3 дахь хэсэг;
- j) 12 дугаар зүйл (Төлөөний газар үүсэх явдлаас төлөөлөн гүйцэтгэгчээр дамжуулах болон төстэй арга замаар хиймлээр зайлсхийх)-ийн 4 дэх хэсэг;
- k) 13 дугаар зүйл (Тодорхой үйл ажиллагаанд хамаарах татварын чөлөөлөлтийг ашиглах замаар төлөөний газар үүсгэхээс санаатайгаар зайлсхийх)-ийн 6 дахь хэсэг;
- l) 14 дүгээр зүйл (Гэрээ хуваах)-ийн 3 дахь хэсэг;
- m) 15 дугаар зүйл (Аж ахуйн нэгжтэй харилцан хамаарал бүхий этгээдийг тодорхойлох)-ийн 2 дахь хэсэг;



- n) 16 дугаар зүйл (Харилцан тохиролцох ажиллагаа)-ийн 5 дахь хэсэг;
- o) 17 дугаар зүйл (Харилцан тохируулга хийх)-ийн 3 дахь хэсэг;
- p) 19 дүгээр зүйл (Арбитрын шийдвэрийг заавал дагаж мөрдөх нөхцөл)-ийн 11, 12 дахь хэсэг;
- q) 23 дугаар зүйл (Арбитрын ажиллагааны төрөл)-ийн 2, 3, 6, 7 дахь хэсэг;
- r) 24 дүгээр зүйл (Зөрүүтэй шийдвэр дээр тохиролцох)-ийн 3 дахь хэсэг;
- s) 26 дугаар зүйл (Тохирох байдал)-ийн 4 дэх хэсэг;
- t) 35 дугаар зүйл (Хүчин төгөлдөр үйлчлэх)-ийн 6, 7 дахь хэсэг; болон
- u) 36 дугаар зүйл (6 дугаар бүлэг хүчин төгөлдөр үйлчлэх)-ийн 2 дахь хэсэг.
2. а) Энэ зүйлийн 1 дэх хэсгийг хөндөхгүйгээр, 18 дугаар зүйл (6 дугаар бүлгийг хэрэглэх хувилбар) –ийн дагуу 6 дугаар бүлэг (Арбитр)-ийг хэрэглэхээр сонгосон аливаа Оролцогч тал нь 6 дугаар бүлэг (Арбитр)-ийн заалтын дагуу арбитрт шилжүүлж болох гомдлын цар хүрээтэй холбогдуулан нэг, эсхүл түүнээс дээш тайлбар хийж болно. 18 дугаар зүйл (6 дугаар бүлгийг хэрэглэх хувилбар)-ийн дагуу 6 дугаар бүлэг (Арбитр)-ийг хэрэглэхээр сонгосон аливаа Оролцогч тал нь энэ конвенцын Оролцогч тал болсны дараа энэхүү дэд заалтад дурдсан тайлбарыг 18 дугаар зүйл (6 дугаар бүлгийг хэрэглэх хувилбар)-ийн дагуу Оролцогч талын гаргасан мэдэгдэлтэй нэгэн зэрэг эх хадгалагчид хүргүүлнэ.
- б) а)-д заасны дагуу хийсэн тайлбаруудыг хүлээн зөвшөөрнө. Аливаа Оролцогч тал нь тайлбарын талаар хадгалагч түүнд мэдэгдснээс хойш хуанлийн арван хоёр сарын хугацаа дуусахаас өмнө, эсхүл өөрийн соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан тухай батламж бичгээ хадгалуулсан өдөр, түүний дараа уг тайлбарыг эсэргүүцэж байгаагаа эх хадгалагчид мэдэгдээгүй бол тухайн Оролцогч талыг тухайн тайлбарыг хүлээн зөвшөөрсөн гэж үзнэ. Энэ конвенцын Оролцогч тал болсны дараа 18 дугаар зүйл (6 дугаар бүлгийг хэрэглэх хувилбар)-ийн дагуу 6 дугаар бүлэг (Арбитр)-ийг хэрэглэхээр сонгосон аль нэг Оролцогч тал нь бусад Оролцогч талуудын хийсэн өмнөх тайлбаруудыг 18 дугаар зүйл (6 дугаар бүлгийг хэрэглэх хувилбар)-ийн дагуу эх хадгалагчид эхэнд дурдсан Оролцогч тал мэдэгдэл хийх үед эсэргүүлцэж болно. Аль нэг Оролцогч тал а)-д заасны дагуу хийсэн тайлбарыг эсэргүүцсэн бол 6 дугаар бүлэг (Арбитр) нь бүхэлдээ тайлбар хийсэн Оролцогч тал, тайлбарыг эсэргүүцсэн Оролцогч тал хооронд үйлчлэхгүй.
3. Энэхүү конвенцын холбогдох заалтуудад өөрөөр тодорхой заагаагүй бол энэ зүйлийн а) болон б)-д заасны дагуу хийсэн тайлбар нь:



а) Нөгөө Оролцогч талтай харилцах тайлбар хийсэн Оролцогч талын харилцаанд тухайн тайлбарт хамаарах конвенцын зохицуулалтуудыг өөрчилнө; мөн

б) Тайлбар хийсэн Оролцогч талтай харилцах нөгөө Оролцогч талын харилцаанд эдгээр зохицуулалтуудыг адил хүрээнд өөрчилнө.

4. Энэ конвенцын 27 дугаар зүйл (Гарын үсэг зурах, соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх эсхүл батлах)-ийн 1 дэх хэсгийн б) эсхүл с)-д заасны дагуу аль нэг улс, эсхүл нутаг дэвсгэр нь конвенцын Оролцогч тал биш тохиолдолд аль нэг Оролцогч тал олон улсын харилцааг нь хариуцдаг тухайн улс, эсхүл нутаг дэвсгэр, эсхүл түүний нэрийн өмнөөс байгуулсан Хамаарах татварын гэрээнд хэрэглэх тайлбаруудыг тэр хариуцсан Оролцогч тал хийх бөгөөд тайлбар нь Оролцогч талын өөрийн Хамаарах татварын гэрээнд хийсэн тайлбараас ялгаатай байж болно.

5. Энэ зүйлийн 2, 6 болон 9 дэх хэсэг, мөн 29 дүгээр зүйл (Мэдэгдэл хийх)-ийн 5 дахь хэсэгт заасны дагуу гарын үсэг зурах үед, эсхүл соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, эсхүл баталсан тухай Батламж бичгийг хадгалуулах үед тайлбаруудыг хийнэ. Энэ конвенцын Оролцогч тал болсны дараа ч гэсэн 18 дугаар зүйл (6 дугаар бүлгийг хэрэглэх хувилбар)-ийн дагуу 6 дугаар бүлэг (Арбитр)-ийг хэрэглэхээр сонгосон Оролцогч талын хувьд 18 дугаар зүйл (6 дугаар Бүлгийг хэрэглэх хувилбар)-ийн дагуу эх хадгалагчид мэдэгдлээ өгөх үедээ зэрэг энэ зүйлийн 1 дэх хэсгийн р), q), r), s)-д заасан тайлбаруудыг хийнэ.


6. Тайлбар агуулсан баримт бичигт тайлбарыг эцсийн гэж тооцохоор тодорхой зааснаас бусад тохиолдолд 29 дүгээр зүйл (Мэдэгдэл хийх)-ийн 5 дахь хэсэг, мөн энэ зүйлийн 2, 5 болон 9 дэх хэсгийн дагуу гарын үсэг зурах үед хийсэн тайлбарыг соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, эсхүл баталсан тухай Батламж бичгийг хадгалуулахдаа баталгаажуулна.

7. Гарын үсэг зурах үед тайлбар хийгээгүй бол энэ үед төлөвлөж буй тайлбарын урьдчилсан жагсаалтыг эх хадгалагчид хүргүүлнэ.

8. Дараах заалтуудын дагуу тайлбар хийх үедээ 2 дугаар зүйл (Нэр томъёоны тодорхойлолт)-ийн 1 дэх хэсгийн а) заалтын ii)-д заасны дагуу мэдэгдсэн, тайлбарт хамаарах зохицуулалтыг агуулсан (мөн энэ зүйлийн 8 дахь хэсгийн с), d) болон n)-д зааснаас бусад аливаа зохицуулалтын дагуу тайлбар хийх тохиолдолд, зохицуулалт тус бүрийн зүйл, заалтын дугаар) гэрээний жагсаалтыг хүргүүлэх ёстой. Үүнд:

а) 3 дугаар зүйл (Ил тод этгээдүүд)-ийн 5 дахь хэсгийн b), c), d), e), болон g) заалт;


б) 4 дүгээр зүйл (Байнга оршин суугчийн давхар харьяалалтай этгээдүүд)-ийн 3 дахь хэсгийн b), c), болон d) заалт;



- c) 5 дугаар зүйл (Татварын давхардлыг арилгах аргуудыг хэрэглэх)-ийн 8, 9 дэх хэсэг;
- d) 6 дугаар зүйл (Хамаарах татварын гэрээний зорилго)-ийн 4 дэх хэсэг;
- e) 7 дугаар зүйл (Гэрээг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх)-ийн 15 дахь хэсгийн b), c) заалт;
- f) 8 дугаар зүйл (Ногдол ашиг шилжүүлэх гүйлгээ)-ийн 3 дахь хэсгийн b)-гийн i), ii), iii) дэд заалт;
- g) 9 дүгээр зүйл (Этгээдийн үндсэн үнэлгээ нь үл хөдлөх хөрөнгөөс гаралтай хувь оролцоо, эсхүл хувьцаа шилжүүлснээс олсон хөрөнгийн орлого)-ийн 6 дахь хэсгийн d), e), f) заалт;
- h) 10 дугаар зүйл (Гуравдагч улсад байрлах төлөөний газрыг урвуулан ашиглахын эсрэг дүрэм)-ийн 5 дахь хэсгийн b), c) заалт;
- i) 11 дүгээр зүйл (Өөрийн оршин суугчид татвар ногдуулах аль нэг Оролцогч талын эрхийг хязгаарласан татварын гэрээг хэрэглэх)-ийн 3 дахь хэсгийн b) заалт;
- j) 13 дугаар зүйл (Тодорхой үйл ажиллагаанд хамаарах татварын чөлөөлөлтийг ашиглах замаар төлөөний газар үүсгэхээс санаатайгаар зайлсхийх)-ийн 6 дахь хэсгийн b) заалт;
- k) 14 дүгээр зүйл (Гэрээ хуваах)-ийн 3 дахь хэсгийн b) заалт;
- l) 16 дугаар зүйл (Харилцан тохиролцох ажиллагаа)-ийн 5 дахь хэсгийн b) заалт;
- m) 17 дугаар зүйл (Харилцан тохируулга хийх)-ийн 3 дахь хэсгийн a) заалт;
- n) 23 дугаар зүйл (Арбитрын ажиллагааны төрөл)-ийн 6 дахь хэсэг; мөн
- o) 26 дугаар зүйл (Тохирох байдал)-ийн 4 дэх хэсэг.

Дээрх 8 дахь хэсгийн a)-гаас o) –д заасан тайлбарыг энэхүү зүйлд заасан жагсаалтад багтаагүй аливаа Хамаарах татварын гэрээнд хэрэглэхгүй.

9. Энэ зүйлийн 1, эсхүл 2 дахь хэсгийн дагуу тайлбар хийсэн аливаа Оролцогч тал нь ямар ч үед эх хадгалагчид хүргүүсэн мэдэгдлээ эгүүлэн авах, эсхүл илүү хязгаарлагдмал тайлбараар сольж болно. Тухайн Оролцогч тал нь тайлбарыг эгүүлэн авсан, эсхүл солилсноос үүдэн 29 дугаар зүйл (Мэдэгдэл)-ийн 6 дахь хэсэгт заасны дагуу нэмэлт мэдэгдэл хийнэ. 35 дугаар зүйлийн (Хүчин төгөлдөр үйлчлэх)



ийн 7 дахь хэсэгт заасны дагуу тайлбарын буцаалт эсхүл өөрчлөлт нь доор заасан хугацаанд хүчин төгөлдөр болно:

а) Хадгалагч тайлбарыг эгүүлэн авах, эсхүл солих тухай мэдэгдлийг зөвхөн энэ конвенцын оролцогч Оролцогч талууд болох улс, эсхүл бүс нутагтай хийсэн Хамаарах татварын гэрээний дагуу хүлээн авсан үед;

i) Хадгалагч тайлбарыг эгүүлэн авах, эсхүл солих тухай мэдэгдсэн өдрөөс хойш 6 сарын дуусах хугацаа өнгөрсний дараа дараагийн жилийн 1 дүгээр сарын 1-ний өдөр, эсхүл түүнээс хойш тухайн татвар үүсэх тохиолдолд эх үүсвэрээс суутгагдсан татварын тухай заалтуудтай холбоотой тайлбаруудад зориулан; мөн


ii) Хадгалагч тайлбарыг эгүүлэн авах, эсхүл солих тухай мэдэгдсэн өдрөөс хойш зургаан сарын хугацаа өнгөрсний дараа дараагийн жилийн 1 дугаар сарын 1-ний өдөр буюу түүнээс хойш эхлэх татвар ногдуулах хугацааны дагуу ногдуулсан татваруудын ба бусад бүх заалтуудтай холбоотой тайлбаруудын; ба

б) Хадгалагч эгүүлэн авах, эсхүл өөрчилсөн тухай мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш нэг, эсхүл түүнээс дээш Хэлэлцэн тохирогч улс нь энэ конвенцын Оролцогч тал болсон Хамаарах татварын гэрээнд тухайн Хэлэлцэн тохирогч улс тус бүрийн хувьд конвенц хүчин төгөлдөр болсон хамгийн сүүлчийн өдөр.

29 дүгээр зүйл Мэдэгдэл

1. Энэ зүйлийн 5 болон 6 дахь хэсэг, 35 дугаар зүйл (Хүчин төгөлдөр үйлчлэх)-ийн 7 дахь хэсэгт заасны дагуу, гарын үсэг зурах үед, эсхүл соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, эсхүл баталсан тухай Батламж бичгийг хадлгалуулах үед дараах заалтуудын дагуу мэдэгдэл хийнэ. Үүнд:

- а) 2 дугаар зүйл (Нэр томъёоны тодорхойлолт)-ийн 1 дэх хэсгийн а) заалт;
- б) 3 дугаар зүйл (Ил тод этгээдүүд)-ийн 6 дахь хэсэг;
- с) 4 дүгээр зүйл (Байнга оршин суугчийн давхар харьяалалтай этгээд)-ийн 4 дэх хэсэг;
- д) 5 дугаар зүйл (Татварын давхардлыг арилгах аргуудыг хэрэглэх)-ийн 10 дахь хэсэг;
- е) 6 дугаар зүйл (Хамаарах татварын гэрээний зорилго)-ийн 5, 6 дахь хэсэг;



f) 7 дугаар зүйл (Гэрээг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх)-ийн 17 дахь хэсэг;

g) 8 дугаар зүйл (Ногдол ашиг шилжүүлэх ажил гүйлгээ)-ийн 4 дэх хэсэг;

h) 9 дүгээр зүйл (Этгээдийн үндсэн үнэлгээ нь үл хөдлөх хөрөнгөөс гаралтай хувь оролцоо, эсхүл хувьцаа шилжүүлснээс олсон хөрөнгийн орлого)-ийн 7, 8 дахь хэсэг;

i) 10 дугаар зүйл (Гуравдагч улсад байрлах төлөөний газрыг урвуулан ашиглахын эсрэг дүрэм)-ийн 6 дахь хэсэг;

j) 11 дүгээр зүйл (Өөрийн оршин суугчид татвар ногдуулах аль нэг Оролцогч талын эрхийг хязгаарласан татварын гэрээг хэрэглэх)-ийн 4 дэх хэсэг;

k) 12 дугаар зүйл (Төлөөлөн гүйцэтгэгчээр болон төстэй аргаар төлөөний газар үүсгэхээс хиймлээр зайлсхийх)-ийн 5, 6 дахь;

l) 13 дугаар зүйл (Тодорхой үйл ажиллагаанд хамаарах татварын чөлөөлөлтийг ашиглах замаар төлөөний газар үүсгэхээс санаатайгаар зайлсхийх)-ийн 7, 8 дахь хэсэг;

m) 14 дүгээр зүйл (Гэрээ хуваах)-ийн 4 дэх хэсэг;

n) 16 дугаар зүйл (Харилцан тохиролцох ажиллагаа)-ийн 6 дахь хэсэг;

o) 17 дугаар зүйл (Харилцан тохируулга хийх)-ийн 4 дэх хэсэг;

p) 18 дугаар зүйл (6 дугаар бүлгийг хэрэглэх хувилбар);


q) 23 дугаар зүйл (Арбитрын ажиллагааны төрөл)-ийн 4 дэх хэсэг;

r) 24 дүгээр зүйл (Зөрүүтэй шийдвэр дээр тохиролцох)-ийн 1 дэх хэсэг;

s) 26 дугаар зүйл (Тохирох байдал)-ийн 1 дэх хэсэг; ба

t) 35 дугаар зүйл (Хүчин төгөлдөр үйлчлэх)-ийн 1, 2, 3, 5, болон 7 дахь хэсэг.

2. 27 дугаар зүйл (Гарын үсэг зурах, соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх эсхүл батлах)-ийн 1 дэх хэсгийн b) эсхүл c)-д заасны дагуу аль нэг улс, эсхүл нутаг дэвсгэр нь конвенцын Оролцогч тал биш тохиолдолд аль нэг Оролцогч тал олон улсын харилцааг нь хариуцдаг тухайн улс, эсхүл нутаг дэвсгэр, эсхүл түүний нэрийн өмнөөс байгуулсан Хамаарах татварын гэрээтэй холбогдох мэдэгдлийг тэр хариуцсан Оролцогч тал хийх бөгөөд мэдэгдэл нь түүний өөрийн Хамаарах татварын гэрээнд хийсэн мэдэгдлээс ялгаатай байж болно.



3. Мэдэгдэл агуулсан баримт бичигт мэдэгдлийг эцсийн гэж тооцохоор тодорхой зааснаас бусад тохиолдолд 35 дугаар зүйл (Хүчин төгөлдөр үйлчлэх)-ийн 7 дахь хэсгийн дагуу болон энэ зүйлийн 5, 6 дугаар хэсгийн дагуу гарын үсэг зурах үед хийсэн тайлбарыг соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, эсхүл баталсан тухай Батламж бичгийг хадгалуулахдаа баталгаажуулна.

4. Гарын үсэг зурах үед мэдэгдэл хийгээгүй бол энэ үед төлөвлөж буй мэдэгдлүүдийн урьдчилсан жагсаалтыг гаргаж өгнө.

5. Аливаа Оролцогч тал 2 дугаар зүйл (Нэр томъёоны тодорхойлолт)-ийн 1 дэх хэсгийн а)-гийн ii)-гийн дагуу мэдэгдсэн гэрээний жагсаалтаа эх хадгалагчид мэдэгдэл хүргүүлэх замаар өргөжүүлж болно.

Энэхүү мэдэгдэлд тухайн Оролцогч тал 28 дугаар зүйл (Тайлбар)-ийн 8 дахь хэсэгт жагсаасан, түүний хийсэн аливаа тайлбарт тухайн гэрээ хамаарч байгаа эсэхийг тусгайлан заана.

Тухайн нэмэлт гэрээг жагсаалтад оруулсныг тусгах зорилгоор тухайн Оролцогч тал нь энэ зүйлийн эсгийн b)-гээс s) хүртэлх дэд заалтуудын дагуу шаардлагатай аливаа нэмэлт мэдэгдлийг хийнэ.

Мөн түүнчлэн, аль нэг Оролцогч тал олон улсын харилцааг нь хариуцдаг аль нэг улс, эсхүл нутаг дэвсгэрийн нэрийн өмнөөс, эсхүл тэдгээрийн байгуулсан татварын гэрээг анх удаа жагсаалтад оруулж, өргөтгөж байгаа бол тухайн улс, эсхүл нутаг дэвсгэрийн нэрийн өмнөөс, эсхүл тэдгээрийн байгуулсан Хамаарах татварын гэрээнд хэрэглэх мэдэгдэл (энэ зүйлийн 2 дахь хэсгийн дагуу), эсхүл аливаа тайлбар (28 зүйл (Тайлбар)-ийн 4 дэх хэсэг хэсгийн дагуу)-ыг тухайн Оролцогч тал хийнэ.

2 дугаар (Нэр, томъёоны тодорхойлолт) зүйлийн 1 дэх хэсгийн а) заалтын ii)-т заасны дагуу нэмэлт гэрээ (гэрээнүүд)-ийг мэдэгдсэн өдөр Хамаарах татварын гэрээ болж, 35 дугаар (Хүчин төгөлдөр үйлчлэх)-ийн зохицуулалтад заасан өдөр тухайн Хамаарах татварын гэрээний өөрчлөлтүүд хүчин төгөлдөр үйлчилнэ.

6. Аливаа Оролцогч тал нь эх хадгалагчид мэдэгдэл хүргүүлэх замаар энэ зүйлийн 1 дэх хэсгийн b)-гээс s) хүртэлх дэд заалтын дагуу нэмэлт мэдэгдэл хийж болно. Эдгээр мэдэгдлүүд нь дараах байдлаар дагаж мөрдөнө:

а) Хадгалагч дараах нэмэлт мэдэгдлийг хүлээн авсан үед зөвхөн энэ конвенцын Оролцогч тал болох улс эсхүл бүс нутагтай хийсэн Хамаарах татварын гэрээтэй холбогдуулан:

i) Нэмэлт мэдэгдлийг хадгалагч мэдэгдсэн өдрөөс эхлэн хуанлийн зургаан сарын хугацаа өнгөрсний дараа дараагийн жилийн 1 дугаар сарын 1-ний өдөр, эсхүл түүнээс хойш эх үүсвэрээс суутгах татвар



ногдуулах нөхцөл үүссэн тохиолдолд ийм төрлийн татварын талаарх зохицуулалтад холбогдох мэдэгдлийн хувьд; мөн

ii) Нэмэлт мэдэгдлийг хадгалагч мэдэгдсэн өдрөөс эхлэн хуанлийн зургаан сарын хугацаа өнгөрсний дараа дараагийн жилийн 1 дүгээр сарын 1-ний өдөр, эсхүл түүнээс хойших татварын жилд ногдуулсан татваруудад зориусан бусад бүх зохицуулалтад холбогдох мэдэгдлийн хувьд; мөн

b) Хадгалагч нэмэлт мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш нэг, эсхүл түүнээс дээш Хэлэлцэн тохирогч улс нь энэ конвенцын Оролцогч тал болсон Хамаарах татварын гэрээнд тухайн Хэлэлцэн тохирогч улс тус бүрийн хувьд конвенц хүчин төгөлдөр болсон хамгийн сүүлчийн өдөр.

30 дугаар зүйл

Хамаарах татварын гэрээний дараа дараагийн өөрчлөлтүүд

Энэ конвенцын заалтууд нь Хэлэлцэн тохирогч улс хооронд харилцан тохиролцох замаар Хамаарах татварын гэрээнд оруулсан дараа дараагийн нэмэлт, өөрчлөлтийг хөндөхгүй.

31 дүгээр зүйл


Оролцогч талуудын бага хурал

1. Оролцогч талууд энэхүү конвенцын заалтын дагуу аливаа шийдвэр гаргах, эсхүл шаардлагатай, эсхүл зорилгод нийцсэн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор Оролцогч талуудын бага хурлыг хуралдуулж болно.
2. Хадгалагч Оролцогч талуудын бага хурлыг зохион байгуулна.
3. Аливаа Оролцогч тал нь хадгалагчид хүсэлт хүргүүлэх замаар Оролцогч талуудын бага хурлыг хуралдуулах хүсэлт гаргаж болно. Хадгалагч нь аливаа хүсэлтийг бүх Оролцогч талуудад мэдэгдэнэ. Хадгалагч хүсэлтийг мэдэгдсэнээс хойш хуанлийн зургаан сарын дотор Оролцогч талуудын гуравны нэг нь хүсэлтийг дэмжсэн тохиолдолд хадгалагч нь Оролцогч талуудын бага хурлыг зарлан хуралдуулна.

32 дугаар зүйл

Тайлбарлах болон хэрэгжүүлэх

1. Энэ конвенцын хүрээнд Хамаарах татварыг гэрээнд орсон өөрчлөлтүүдтэй холбогдуулан тухайн гэрээг тайлбарлах, эсхүл хэрэгжүүлэхтэй холбоотойгоор үүссэн аливаа асуудлыг тухайн гэрээний харилцан тохиролцох ажиллагааны дагуу гэрээг тайлбарлах эсхүл хэрэгжүүлэхэд үүсэх асуудлыг шийдвэрлэх заалтуудаар (тэдгээр заалтыг энэхүү Конвенцоор өөрчилж болох тул) зохицуулна.



2. Энэ конвенцыг тайлбарлах эсхүл хэрэгжүүлэхтэй холбоотойгоор үүссэн аливаа асуудлыг 31 дүгээр зүйл (Оролцогч талуудын бага хурал)-ийн 3 дахь хэсэгт заасны дагуу Оролцогч талуудын бага хурлаар хэлэлцэж болно.

33 дугаар зүйл

Нэмэлт, өөрчлөлт оруулах

1. Аливаа Оролцогч тал нь хадгалагчид нэмэлт, өөрчлөлт оруулах хүсэлт гаргаснаар энэхүү конвенцод нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргаж болно.

2. Энэхүү нэмэлт, өөрчлөлтийн саналыг хянах зорилгоор энэ конвенцын 31 дүгээр зүйл (Оролцогч талуудын бага хурал)-ийн 3 дахь хэсэгт заасны дагуу Оролцогч талуудын бага хурлыг зарлан хуралдуулж болно.

34 дүгээр зүйл

Хүчин төгөлдөр болох

1. Энэ конвенц нь 50 дахь батламж жуух бичиг, хүлээн зөвшөөрсөн буюу батласан баримт бичгийг хадгалуулахаар өгсөн өдрөөс хойш хуанлийн гурван сарын дараах сарын эхний өдөр хүчин төгөлдөр болно.

2. 50 дахь батламж жуух бичиг, хүлээн зөвшөөрсөн буюу батласан баримт бичгийг хадгалуулсны дараа Гарын үсэг зурсан тал бүрийн хувьд энэ конвенц нь Гарын үсэг зурсан тал соёрхон баталсан батламж жуух бичиг, хүлээн зөвшөөрсөн буюу батласан баримт бичгээ хадгалуулсан өдрөөс хойш хуанлийн гурван сарын дараах сарын эхний өдөр хүчин төгөлдөр болно.


35 дугаар зүйл

Хүчин төгөлдөр үйлчлэх

1. Энэхүү конвенц нь Хамаарах татварын аль нэг гэрээтэй холбогдуулан Хэлэлцэн тохирогч улс бүрт хүчин төгөлдөр үйлчилнэ:

а) Хамаарах татварын гэрээний Хэлэлцэн тохирогч улс бүрийн хувьд энэ конвенц хүчин төгөлдөр болсон өдрүүдийн хамгийн сүүлчийн өдөр эхлэх, эсхүл тэр өдрөөс хойш дараах хуанлийн жилийн эхний өдөр, эсхүл түүнээс хойш эх үүсвэрээс суутгасан татвар ногдуулах нөхцөл үүссэн тохиолдолд оршин суугч биш этгээдийн төлсөн, эсхүл түүнээс нэхэмжилсэн хэмжээгээр эх үүсвэрээс суутгасан татварын хувьд; ба

б) Хамаарах татварын гэрээний Хэлэлцэн тохирогч улс бүрийн хувьд энэ конвенц хүчин төгөлдөр болсон хамгийн сүүлчийн өдрөөс хойших хуанлийн зургаан сар (эсхүл Хэлэлцэн тохирогч бүх улс богино хугацааг хэрэглэхээр төлөвлөж буйгаа эх хадгалагчид мэдэгдсэн бол тухайн богино хугацаа)-ын хугацаа өнгөрснөөс эхлэх, эсхүл түүнээс хойших татварын жилийн хүрээнд Хэлэлцэн тохирогч улсаас ногдуулсан аливаа бусад татварын хувьд.



2. Аль нэг Оролцогч тал нь энэ зүйлийн 1 дэх хэсгийн а) болон 5 дахь хэсгийн а)-г зөвхөн өөртөө хэрэглэх зорилгоор “хуанлийн жил”-ийг “татварын жил ногдуулах хугацаа”-ээр сольж болох бөгөөд энэ тухайгаа эх хадгалагчид мэдэгдэнэ.

3. Аль нэг Оролцогч тал нь энэ зүйлийн 1 дэх хэсгийн б) болон 5 дахь хэсгийн б)-г зөвхөн өөртөө хэрэглэх зорилгоор «хугацаа дуусахад, эсхүл дууссаны дараа эхлэх татварын жил» гэсэн хэсгийг «хугацаа дуусахад, эсхүл дуусаны дараах жилийн 1 дүгээр сарын 1-ний өдөр, эсхүл түүнээс хойш эхлэх татварын жил» гэсэн хэсгээр солихоор сонгож болох бөгөөд энэ тухайгаа эх хадгалагчид мэдэгдэнэ.

4. Энэхүү зүйлийн 1-ээс 3 дахь хэсгийн зохицуулалтад харшлахгүйгээр 16 дугаар зүйл (Харилцан тохиролцох ажиллагаа) нь Хэлэлцэн тохирогч улс бүрийн хувьд энэ конвенц хүчин төгөлдөр болсон хамгийн сүүлчийн өдөр, эсхүл өдрөөс хойш эрх бүхий байгууллагуудын аль нэгэнд Хамаарах татварын гэрээтэй холбогдуулан гаргасан, энэхүү конвенцоор өөрчлөлт оруулахаас өмнө Хамаарах татварын гэрээний дагуу тухайн өдөр хүртэл гаргах боломжгүй байсан гомдлуудаас бусад гомдолд, түүнд хамаарах татварын жилээс үл хамааран хүчин төгөлдөр үйлчилнэ.


5. Энэ конвенцын 29 дүгээр зүйл (Мэдэгдэл хийх)-ийн 5 дахь хэсэгт заасны дагуу 2 дугаар зүйл (Нэр томъёоны тодорхойлолт)-ийн 1 дэх хэсгийн а)-гийн ii)-ын дагуу мэдэгдсэн хэлэлцээрүүдийн жагсаалтыг өргөжүүлснээс үүдэлтэй аливаа шинэ Хамаарах татварын гэрээний хувьд энэхүү конвенц нь Хэлэлцэн тохирогч улс бүрийн нутаг дэвсгэрт дараах байдлаар хүчин төгөлдөр үйлчилнэ. Үүнд:

а) Гэрээний жагсаалтын өргөтгөлийн мэдэгдлийн тухай эх хадгалагчид мэдэгдсэн өдрөөс хойш 30 дахь өдөр, эсхүл өдрөөс хойш эхлэх дараагийн хуанлийн жилийн эхний өдөр, эсхүл түүнээс хойш эх үүсвэрээс нь суутгах татвар ногдуулах нөхцөл үүссэн бол оршин суугч биш этгээдийн төлсөн, эсхүл түүнээс нэхэмжилсэн хэмжээгээр суутгах татварын хувьд; ба

б) Гэрээний жагсаалтын өргөтгөлийн мэдэгдлийн тухай эх хадгалагчид мэдэгдсэн өдрөөс хуанлийн есөн сар (эсхүл Хэлэлцэн тохирогч бүх улс богино хугацааг хэрэглэхээр төлөвлөж буйгаа эх хадгалагчид мэдэгдсэн бол тухайн богино хугацаа)-ын хугацаа өнгөрснөөс, эсхүл түүнээс хойш эхлэх татварын жилийн хүрээнд Хэлэлцэн тохирогч улсаас ногдуулсан аливаа бусад татварын хувьд.

6. Аль нэг Оролцогч тал нь өөрийн Хамаарах татварын гэрээнд энэ зүйлийн 4 дэх хэсэг хэрэглэхгүй байх эрхтэй.

7. а) Аль нэг Оролцогч тал нь солих эрхтэй:



дуусгасан тухай 35 дугаар зүйл (Хүчин төгөлдөр үйлчлэх)-ийн 7 дахь хэсэгт заасан тайлбарыг хийж буй Хэлэлцэн тохирогч улс бүрээс гаргасан мэдэгдлийн сүүлчийн мэдэгдлийг хадгалагч хүлээн авсан өдрөөс хойш 30 дахь хоног” гэсэн хэсгээр; мөн

viii) 36 дугаар зүйл (6 дугаар бүлэг хүчин төгөлдөр үйлчлэх)-ийн 3 дахь хэсгийн “гэрээний жагсаалтыг өргөжүүлсэн мэдэгдлийн тухай хадгалагч мэдэгдсэн өдөр” гэснийг;

ix) 36 дугаар зүйл (6 дугаар бүлэг хүчин төгөлдөр үйлчлэх)-ийн 4 дэх хэсгийн “тайлбарыг эгүүлэн авах мэдэгдлийн тухай хадгалагч мэдэгдсэн өдөр”, “тайлбар солих мэдэгдлийн тухай хадгалагч мэдэгдсэн өдөр” ба “тайлбарыг эсэргүүцэн эгүүлэн авах мэдэгдлийн тухай хадгалагч мэдэгдсэн өдөр” гэснийг; ба

x) 36 дугаар зүйл (6 дугаар бүлэг хүчин төгөлдөр үйлчлэх)-ийн 5 дахь хэсгийн “нэмэлт мэдэгдлийн тухай хадгалагч мэдэгдсэн өдөр” гэснийг;

“Хамаарах татварын холбогдох гэрээний хувьд 6 дугаар бүлэг (Арбитрын ажиллагаа) хүчин төгөлдөр үйлчлэхэд шаардлагатай дотоодын процедураа дуусгасан тухай 35 дугаар зүйл (Хүчин төгөлдөр үйлчлэх)-ийн 7 дахь хэсэгт заасан тайлбар хийсэн Хэлэлцэн тохирогч улс бүрийн гаргасан мэдэгдлийн хамгийн сүүлчийн мэдэгдлийг хадгалагч хүлээн авсан өдрөөс хойш 30 дахь хоног” гэсэн хэсгээр тус тус солино.

b) Энэ зүйлийн 7 дахь хэсгийн а)-д заасны дагуу тайлбар хийсэн аль нэг Оролцогч тал нь дотоодын процедураа дуусгасан болохыг баталгаажуулж хадгалагч болон бусад Хэлэлцэн тохирогч улсуудад нэгэн зэрэг мэдэгдэнэ.

c) Энэ хэсгийн дагуу нэг, эсхүл түүнээс дээш Хэлэлцэн тохирогч улс тайлбар хийсэн бол энэ конвенцын, тайлбарыг эгүүлэн авсан, эсхүл солисон, тухайн Хамаарах татварын гэрээний нэмэлт мэдэгдлийн, эсхүл 6 дугаар бүлгийн (Арбитр) хүчин төгөлдөр болсон огноо нь Хамаарах татварын гэрээний Хэлэлцэн тохирогч бүх улсын хувьд энэ хэсгээр тодорхойлогдоно.

36 дугаар зүйл

6 дугаар бүлэг хүчин төгөлдөр үйлчлэх

1. Энэ конвенцын 28 дугаар зүйл (Тайлбар)-ийн 9 дэх хэсэг, 29 дүгээр зүйл (Мэдэгдэл хийх)-ийн 6 дахь хэсэг, мөн 35 дугаар зүйл (Хүчин төгөлдөр үйлчлэх)-ийн 1-ээс 6 хүртэлх хэсгүүдэд заасанд харшлахгүйгээр аль нэг Хамаарах татварын гэрээний Хэлэлцэн тохирогч хоёр улсын хувьд 6 дугаар бүлэг (Арбитр)-ийн заалтууд нь хүчин төгөлдөр үйлчилнэ:

а) Аль нэг Хэлэлцэн тохирогч улсын эрх бүхий байгууллагад гаргасан (19 дүгээр зүйл (Арбитрын шийдвэрийг заавал дагаж мөрдөх нөхцөл)-ийн 1 дэх

Монгол Улсын Гадаад харилцааны яам
АЛБАН ЁСНЫ ОРЧУУЛГА МӨН 59

Гарын үсэг /Signature: *M.C.*

2023 оны 10 сарын 16 өдөр
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs of Mongolia
OFFICIAL TRANSLATION

хэсгийн а)-д заасан) гомдлын хувьд Хамаарах татварын гэрээний Хэлэлцэн тохирогч улс бүрт энэ конвенц хүчин төгөлдөр болсон сүүлийн өдөр, эсхүл түүнээс хойш; ба


б) Энэ конвенц нь Хамаарах татварын гэрээний Хэлэлцэн тохирогч улсуудад хүчин төгөлдөр болох сүүлчийн өдрөөс өмнө аль нэг Хэлэлцэн тохирогч улсын эрх бүхий байгууллагад гаргасан гомдлын хувьд Хэлэлцэн тохиролцогч хоёр улс 19 дүгээр зүйл (Арбитрын шийдвэрийг заавал дагаж мөрдөх нөхцөл)-ийн 10 дахь хэсэгт заасны дагуу харилцан тохиролцоонд хүрсэн гэдгээ, энэ харилцан тохиролцооны нөхцөлийн дагуу Хэлэлцэн тохирогч улсын эрх бүхий байгууллагад (19 дүгээр зүйл (Арбитрын шийдвэрийг заавал дагаж мөрдөх нөхцөл)-ийн 1 дэх хэсгийн а)-д заасан) гомдол гаргасан гэж үзэх тодорхой өдөр, эсхүл өдрүүдийн мэдээллийн хамт эх хадгалагчид мэдэгдсэн өдөр.

2. Аливаа Оролцогч тал нь 6 дугаар бүлгийг (Арбитрын ажиллагаа) энэ конвенц Хэлэлцэн тохирогч улсуудын хувьд хүчин төгөлдөр болсон сүүлийн өдрөөс өмнө Хэлэлцэн тохирогч талуудын эрх бүхий байгууллагад гаргасан, 6 дугаар бүлгийг хэрэглэхээр Хэлэлцэн тохиролцогч улсуудын эрх бүхий байгууллагууд харилцан тохиролцсон гомдлын хүрээнд зөвхөн хэрэглэнэ гэж тайлбар хийх болно.

3. Энэ конвенцын 2 дугаар зүйл (Нэр томъёоны тодорхойлолт)-ийн 1 дэх хэсгийн а)-гийн ii)-ын дагуу мэдэгдсэн 29 дүгээр зүйл (Мэдэгдэл хийх)-ийн 5 дахь хэсэгт заасны дагуу гэрээний жагсаалтад нэмэгдсэн шинэ Хамаарах татварын гэрээний хувьд энэ зүйлийн 1 болон 2 дахь хэсэгт заасан "энэ конвенц нь Хамаарах татварын гэрээний Хэлэлцэн тохирогч улсуудад хүчин төгөлдөр болсон сүүлчийн өдрөөс" гэснийг "Гэрээний жагсаалтыг өргөтгөлийн мэдэгдлийн тухай хадгалагч мэдэгдсэн өдөр" гэсэн хэсгээр солино.

4. 26 дугаар зүйл (Тохирох байдал)-ийн 4 дүгээр хэсгийн дагуу хийсэн тайлбарыг 28 дугаар зүйл (Тайлбар)-ийн 9 дэх хэсгийг үндэслэн эгүүлэн авсан, эсхүл сольсон, эсхүл аль нэг Хамаарах татварын гэрээний Хэлэлцэн тохирогч хоёр улс хооронд 6 дугаар бүлэг (Арбитрын ажиллагаа)-ийг хэрэглэхэд хүргэж буй 28 дугаар зүйл (Тайлбар) –ийн 2 дахь хэсгийн дагуу хийсэн тайлбарын эсрэг эсэргүүлцлийг эгүүлэн авсан нь "Хэлэлцэн тохирогч улс бүрийн хувьд энэ конвенц хүчин төгөлдөр болсон хамгийн сүүлчийн өдөр" гэснийг "Тайлбар эсрэг эсэргүүцэл гаргасныг эгүүлэн авсан мэдэгдлийн тухай хадгалагч мэдэгдсэн өдөр", эсхүл "Тайлбарыг сольсон мэдэгдлийн тухай хадгалагч мэдэгдсэн өдөр", эсхүл "Тайлбарыг эгүүлэн авсан мэдэгдлийн тухай хадгалагч мэдэгдсэн өдөр" гэснээр тус тус сольсноос бусад тохиолдолд энэ зүйлийн 1 дэх хэсгийн а) болон б) –гийн дагуу хүчин төгөлдөр үйлчилнэ.

5. Энэ зүйлийн 1 болон 2 дахь хэсэгтэй холбогдолтой "Хамаарах татварын гэрээний хэлэлцэн тохирогч улс тус бүрийн хувьд энэхүү конвенц хүчин төгөлдөр болсон хамгийн сүүлчийн өдөр" гэсэн хэсгийг "Нэмэлт мэдэгдлийн тухай хадгалагч мэдэгдсэн өдөр" гэсэн хэсгээр сольсноос бусад тохиолдолд 29 дүгээр зүйл



(Мэдэгдэл хийх)-ийн 1 дэх хэсгийн 16-д заасны дагуу гаргасан аль нэг нэмэлт мэдэгдэл нь 36 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн а) болон б) хэсэгт заасны дагуу хүчин төгөлдөр үйлчилнэ.

37 дугаар зүйл
Конвенцоос гарах


1. Аливаа Оролцогч тал нь хадгалагчид мэдэгдэл хүргүүлснээр энэ конвенцоос ямар ч үед гарч болно.
2. Хадгалагч мэдэгдлийг хүлээн авснаар энэ зүйлийн 1 дэх хэсгийн дагуу гаргасан гарах хүсэлт нь хүчин төгөлдөр болно. Аль нэг Оролцогч талын конвенцоос хүчин төгөлдөр гарсан өдрөөс өмнө энэ конвенц Хамаарах татварын гэрээний Хэлэлцэн тохирогч бүх улс орнуудад хүчин төгөлдөр болсон тохиолдолд тухайн Хамаарах татварын гэрээ нь энэхүү конвенцын дагуу өөрчлөгдсөн хэвээр үлдэнэ.

38 дугаар зүйл
Протоколын талаар

1. Энэхүү конвенц нь нэг, эсхүл түүнээс дээш хавсралт протоколтой байж болно.
2. Аль нэг Улс, эсхүл нутаг дэвсгэр протоколд Оролцогч тал болохын тулд энэ конвенцын Оролцогч тал байх ёстой.
3. Энэ конвенцын аливаа Оролцогч тал протоколын дагуу түүний Оролцогч тал болсноос бусад тохиолдолд протоколыг заавал биелүүлэх үүрэг хүлээхгүй.

39 дүгээр зүйл
Хадгалагч

1. Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга нь 38 дугаар зүйл (Протоколын талаар)-ийн дагуу аливаа протоколуудын болон энэ конвенцын хадгалагч болно.
2. Хадгалагч нь Оролцогч талууд болон гарын үсэг зурсан Оролцогч талуудад хуанлийн нэг сарын дотор дараахыг мэдэгдэнэ:
 - а) 27 дугаар зүйл (Гарын үсэг зурах, соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх эсхүл батлах)-ийн дагуу аливаа гарын үсэг зурсан тухай;
 - б) 27 дугаар зүйл (Гарын үсэг зурах, соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх эсхүл батлах)-ийн дагуу соёрхон баталсан тухай Батламж жуух бичиг, хүлээн зөвшөөрсөн буюу баталсан баримт бичгийг хадгалуулсан тухай;
 - в) 28 дугаар зүйл (Тайлбар)-ийн дагуу хийсэн аливаа тайлбар, тайлбар эгүүлэн авсан, эсхүл сольсон тухай;



d) 29 дүгээр зүйл (Мэдэгдэл хийх)-ийн дагуу аливаа мэдэгдэл, эсхүл нэмэлт мэдэгдлийн тухай;

e) 33 дугаар зүйл (Нэмэлт, өөрчлөлт оруулах)-ийн дагуу энэхүү конвенцод нэмэлт, өөрчлөлт оруулах саналын тухай;

f) 37 дугаар зүйл (Конвенцоос гарах)-ийн дагуу энэхүү конвенцоос гарах тухай; мөн

g) Энэхүү конвенцтой холбоотой аливаа бусад мэдэгдлүүд.

3. Хадгалагч нь дараах мэдээллийг агуулсан жагсаалтыг олон нийтэд ил болгоно:

a) Хамаарах татварын гэрээнүүд;

b) Оролцогч талуудын хийсэн тайлбарууд; болон

c) Оролцогч талуудын гаргасан мэдэгдлүүд.

ХЭМЭЭСНИЙГ НОТЛОН зохих ёсоор олгосон бүрэн эрхийн дор гарын үсэг зурагчид энэхүү конвенцод гарын үсэг зурцгаав.

Парис хотноо 2016 оны 11-р сарын 24-ний өдөр Англи болон Франц хэлээр тус бүр нэг хувь үйлдсэн бөгөөд Эдийн засгийн Хамтын ажиллагаа, Хөгжлийн Байгууллагын архивт хадгалагдаж буй эх бичвэр бүр адил хүчинтэй.

